ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2017 ОНЫ АРВАН ХОЁРДУГААР САР

Лиахона

Бид хэрхэн Түүнийг шүтэн биширэх вэ? х. 4, 10, 16

Нэрд гараагүй хөвгүүн, сонгогдсон үзмэрч, х. 20

Танд Сүмийнх биш мэт санагддаг уу? х. 28

Биднийг хамгаалдаг сайн мэдээний 7 зарчим, х. 34



1901-1918 оны хооронд Сүмийн ерөнхийлөгчөөр үйлчилсэн Жозеф Ф.Смит 80 настайдаа буюу нас барахаасаа нэг жилийн өмнө энэ зургийг авахуулсан. Эцэг Хайрум Смит нь 1844 онд Иосеф Смиттэй хамт алуулжээ. Жозеф Ф.Смитийг 1866 онд 27 настай байхад ерөнхийлөгч Бригам Янг төлөөлөгчөөр томилсон бөгөөд тэрээр Сүмийн дөрвөн ерөнхийлөгчийн зөвлөхөөр үйлчилсэн юм. Сүмийн ерөнхий эрх мэдэлтнээр 52 жил үйлчлэхдээ заасан олон зүйл нь Сайн мэдээний сургаал *нэртэй хэвлэгдэж байв. Тэрээр түүнчлэн* Сургаал ба Гэрээний *138-р хэсэгт цэдэглэгдсэн илчлэлтийг хүлээн авсан.*

Гэрэл зургийг Сүмийн түүхийн номын сангийн зөвшөөрлөөр нийтлэв

4

ЗАХИАСУУД

4 **Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Христийн мэндэлсний баяраар Христийг хайх нь**
Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф

7 **Айлчлагч багшийн захиас бичиг: Нэг нэгнийхээ ачаанаас үүрэлцэх хүсэлтэй байх нь**

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

10 **Дээдийн дээд Хаан Бурханы магтъя**
Ахлагч Роналд А.Расбанд

16 **Христийг төрөх үед болсон 14 үйл явдал**
Жессика Гриффит
Аврагчийг төрөхийн өмнөх болон төрсний дараа болсон үйл явдлыг судраас олж мэд.

20 **Иосеф Смит: Сул дорой байдлаас гарсан хүч**
Ахлагч Маркус Б.Нэш
Бид сул дорой байдлаа ухаарч ойлгон, Их Эзэнд өргөх үед гайхамшиг бошиглогч Иосеф Смитэд ирсний адил ирдэг.

28 **Бид илүү сайн байж чадна, 2-р хэсэг: Есүс Христийн Сүмд байр сууриа олох нь**
Бэтси Вандэнбэрг
Та энд хамааралддаггүй гэж хэзээ ч юм нэгэн удаа мэдэрч байсан уу? Иймэрхүү байдалд шийдэл олох хэд хэдэн арга зам байна.

34 **Есүс Христийн сайн мэдээ: Хоргодох газар ба хамгаалалт**
Жэтулио Волтэр Жагэр и Силва
Сургаал ба Гэрээнээс: бидний амьдралдаа хамгаалуулахаар амлагдсан долоон арга.

БУСАД ӨГҮҮЛЭЛ

8 **Аврагчийн арга барилаар заах нь: Гэр бүлийн ярилцлагаа үнэлж цэгнэх нь**
Даг Харт

40 **Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой**

44 **Итгэлийн хөрөг: Жозефин Сийр**

80 **Биднийг дахин уулзтал: Христийн үйл хэрэгт баатарлаг байх нь**
Ерөнхийлөгч Иосеф Смит

ХАВТСАН ДЭЭР
Христийн төрөлт, Брюс Хиксон Смит

ЗАЛУУЧУУДАД

48

46 **Авьяаслаг монголчууд**
По Ниэн (Филипэ) Чоу, Петра Чоу, Очиржавын Одгэрэл нар
Залуу найрал дуучид улс орондоо танигдаж, сайн мэдээг хуваалцахын тулд хэрхэн дуу хөгжим ашигласан бэ?

48 **Аврагчид өргөх миний бэлэг**
Чэрстан Пикстон
Би өөрийнхөө тухай бодохоо больж; ах, эгч, дүү нарынхаа тухай бодох хэрэгтэй болсон.

Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Сэжүүр: Сайн найз байхад тань Ариун Сүнс хэрхэн тусалж чадах вэ?

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД

50 **Итгэлээ сэргээсэн нь**
Дэвид Диксон
Тэ Ораноагийн гэрлэлэх хөрсөн байсан ч өнгөрсөн үеийнхээ нандин дурсамжаас санагалздаг байжээ.

52 **Христийн мэндэлсний баярын магтуу дууны гайхамшиг**
Дуулснаар ирсэн ер бусын адислалуудын тухай хоёр түүх

54 **Христийн мэндэлсний баяр номлогч болох хамгийн тохиромжтой үе байдгийн найман шалтгаан**
Шарлотт Ларкэбэл
Номлогч байх иймхялбар байна гэж хэн мэдэх вэ дээ?

58 **Зурагт хуудас: Түүнд зай гарга**

59 **Сүмийн удирдагчдын хариулт: Христийн мэндэлсний баярын жинхэнэ уур амьсгалыг хэрхэн мэдрэх вэ**
Ерөнхийлөгч Томас С.Монсон

60 **Асуулт, хариулт**
Би ямар нэгэн чухал зүйлийн төлөө залбирч байгаа болович хариултаа хүлээн авсан эсэхээ сайн мэдэхгүй байна. Би хэрхэн мэдэх вэ?

62 **Бидний орон зай**


54

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

76

64 **Христийн мэндэлсний баярын өмнөх орой ирсэн гийчин**
Холли К.Вортингтон
Өө, үгүй байлгүй дээ! Кларагийн жилийн хамгийн дуртай үдэш нурахаар байлаа.

66 **Зориг гарган, хуваалц!**
Ахлагч Пол Б.Пийпэр
Есүс Христийн талаар мэдэж авахад нь найз нөхдөдөө туслах уу?

67 **Сүмийн түүхэн дэх онцгой хүмүүс: Сүм өнөөдөр**

68 **Улаан тасалбар**
Дарси Жэнсэн Моррис
Матэо Есүс шиг сайн найз байхыг хүссэн. Тэр юу хийж чадах байсан бэ?

70 **Төлөөлөгчийн хариулт: Би наманчилснаар хэрхэн аз жаргалыг мэдрэх боломжтой вэ?**
Ахлагч Дэйл Г.Рэнланд

72 **Есүсийн сургаал**
Энэ бол Христийн мэндэлсний баяр хүртэл Есүсийн сургаалыг дагаж хийх хөгжилтэй арга юм.

74 **Дуу хөгжим: Түүнд зай гарга**
Ларри Хиллэр, Майкл Ф.Муди

75 **Бидний хуудас**

76 **Есүсийн тухай түүх: Есүс Бетлехемд төрөв**
Ким Вэбб Рэйд

79 **Будах хуудас**

2017 ОНЫ АРВАН ХОЁРДУГААР САР, 18, №6
ЛИАХОНА 14452 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг, Дийтр Ф.Угдорф

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, М.Рассэлл Баллард, Робэрт Д.Хэйлс, Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд

Эрхлэгч: Хюго И.Мартинэз
Туслах редакторууд: Рэндэлл К.Бэннэтт, Кэрол Ф.Макконки
Зөвлөхүүд: Бриэн К.Эштон, Бонни Х.Кордон, Бага Лигранд Р.Куртис, Эдуард Дюб, Шэрон Юбанк, Доналд Л.Холлструм, Даглас Д.Холмэс, Эрих В.Көпишкэ

Удирдах захирал: Питэр Ф.Эванс
Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг
Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон
Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр
Хэвлэлийн туслах: Крэмилда Амарал
Редакцийн баг: Мэрисса Дэннис, Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр, Гаррэт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Жон Рэйн Жэнсэн, Шарлотт Ларкэбэл, Майкл Р.Моррис, Салли Жонсон Одэкөрк, Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороү, Ричард М.Ромни, Минди Аннэ Сэлү, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер: Ж.Скотт Кнудсэн
Зураглал чимэглэлийн удирдагч: Тадд Р.Петрсон
Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрьюс, Фэй П.Андрус, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Эмили Чиэко Рэмингтон, Марк В.Робисон, Брэд Тиэри, К.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун
Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс
Хэвлэх баг: Ира Глэнн Адэйр, Жюли Бардэтт, Томас Ж.Кронин, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Дэрэк Ричардсон
Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис
Хуваарилалт хариуцсан захирал: Трой К.Вэллинга

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар иргүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин" буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын, свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга, украйн, унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2017 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн тухай мэдээлэл: Өөрөөр заагаагүй бол хувь хүмүүс *Лиахона* сэтгүүлээс арилжааны бус, хувьдаа (мөн Сүмийн дуудлагат ажилд) ашиглах зорилгоор материал хувилан авч болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй. Үзүүлэнгийн материалыг хэрэв зураг чимэглэлийн тухайд ямар нэг хязгаарлалт тогтоосон бол хуулбарлаж болохгүй. Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St., FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар иргүүлнэ үү.

For Readers in the United States and Canada: December 2017 Vol. 18 No. 6. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is $5.00 per year; Canada, $6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address must be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard, American Express) may be taken by phone. (Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.

Дэлхий даяарх уран бүтээлчдэд өгөх урилга

"Би ЭЗЭНий үйлсийг санана. Би эрт үеийн Таны гайхамшгуудыг үнэхээр санана. Би Таны бүх ажлыг тунгаан, Таны үйлсийг шимтэн бодно" (Дуулал 77:11–12).

ШИММЕЛБАЧИЙН ГЭРИЙН ХЭЭТЭЙ ДААВУУН БҮТЭЭЛЭГ, КРИСТА ШИММЕЛБАЧ; ШУУРГА-ЧИМЭЭГҮЙ, НАМД, ЖОРЖ КОКО СЭНТЭНГИЛО

Таныг Ютагийн Солт Лэйк Сити дэх Сүмийн түүхийн музейгээс ивээн тэтгэдэг 11 дэх удаагийн олон улсын уран бүтээлийн уралдаанд өөрийнхөө бүтээлийг илгээхэд урьж байна.

- Сэдэв: "Итгэл үнэмшлийн талаар тунгаан бодох нь," Дуулал 77:11–12-оос санаа авав. Уран бүтээлийн бүхий л арга барил, хэв маяг, соёл уламжлалыг харуулсан бүтээлүүдийг хүлээн авна.
- Илгээх огноо: 2018 оны 2-р сарын 1-нээс 6-р сарын 1 хүртэл.
- Нас: Оролцогчид 18 ба түүнээс дээш настай байх ёстой.
- Шагнал: 2018 оны 10-р сард шүүгчдийн шийдвэрээр шагналт байрыг танилцуулна. Сонгогдсон бүтээлүүдийг Сүмийн түүхийн музейд болон онлайнд байршуулах болно.

Нарийвчилсан дүрэм, шаардлага, онлайн бүртгэлийн талаарх мэдээллийг **lds.org/artcompetition**-оос авна уу.

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Аравны нэг, *34*
Ариун Сүнс, *34, 40, 60, 68*
Ариун сүмүүд, *34, 44, 67, 75*
Бошиглогчид, *20, 34, 67*
Бурхан Эцэг, *20, 28, 75*
Бэлгүүд, *41, 43, 48, 59*
Гэр бүл, *10, 52, 54*
Гэрлэлт, *34*
Гэрээнүүд, *7, 34, 44*
Даруу байдал, *20*
Дуулгавартай байдал, *34*
Дуу хөгжим, *10, 43, 46, 52, 74*
Есүс Христ, *4, 10, 16, 42, 43, 48, 58, 59, 72, 76, 79, 80*
Жишээ, *8, 62*
Заах, *8*
Залбирал, *20, 60*
Иосеф Смит, *20*
Итгэл, *4, 20, 28, 44, 50, 80*
Мормоны Ном, *20, 50, 63, 66, 67*
Мэргэн ухааны үг, *34*
Наманчлал, *28, 68, 70, 71*
Номлолын ажил, *34, 46, 48, 54, 64, 66*
Нөхөрлөл, *62, 68*
Судар судлах, *10, 72*
Сургаал ба Гэрээ, *34*
Сүмийн ирц, *28*
Үйлчлэл, *7, 10, 41, 42, 43, 52, 54, 75*
Үнэн, *44*
Үүрэг, *63, 68*
Христийн мэндэлсний баяр, *4, 10, 16, 40, 41, 42, 43, 48, 52, 54, 58, 59, 64, 72, 74, 76, 79*
Энэрэл, *7*
Эцэг эх болох нь, *8*

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх
Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРААР ХРИСТИЙГ ХАЙХ НЬ

Биднийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүний хувьд ойлгохыг хүсдэг бүх хүнд хандан, "Бид Христийг хайдаг" гэсэн гурван үгээр илэрхийлж болох цэгээс эхлэхийг би санал болгож байна.

Бид Түүнээс суралцах, Түүнийг дагах, Түүнтэй адил болохыг эрэлхийлдэг.

Бид бүтэн жилийн турш өдөр бүр Түүнийг хайдаг. Гэхдээ ялангуяа жилийн энэ Христийн мэндэлсний баяраар хайрт Аврагчийнхаа төрсөн өдрийг тэмдэглэж байхдаа зүрх сэтгэл маань урьд урьдынхаас илүү Түүн рүү хандлаг.

Христийн мэндэлсний баярыг тэмдэглэх бэлтгэл ажлын маань нэг хэсэг болгон хоёр мянган жилийн өмнө амьдарч байсан хүмүүс Аврагчийг ирэхэд хүлээн авахдаа хэр бэлтгэлтэй байсан тухай эргэцүүлэн бодоцгооё.

Хоньчид

Хоньчид "сүргээ манаад шөнө хээр хоноглож" байсан гэдгээс илүүг бид мэддэггүй.[1] Тэрхүү хоньчид амьжиргаагаа залгуулах гэж өдөр хоногийг өнгөрөөдөг сайшаагдах бодгалиуд шиг энгийн хүмүүс байсан байх магадлал тун өндөр.

Тэд нэгэн үед Христийг эрж хайхдаа тийм ч их идэвхийлээгүй байж болох ч тэнгэр нээгдэн, тэдэнд Христийг зарлан тунхаглахад зүрх сэтгэл нь өөрчлөгдсөн хүмүүсийг төлөөлж болох юм.

Тэд бол тэнгэр элчүүдийн өгүүлэхийг сонсоод, үзэхийг хүсэн, тэр даруй Бетлехем рүү явсан хүмүүс юм.[2]

Мэргэн хүмүүс

Мэргэн хүмүүс Бурханы Хүү Мессиагийн ирэхийг судалж байсан эрдэмтэн мэргэд байсан. Тэд судлаад, Түүний мэндлэхийг илтгэсэн шинж тэмдгүүдийг танин мэджээ. Тэд тэмдгүүдийг таниад, гэр орноо орхин, Иерусалим руу аялж, "Саяхан мэндэлсэн иудейчүүдийн Хаан хаана байна вэ?" гэж асууж явжээ.[3]

Христийн тухай тэдний мэдлэг цэвэр онолын мэдлэг төдий байгаагүй. Тэд Түүний төрөлтийг бэлгэдсэн тэмдгүүдийг хараад, үйлдсэн. Тэд Христийг олохоор замдаа гарсан.

Мэргэн хүмүүс Христийг судлахаар хайдаг, мэдлэгээр дамжуулан эрэлхийлдэг хүмүүсийг төлөөлж болох юм. Үнэний төлөө сэтгэл зүрхээ зориулсан нь тэднийг яваандаа Христийг хайж олон, Түүнийг Хаадын хаан, хүн төрөлхтний Аврагч хэмээн бишрэн шүтэхэд хүргэсэн.[4]

Симеон ба Анна

Симеон, Анна хоёр бол Ариун Сүнсээр дамжуулан Христийг эрэлхийлдэг хүмүүсийг төлөөлж болох юм. Энэ гайхамшигтай бодгалиуд чин сэтгэлээсээ шашин шүтдэг хүмүүс байсан бөгөөд мацаг барьж, залбирч, сүсэг бишрэлтэй, дуулгавартай амьдран, Бурханы Хүүгийн ирэх өдрийг хүсэн хүлээж байжээ.

Үнэнч, даруу, итгэлтэй тэд Аврагчийн ирэхийг тэвчээртэй ажиглаж байсан.

Яваандаа тэдний итгэлтэй байдал шагналаа хүртсэн юм. Мари, Иосеф хоёр хожим хүн төрөлхтний нүглийг Өөртөө авах хүүгээ тэдэнд танилцуулжээ.[5]

БАЯР БАЯСГАЛАН, НИГҮҮЛСЛИЙН ӨДӨР, САРА ВОДДОПС МОРГАНЫ БҮТЭЭЛ, СҮМИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

Нифайчууд болон леменчүүдийн дунд байсан итгэгчид

Шинэ Дэлхийн итгэгчид Аврагчийн төрөх шинж тэмдгүүдийг хэрхэн ажиглаж байсан тухай сэтгэл хөдөлгөм түүх Мормоны Номон дээр байдаг.

Христэд итгэж байсан хүмүүсийг элэглэн шоолж, хавчин хяхаж байсныг та нар санаж байгаа. Тэр үеийн хашир хүмүүс итгэгчдийг мунхаг мухар сүсэгт автсан хэмээн буруутгаж байсан. Үнэндээ, үл итгэгчид ил тод элэг доог хийснээс болж уг газар нутагт "агуу самуун" дэгдсэн байв (3 Нифай 1:7). Аврагч төрөх болно хэмээн итгэдэг байсан хүмүүсийг тэд дооглон тохуурхаж байжээ.

Аврагчид итгэдэг хүмүүсийн итгэл найдварыг нэгмөсөн үгүй хийхээр уур хилэн нь буцалж байв. Ийнхүү нэгэн цочирдмоор шийдвэр гарсан тухай Мормоны Номонд цэдэглэгдсэн байдаг.[6]

Тэр үед амьдарч байсан итгэгчид хэдийгээр бусад хүн өөрсөд рүү нь харж инээлдэн, ад шоо үзэн, доромжилж байсан ч Христийг эрэлхийлдэг хүмүүсийг төлөөлж байж болох юм. Тэд өөрсдийг нь боловсроогүй,

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Бид ерөнхийлөгч Угдорфын санал болгосноор хэрхэн Христийг илүү сайн эрэлхийлж болох вэ? Та зааж байгаа хүмүүсээ өөрсдөөсөө "Би хэрхэн Христийг эрэлхийлж байна вэ?" хэмээн асуухад урамшуулан дэмжиж болно. Тэднийг гэр бүлээрээ өдөр бүр судар судлах цагаараа хэрхэн Христийг эрэлхийлж байгаа талаараа хуваалцахад урь. Та зааж буй хүмүүстээ мөн Mormon.org-оос Христийн мэндэлсний баярын холбогдолтой видео бичлэг үзүүлж, Христийн сургаалыг дагаснаараа Түүнийг эрэлхийлэхийн тулд жил болгоны ийм боломжийг ашиглахад урьж болно.

харанхуй бүдүүлэг, гэнэн итгэмтгий хэмээн шоолох үед ч Христийг эрэлхийлдэг.

Гэвч бусдын үзэн ядалт жинхэнэ итгэгчдэд Христийг эрэлхийлэхэд нь саад болдоггүй.

Бид Есүс Христийг эрэлхийлдэг

Жилийн туршид, ялангуяа Христийн мэндэлсний баярын үеэр “Би Христийг хэрхэн эрэлхийлж байна вэ?” хэмээн өөрсдөөсөө дахин нэг асуух нь бидэнд тустай байж магадгүй.

Давид хаан амьдралынхаа хүнд хэцүү үед “Бурхан, Та бол миний Бурхан. Би Таныг чин сэтгэлээсээ хайх болой. . . . сэтгэл минь Танаар цангаж, махан бие минь Таныг хүсэн хүлээдэг” хэмээн бичжээ.[7]

Бурханыг хайх ийм хандлага нь Давидыг Бурханы зүрх сэтгэлийг дагадаг хүн гэж дүрсэлдгийн нэг шалтгаан байж болох юм.[8]

Бид Христийн мэндэлсний баярын үеэр мөн бүтэн жилийн турш энх амгалангийн Ханхүү, Израилийн Ариун Нэгэн болох хайрт Аврагчаа зүрх сэтгэл, бодгалиараа эрэлхийлж байх болтугай. Ийм хүсэл эрмэлзэл биднийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүний хувьд төдийгүй Христийн шавь нарын хувьд хэн гэдгийг маань тодорхойлж байдаг. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Лук 2:8.
2. Лук 2:15-ыг үзнэ үү.
3. Матай 2:1–2-ыг үзнэ үү.
4. Матай 2:11-ийг үзнэ үү.
5. Лук 2:22–38-ыг үзнэ үү.
6. 3 Нифай 1-ийг үзнэ үү.
7. Дуулал 63:1.
8. Үйлс 13:22-ыг үзнэ үү.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Есүсийг хүлээсэн нь

Олон хүн Есүс Христийн төрөхийг харуулдан хүлээж байв. Өнөөдөр бид Түүний дахин ирэхийг харуулдан хүлээж байна. Бид Есүсийн тухай судалж, Түүнийг дагаснаар бэлэн байж чадна. Та нар Есүсийг хэрхэн дагадаг вэ? Бодол санаагаа одод дээр бич.

ЕСҮСИЙГ ТӨРӨХ *ҮЕД ХОНЬЧИД БОЛОН МЭРГЭН ХҮМҮҮС ХАМТ БАЙСАН НЬ,* ФИЛЛИС ЛАК

Нэг нэгнийхээ ачаанаас үүрэлцэх хүсэлтэй байх нь

Энэ материалыг залбирч судлаад, юу хуваалцахаа мэдэхийн тулд сүнслэг өдөөлт эрэлхийл. Халамжийн нийгэмлэгийн зорилгыг ойлгох нь Бурханы охидыг мөнх амьдралын адислалуудад хэрхэн бэлтгэх вэ?

Итгэл гэр бүл халамж

"Бидний анхаарал халамж, урам дэм, тусламж дэмжлэг, тайтгаруулал, нинжин сэтгэл хэрэгтэй байгаа хамаатан садан, найз нөхөд, таньдаг, таньдаггүй хүмүүс эргэн тойронд чинь хаа сайгүй байгаа. Бид бол дэлхий дээрх Их Эзэний хүүхдүүдэд үйлчилж, тэднийг өргөх үүрэгтэй Түүний мутар болсон хүмүүс юм. Тэрээр бидний хүн нэг бүрд найдлага тавьдаг" хэмээн ерөнхийлөгч Томас С.Монсон хэлсэн.[1]

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг "Таныг Түүний Сүмд элсэх үед зүрх сэтгэлд тань маш том өөрчлөлт гарч эхэлсэн юм. Та гэрээ хийсэн, та мөн чанарыг тань өөрчилж эхлэх амлалт хүлээн авсан. . . .

. . . Та [бусдын] ачаа дарамт хөнгөн байж, тэднийг тайвшруулахад нь Их Эзэнд тусална хэмээн амласан. Та Ариун Сүнсний бэлэг хүлээн авахдаа тэдгээр ачааг хөнгөлөхөд туслах хүчийг хүлээн авсан билээ" хэмээн хэлсэн.[2]

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Жийн Б.Бингам "Бусдыг Аврагчийн адил өрөвч сэтгэл, итгэл найдвар, хайр энэрлээр харахын тулд бидэнд сайн мэдээний гэрэл хэрэгтэй. Бид бусдын зүрх сэтгэлийг бүрэн ойлгодог болж, энэ амьдралын туршид тэдний талаар энэрэнгүй сэтгэлээр бодож, ярьснызхаа хариуд нигүүлслийг хүлээн авсандаа талархах өдөр ирэх болно. . . .

Бид Аврагч Есүс Христтэй илүү адил болох гэж хичээж байх үедээ *бух хүний* сайжирч дээшилсэн байдлыг хүлээн зөвшөөрөх нь бидний үүрэг хариуцлага хийгээд давуу эрх юм" хэмээн хэлсэн.[3]

Бид нэг нэгнийхээ ачаанаас үүрэлцэж, гэрээнүүдээ сахих үедээ Есүс Христийн эдгээх хүч чадлыг илүү их ухамсарлан ойлгодог. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд "Цовдлолт ба Цагаатгалын төсөөлшгүй үнэ цэнийг авч үзэхэд, Тэр биднээс нүүр буруулахгүй гэдгийг би амлаж байна. Тэр гарах арга замыг төдийгүй өөдлөх арга замыг ч мэддэг учраас сүнсэндээ ядуу тэдэнд "Надад ирэгтүн" гэж хэлсэн. Тэр энэ замаар алхсан учраас үүнийг мэддэг. Тэрээр *зам* нь учраас замыг мэддэг" хэмээн хэлсэн билээ.[4]

Нэмэлт судрууд
Матай 25:40; Галат 6:2; Мозая 2:17; 18:8–9
reliefsociety.lds.org

ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон, "Их Эзэнд хайраар үйлчил," *Liahona,* 2014 оны 2-р сар, 4.
2. Хэнри Б.Айринг, "Тайтгаруулагч," *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 137.
3. Жийн Б.Бингам, "Би гэр орондоо сайн мэдээний гэрлийг авчирна," *2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 125-129.
4. Жэффри Р.Холланд, "Broken Things to Mend," *Liahona,* 2006 оны 5-р сар, 71.

Үүнийг эргэцүүлэн бод

Бусдын ачаанаас үүрэлцэж, гэрээнүүдээ сахих нь бусдыг эдгээх арга замыг Есүс Христэд хэрхэн нээж өгдөг вэ?

Гэр бүлийн ярилцлагаа

Бид хүүхдүүддээ сайн мэдээнээс илүү сайн суралцдаг болоход нь хэрхэн тусалж болох вэ?

Даг Харт

Хэсэг хугацааны өмнө эхнэр бид хоёр гэр бүлээрээ судар судлах, гэр бүлийн үдэш хийх, бүр төлөвлөөгүй байсан ч сайн мэдээнд төвлөрсөн ярилцлагыг ганцаарчлан хийх үеэр өсвөр үеийн зарим хүүхдийнхээ байнга гаргах болсон зан авирт санаа зовж эхэлсэн юм. Тэд зүгээр л царайгаа харуулах гэж ирэн, хааяа нэг л нүд рүү харж, асуултад нэг үгээр хариулах зэргээр суралцах хамгийн доод жишгийг дагаж байсан бөгөөд суралцах үйл явцад идэвхтэй оролцохгүй байв.

Тэд Ариун Сүнсний хүчээр бат бөх гэрчлэлтэй болж, хувь хүний хувьд гүн гүнзгий хөрвөгдөхийн тулд илүү их зүйл хийх хэрэгтэй гэдгийг бид мэдэж байв. Аврагч шавь нараа зүгээр нэг сонсох биш, Өөрийнхөө сургаалыг итгэл гарган хэрэгжүүлээсэй гэж хүсдэг (*Аврагчийн арга барилаар заах нь* [2016], 30-ийг үзнэ үү).

Нэгэн орой бид тэдэнтэй өөрсдийнхөө мэдрэмжийг хуваалцсан юм. Бид Сүнсээр удирдуулсан ярилцлага өрнүүлснээр тэдэнтэй зөвлөлдөх зорилготой байсан ч бидний ярилцлага тэр даруй зөвхөн нэг тал руу хазайсан лекц болон хувирсан. Хөвгүүд маань бидний захиасыг сонссон ч тэдний оюун санаа, зүрх сэтгэл өөрчлөгдөөгүй.

Үүнээс болж бидний санаа зовниж эхэлсэн учраас эхнэр бид хоёр хүүхдүүддээ сайн мэдээг илүү идэвх санаачилгатай судлахад нь туслан, бидний ярилцлага, лекцийн нөлөөгөөр үйлдэхийн оронд өөрсдөө үйлдэх урам зориг өгөх тухай бодож эхэлсэн. Асуултууд маань биднийг судрууд болон хожмын үеийн бошиглогчдын үгсийг мөн судлах, заахтай холбоотой Сүмийн бусад эх сурвалжийг судалснаар сурсан зүйл дээрээ тулгуурлан төлөвлөгөө гаргахад хүргэсэн юм. Манай төлөвлөгөөнд:

Хүүхдүүдээ гэр бүлийн ярилцлагын үеэр Ариун Сүнсийг эрэлхийлэхэд хөтөл

Хайр, хүндэтгэлийг бий болго. Хайр зүрх сэтгэлийг зөөллөдөг. Хайрын илэрхийлэл нь Ариун Сүнсний нөлөөнд хүүхдүүдээ бэлтгэхэд тусалдаг. Энэ нь мөн идэвхтэй, сүнслэг суралцах үйл явцад оролцох тэдний хүслийг нэмэгдүүлдэг. Хүүхдүүдийнхээ үзэл бодол, мэдрэмжийг үнэлж, сонссоноор тэднийг хүндэтгэх нь илүү аюулгүй байдлыг мэдэрч, мэдрэмжээ хуваалцах хүсэлтэй болоход тэдэнд тусална.

Сүнсээр заа. Хүүхдүүдээ анхааралтай ажиглаж, сонсох нь юуг хэлж буйг мөн, тэднийг суралцах явцдаа Ариун Сүнсний нөлөөг эрэлхийлэхэд хөтлөх ямар асуулт тавин, ямар урилга өгөхөө Сүнсээр ялган таниход биднийг бэлтгэх болно.

Бүх ярилцлагаа Бурханы үгээр бэхэл. Сайн мэдээний тухай бодол санаагаа бие биетэйгээ хуваалцах

Үлгэр жишээгээрээ удирдан чиглүүл. Хүүхдүүдээсээ хүсэн хүлээдэг арга замаараа сайн мэдээнээс суралцаж, амьдралдаа хэрэгжүүлэх нь ярилцлагын үеэр тэднийг Сүнсний дэмжлэг, удирдамжийг хүлээн авахуйц зохистой байлгахад бидэнд тусална.

Бид төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхээр хичээх явцдаа Ариун Сүнсний нөлөөг гэр бүлийн ярилцлагадаа урьж авчрахад дадлага, цаг хугацаа шаардагддаг гэдгийг сурч мэдэж байна. Бид сэтгэлээр унан, бууж өгөхөөс татгалздаг. Саяхан нэгэн орой 10 настай охин маань гэр бүлээрээ хамт уншиж байсан Мормоны Номын нэгэн шүлгээс сүнслэг өдөөлтийг мэдрэн, "Та нар яаж Ариун Сүнсээр суралцдаг юм бэ?" гэж чин сэтгэлээсээ асууж билээ. Би инээмсэглэсэн ба өөрсдийнхөө өсөж өсөж хөгжиж байгааг мэдэрсэн. ■

үнэлж цэгнэх нь

нь тустай ч судрууд болон хожмын үеийн бошиглогчдын үгс биднийг Сүнстэй илүү гүн, илүү хүчтэй холбодог (С ба Г 84:45-ыг үзнэ үү).

Аврагчийг сайн мэдээнд суурилсан бүхий л ярилцлагынхаа эх үндэс болго. Бидний ярилцаж буй зүйл Аврагч болон Түүний Цагаатгалтай мөн "Христийн сургаалын үндэс суурьтай" (Боид К.Пакэр, "The Mediator," *Ensign,* 1977 оны 5-р сар, 56) хэрхэн холбогдож байгааг хүүхдүүд маань ойлгох үед бидний ярилцлага утга учиртай, хүчирхэг болдог.

Сүнслэгээр өдөөгдсөн асуултууд тавь. Үр дүнтэй асуултууд нь Сүнсний тусламжтайгаар шууд судрууд болон бошиглогчдын үгсээс үнэн ба ойлголтыг хүлээн авахад хүүхдүүдийг маань хөтөлдөг. Ийм арга замаар судалсан аливаа зүйл тэднийн хувьд бид яг адил материалыг хамгийн сайнаараа тайлбарласнаас хавьгүй илүү утга учиртай санагддаг.

Гэр бүлийн гишүүдээ ярилцахад урь. Хүүхдүүд маань харж, бодож, мэдэрсэн зүйлээ өөрийнхөө үгээр илэрхийлэхдээ юуг, хэрхэн хэлэхийг мэдэхэд туслах Ариун Сүнсийг урьдаг. Энэ үйл явц нь Их Эзэний өөрсдөөс нь юуг суралцаж, мэдрээсэй гэж хүсэж байгааг илүү сайн ойлгож, мэдэхэд тэдэнд тусална.

Тэвчээртэй бай! Хүүхдүүд маань үнэн ба ойлголтыг зүрх сэтгэл, бодол санаанаасаа хайх үед нь Ариун Сүнс тэдэнтэй хамт ажиллах болно. Бид хувийн санаа бодол, өөрсдийнхөө шийдлүүдийг тулгах гэж яарснаар тэдэнд ийнхүү эрэл хайгуул хийхэд нь саад болдог. Ийм уруу таталтыг эсэргүүцэх хэрэгтэй.

Зохиогч нь Бразилийн Куритиба номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байна.

Аврагчийн арга барилаар заах нь шинэ заах гарын авлага өсвөр үеийнхэн болон хүүхдүүдэд заах зөвлөмжүүдийг багтаадаг. **Teaching.lds.org**-ийг үзнэ үү.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Роналд А.Расбанд

Дээдийн дээд Хаан Бурханыг магтъя

Бид Их Эзэнтэй хамт үйлдэж, Түүний хүссэнийг хийн, эргэн тойрон дахь хүмүүсээ өргөн дэмжих бүрдээ Тэр амьд мөн биднийг хайрладаг гэдгийн гэрч болдог.

Есүс Христийг Иудейн Бетлехемд төрөхөөс 700 жилийн өмнө бошиглогч Исаиа "Үзэгтүн! Нэгэн онгон бүсгүй хүүхэдтэй болж, хүү төрүүлээд, Түүнийгээ Иммануел гэж нэрлэнэ" (Исаиа 7:14) хэмээн тунхаглажээ.

Аврагчийг төрөхөөс 125 жилийн өмнө Хаан Бенжамин "тэрээр Есүс Христ, Бурханы Хүү, тэнгэр ба газрын Эцэг, эхлэлээс бүх зүйлийг Бүтээгч хэмээн нэрлэгдэх болно; мөн түүний эх Мариа гэгдэх болно" (Мозая 3:8) хэмээн бошигложээ.

Бяцхан Есүсийг төрөхөөс нэг өдрийн өмнө Нифайн хүү Нифай "маргааш бибээр дэлхийд ирэх болно" хэмээх дуу хоолойг сонсов (3 Нифай 1:13).

Дараагийн өдөр нь алс хол газар Христ хүү мэндэлсэн юм. Түүний эх Мариа дөнгөж төрсөн хүү рүүгээ, Эцэгийн маханбод дахь Төрсөн Ганц руу гайхан ширтэж байсан нь лавтай.

Бетлехемийг тойрон хүрээлсэн Иудейн толгодоор хоньчид хоноглож байлаа гэж Лук хэлсэн байдаг (Лук 2:8-ыг үзнэ үү). Эдгээр хоньчин Христийн төрөлтийн гэрч болох "шударга бөгөөд ариун хүмүүс" (Алма 13:26-г үзнэ үү) байсан юм.

"Гэнэт Эзэний тэнгэр элч тэдний өмнө зогсож, Эзэний цог жавхлан тэдний эргэн тойронд гийсэнд хоньчид үлэмжийн айдаст автжээ.

Тэнгэр элч тэдэнд—Бүү айгтун, харагтун, би бүх ард түмнийг үлэмж баярлуулах сайн мэдээг та нарт авчирлаа.

Өнөөдөр Давидын хотод Аврагч, Эзэн Христ та нарын төлөө мэндэллээ. . . .

Гэнэт өнөөх тэнгэр элчийн хамт олон тооны тэнгэрлэг дайчид үзэгдэж, Бурханыг магтан,—

ХРИСТ МЭНДЭЛСЭН НЬ, Н.С.ВЭЙТ

Дээр өндөрт алдар нь Бурханд байх болтугай, доор газарт амар тайван нь Түүний таалдыг олсон хүмүүст байх болтугай гэцгээв" (Лук 2:9–11, 13–14).

Иудейд энэхүү онцгой үйл явдлыг тэмдэглэж буй тэнгэрийг дүүргэх нэгэн гайхамшигт одны сүр жавхлан, тэнгэрээс найрал дуу эгшиглэж буй тэр мөчийг төсөөлөн бодоорой. Хоньчид тэжээлийн тэвшин дотор хэвтэж буй бяцхан хүүг харахаар "яаран" (Лук 2:16) явсан юм. Дараа нь тэд сонссон, үзсэн зүйлээ "мэдүүлсэн" (Лук 2:17) билээ.

Жил бүрийн Христийн мэндэлсний баяраар бид амьд Бурханы төрсөн Хүү Есүс Христ дэлхийн нэгэн өнцөгт буюу бидний нэрлэдгээр Ариун Газарт ирсэн гэдэг хоньчдын гэрчлэл дээр гэрчлэлээ нэмдэг.

Хоньчид хаадын Хааныг шүтэн биширэхээр малын хашаа руу хүндэтгэлтэйгээр явсан билээ. Бид Түүнийг энэ цаг үед хэрхэн шүтэн бишрэх вэ? Зогсолтгүй дэлгүүр хэсэж үү? Гэр орноо чимэглэн, бэлэг боох гэж сандран тэвдэж үү? Ийм маягаар бид Аврагчийг магтан дуулах уу? Эсвэл зовсон зүрх сэтгэлийг тайтгаруулан, тусламж илүү их хэрэгтэй байгаа хүмүүст сайныг үйлдэж, Бурханы таалдыг биелүүлэх хүслээрээ Түүнийг алдаршуулах уу?

Есүс үүнийг "Ирж, Намайг дага" (Лук 18:22) хэмээн энгийнээр хэлсэн байдаг.

Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн Есүс Христийн сайн мэдээ дэлхий даяарх итгэгчдийн сэтгэлийг татсаар ирсэн юм. Би Аврагчийн ариун нандин үгийг хүлээн авсан далайн арлуудаас Оросын өргөн уудам газар нутаг хүртэлх хүмүүсийн урам зоригийг нүдээрээ харсан.

Христийн мэндэлсний баярын захиас

Сионд цугларсан эртний гэгээнтнүүдийн дунд АНУ-ын Юта мужийн Спаниш Форкт суурьшсан Ханна Ласт Корнаби байлаа. Сэргээгдсэн Сүмийн эхэн үеийн хүнд хэцүү цагт Христийн мэндэлсний баярыг заримдаа амтат жүрж, сийлбэрлэсэн тоглоом эсвэл зөвхөн даавуун хүүхэлдэйгээр тэмдэглэдэг байлаа. Гэхдээ үргэлж тийм байгаагүй. Ханна 1856 оны 12-р сарын 25-ны талаар ингэж бичжээ.

"Христийн мэндэлсний баярын өмнөх өдөр болоход хонгорхон хүүхдүүд минь хүүхдийн гэнэн цайлган зангаараа оймсоо бэлгээр дүүрнэ гэж итгэн, хананд өлгөсөн юм. Сэтгэлийн гунигаа тэднээс нуун, тэд гар хоосон үлдэхгүй гэдгийг би тэдэнд баталж хэлсэн. Тэд маргаашийг тэсэн ядан хүлээн, баяр хөөртэйгөөр унтацгаав.

Өчүүхэн төдий ч амттан байгаагүй болохоор би юу хийхээ мэдэхгүй байлаа. Тэдний урмыг хугалж болохгүй байв. Би гэрт хулуу байгааг санаад буцалгаж, шүүсийг нь шахан, дахин хэдэн цаг буцалгасны дараа амттай шүүс бэлэн боллоо. Үүнийгээ бага зэрэг амтлагчтай холиод, цагаан гаатай жигнэмгийн зуурмаг бэлтгэн, байж болох бүх л хэвэнд оруулан, хайруулын тавганд жигнээд (надад зуух байгаагүй), тэдний оймсыг дүүргэсэн бөгөөд энэ тэдэнд хамгийн тансаг амттан шиг л таалагдаж билээ." [1]

Энэ түүхэнд ажил хөнгөвчлөх шарах зуух ч байхгүй байхад шөнөжин хөдөлмөрлөсөн ээжийн тухай гарч байна. Тэр хүүхдүүддээ баяр баясгаланг авчирч, тэдний итгэлийг хүчирхэгжүүлэн, "Жаргалтай өдөр! Бүх зүйл сайхан байна!"[2] гэдгийг гэр орондоо батлан харуулсан юм. Энэ л Христийн мэндэлсний баярын захиас биш гэж үү?

Ерөнхийлөгч Томас С.Монсон "Бидний өөрсдийгөө бусдад зориулах боломжууд хязгааргүй ч түр зуурынх байдаг. Баярлуулах зүрх олон байна. Хэлэх эелдэг үгс зөндөө байна. Өгөх бэлгүүд дүүрэн байна"[3] гэж заасан.

Бид мөнх бус амьдралд тохиолдох бэрхшээлээсээ үл хамааран Их Эзэнтэй хамт үйлдэж, Түүний хүссэнийг хийн, эргэн тойрон дахь хүмүүсээ өргөн дэмжих бүрдээ Тэр амьд бөгөөд биднийг хайрладаг гэдгийн гэрч болдог.

Шотланд гаралтай хөрвөгч Жон Мэнзийс Макфарлэйн бэлэвсэн ээж, дүүгийнхээ хамт Сүмд нэгдсэний дараа бүгдээрээ 1852 онд Юта мужийн Солт Лэйк Сити хот руу аялжээ. Тэр 18 настай байсан. Тэр газар хэмжигч, барилгачин, бүр дүүргийн шүүгч хүртэл хийж байсан ч зохиосон хөгжим нь түүнийг алдар нэртэй болгосон юм.

Тэр Юта мужийн Сидар Ситид анхныхаа найрал дууны чуулгыг зохион байгуулсан бөгөөд чуулгаа Ютагийн өмнөд хэсэг рүү авч явжээ. Сэнт Жорж дахь тоглолтын дараа төлөөлөгч, суурингийн удирдагч, ахлагч Ирастус Снөү (1818–1888) Жоныг Сэнт Жоржид гэр бүл болон хөгжмийнхөө хамт нүүж ирэхэд урамшуулсан байна.

1869 онд цаг үе хүнд байсан учраас ахлагч Снөү Макфарлэйн ахаас хүмүүсийн сэтгэлийг сэргээх Христийн мэндэлсний баярын хөтөлбөр гаргахыг хүсжээ. Макфарлэйн ах үйл явдалд зориулан шинэ, сонирхолтой хөгжим зохиохыг хүсэв. Гэхдээ тэр хэчнээн хичээсэн ч ямар ч санаа төрсөнгүй. Тэр удирдамж хүсэн ахин дахин залбирчээ.

Нэг орой тэр эхнэрээ сэрээгээд, "Би дууны үгийг нь олчихлоо. Бас хөгжим нь ч болчих шиг боллоо" гэж хэлсэн юм. Тэр зочны өрөөний бишгүүр хөгжмийнхөө



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДАГ ФАККЭЛ

даруул руу яаран очоод, аяа тоглож эхэлсэн бөгөөд эхнэрийгээ шар тостой цөгцөнд хөвөн шатаж буй үслэг даавуутай анивчсан гэрэл барин зогсох үед үгийг нь бичиж байв. Үг, ая урсан гарсаар байлаа.

Алс тэртээ хол Иудейн нутаг,
хээр талд
Эртний хоньчид баярын дууг сонсжээ.
Бурханыг магтъя
Бурханыг магтъя
Дээдийн дээд Хаан Бурханыг магтъя;
Ертөнц, хүмүүс амар байг!
Ертөнц, хүн бүгд амар байг![4]

Макфарлэйн ах уулархаг нутагтай Иудей руу хэзээ ч явж байгаагүй ч хөгжмийнх нь сүнслэг өдөөлт бүхий захиас Бетлехем дэх Аврагчийн төрөлтийг гэрчлэхээр бодгалиас нь урсан гарсан бөгөөд энэ нь дэлхийг үүрд мөнхөд өөрчлөх эхлэл байсан юм.[5]

Жон Мэнзийс Макфарлэйн хөгжмөөрөө дамжуулан Есүс Христийг гэрчилсэн бол Ханна Ласт Корнаби хүүхдүүддээ хийсэн үйлчлэлээрээ дамжуулан Христийг гэрчилсэн. Үүнтэй адил бид амин хувиа үл хичээсэн энгийн жижиг үйлсээр дамжуулан Их Эзэнд үйлчилж, Түүнийг гэрчилж чадна. Мөн бид гэр бүл, тойрог, ажлын газартаа болон өөр бусад үүрэг хариуцлагын хүрээн дотроо өөрчлөлт хийж чадна.

Өөрчлөлт хий

Бидний өөрчлөлт авчирч болох энгийн нэгэн арга бол Сүмийн жил тутмын Христийн мэндэлсний баярын олон нийтийн мэдээллийн хэрэгслийн аянд оролцох явдал юм. Энэхүү аян нь гэгээнтнүүдэд буюу дэлхий даяарх Бурханы хүүхдүүдэд Аврагчид төвлөрөхөд нь туслах зорилготой. Энэ жил Сүм Христийн төрөлтийг тэмдэглэн, хүмүүсийг Христийн мэндэлсний баяраар бусдад үйлчилснээр Түүнийг даган дуурайхад урамшуулахын тулд өөр нэгэн дэлхий дахины аяныг танилцуулж байна.

Эгч маань гоёмсог хээтэй бүтээлэг хийгээд, "Бүхнээс дээд эрхэм нэр" гэж нэрлэсэн. Энэ бүтээлэгт Есүс Христийн 26 нэрийг дүрсэлжээ.

Сүм “Дэлхийг гэрэлтүүл” хэмээх өнгөрсөн жилийн амжилттай уриагаараа дахин уриалж байна (Mormon.org-ыг үзнэ үү). Уг уриа нь “Тэгээд Есүс тэдэнд дахин—Би бол ертөнцийн гэрэл мөн. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно гэж айлдав” хэмээх Иохан 8:12-оос гаралтай юм.

Энэ аян нь Христийн мэндэлсний баяраар хийх зүйлсийн хуанли, Христийн гэрлийг бусдад түгээн, үйлчлэл хийх гэж байгаа хүмүүст санаа өгөх холбогдох судрын шүлгүүдийг багтаадаг.

“Бидний хүн нэг бүрийг дэлхий дээр ирэхэд Христийн гэрэл өгөгдсөн. Бид Аврагчийн үлгэр жишээг дагаж, Түүний хэрхэн амьдарч, заасанчлан амьдрах юм бол тэрхүү гэрэл бидний дотор асаж, бусдын явах ёстой замыг гэрэлтүүлэх болно.”[6]

Бид Аврагчийн хийснийг хийснээр Түүнийг таньж мэддэг. Бид бусдад үйлчилснээр тэднийг төдийгүй өөрийгөө Түүнд ойртуулдаг.

“Бүхнээс дээд эрхэм нэр”

Христийн мэндэлсний баярын үеэр би ач хүү Пакстоноо маш их санадаг. Пакстон ховор тохиолддог генийн өөрчлөлттэй төрсөн учраас маш их эрүүл мэндийн асуудалтай байсан. Пакстон амьдралыг маань адисалсан гуравхан жилд Тэнгэрлэг Эцэг бидний гэр бүлд олон онцгой, сайхан сургамжуудыг өгсөн.

Нэнси Шиндлэр эгч маань Пакстоны дурсгалд зориулж гоёмсог хээтэй бүтээлэг хийв. Тэр үүнийгээ “Бүхнээс дээд эрхэм нэр” гэж нэрлэсэн. Уг бүтээлэг Есүс Христийн 26 нэрийг дүрсэлсэн бөгөөд эдгээр нь А-аас Я хүртэлх бүх үсгээр эхэлсэн нэрс юм. Энэ бүтээлэг надад Аврагчийн зовлон шаналал, золиослол, Амилалтаар дамжуулан Пакстонтойгоо нэгдэх боломжтой болсон ирээдүйн нэгэн гайхамшигт гэр бүлийн цугларалтын тухай сануулдаг.

Мөн судруудад илчлэгдсэн Есүс Христийн нэрсийг судлахад надад сүнслэгээр нөлөөлсөн. Түүний нэрийг судлах нь миний хувиараа судраас судлах үйл явцын нэг хэсэг болсон билээ. Одоогоор би Аврагчийн зуу зуун нэрийг олж тогтоогоод байна.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүний хувьд мөн Сургаал ба Гэрээнд дурдсаны дагуу миний нэгэн үүрэг хариуцлага бол Есүс Христийг гэрчлэх явдал юм. Сургаал ба Гэрээнд “Аялагч арванхоёр зөвлөх нь Арванхоёр Төлөөлөгч, эсвээс бүх дэлхийд *Христийн нэрний тусгай гэрчүүд* байхаар дуудагддаг” гэж дурдсан байдаг (С ба Г 107:23; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Саяхан намайг Солт Лэйк Ситигийн Хүүхдийн эмнэлэгт болсон ариун ёслолын цуглаан дээр үг хэлэхийг хүссэн юм. Би Есүс Христ, Түүний итгэл найдвар төрүүлсэн нэрсийн тухай ярих сүнслэг өдөөлтийг хүлээн авсан. Би Аврагчийг “гэрэлт үүрийн цолмон” (Илчлэлт 22:16), “ирэх сайн юмсын Тэргүүн Тахилч” (Еврей 9:11), “жигүүрэндээ анагаах чадлыг эзэмдэн” боссон “гайхамшгуудын Бурхан” (2 Нифай 27:23; 25:13), “Энхийн Жонон” (Исаиа 9:6; 2 Нифай 19:6), “амилалт ба амь” (Иохан 11:25) мөн хэмээн гэрчилсэн юм.

Би Христийн мэндэлсний баярын үеэр Ариун сүмийн талбайн Христийн мэндэлсний баярын гэрлүүдийн хажуугаар ажлынхаа өрөө рүү алхах мөн буцаж явах бүрдээ Аврагчийн өөр өөр нэрсийг хэлэх дуртай. Би А, “Альфа ба Омега” (Илчлэлт 1:8); “амар амгаланг үндэслэгч” (Мозая 15:18); Б, Бетлехемийн “нялх хүүхэд” (Лук 2:12, 16); З, “Зөвлөгч” (Исаиа 9:6; мөн 2 Нифай 19:6-г үзнэ үү); Ө, “Өргөмжилсөн [нэгэн]” (Дуулал 89:19); Ч, “Чөлөөлөгч” (Ром 11:26) гэх мэт дараалалаар эхэлдэг.

Христийн мэндэлсний баяраар би Түүний илүү олон нэрийг чээжлэхийг мөн Түүний нэрэнд хүндэтгэл үзүүлэх боломжуудыг эрж хайхыг тэсэн ядан хүлээдэг. Та энэ Христийн мэндэлсний баярын үеэр өөрчлөлт авчрахаар хичээхдээ Аврагчийг хичээл зүтгэлийнхээ төвд байлган, Түүний нэрээр бусдад үйлчилснээр Түүнийг алдаршуулна гэдэгт найдаж байна.

Мөнхийн Эцэг маань амьд гэдгийг би гэрчилж байна. Түүний аз жаргалын төлөвлөгөө бүх үеийн хүүхдүүдийнх нь амьдралыг арвин ихээр адисалдаг. Түүний Хайрт Хүү Есүс Христ Бетлехемд төрсөн бяцхан хүүхэд, дэлхийн Аврагч, Гэтэлгэгч гэдгийг би мэднэ.

Магтаалын энэ үгс миний сонорт үнэнийг өгүүлдэг. “Дээдийн дээд Хаан Бурханыг магтъя, ертөнц хүмүүс амар байг, ертөнц хүн бүгд амар байг.”[7] ■

2016 оны 12-р сарын 13-нд АНУ-ын Юта мужийн Солт Лэйк Сити хотод БЯИС-ийн Менежментийн нийгэмлэгийн Солт Лэйк Сити хотын бүлэгт зориулан хэлсэн үгээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. Ханна Корнаби, *Autobiography and Poems* (1881), 45–46.
2. “Ирцгээ, ирцгээ гэгээнтнүүд ээ,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу,* х. 2.
3. Томас С.Монсон, “May We So Live,” *Лиахона,* 2008 оны 8-р сар, 5.
4. “Алс тэртээ хол Иудейн нутаг хээр талд,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу,* х. 52.
5. Карэн Линн Дэвидсон, *Our Latter-day Hymns: The Stories and the Messages* (1988), 223–224-ийг үзнэ үү.
6. Томас С.Монсон, “Үлгэр жишээ мөн гэрэл байгтун,” *2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 75.
7. *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу,* х. 52.

Христийг төрөх үед БОЛСОН 14 үйл явдал

Жэссика Гриффит

Есүс Христийн мэндэлсэн өдрийг бид дуу дуулж, гэр бүлийн уламжлалт үйл явдалд баясан, Их Эзэний төрөлтийг эрхэмлэн дээдэлж, Түүнийг дурсан санаж тэмдэглэдэг. Гэхдээ бид судруудаас Христийн төрөлтийн талаар дэлгэрэнгүй юу олж мэддэг вэ?

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН ЖИНХЭНЭ МӨН ЧАНАР

"Тэрээр дэлхийд ирсэн учраас бид жилийн энэ үеэр баяр баясгалантай байдаг. Түүнээс ирдэг амар амгалан, бидний хүн нэг бүрийн мэдэрч болох төгсөшгүй хайр, Өөрөө асар их төлөөс төлж байж бидэнд үнэгүй өгсөн зүйлд хэмжээлшгүй ихээр талархах мэдрэмж зэрэг нь бүгд Христийн мэндэлсний баярын жинхэнэ мөн чанар юм."

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008), "The Wondrous and True Story of Christmas," *Liahona,* 2000 оны 12-р сар, 6.

ҮЙЛ ЯВДАЛ

Христийн төрөлтийг бошиглосон

Эхлэл 49:10; Исаиа 7:14; 9:1–7; Мика 5:2; Мозая 3:8; Алма 7:10; Хиламан 14:2–5



БОЛСОН ГАЗАР

ЭРТНИЙ ИЕРУСАЛИМ БА ЭРТНИЙ АМЕРИК

Аврагчийг мэндлэхээс олон жилийн өмнө бошиглогчид Есүс Христийн талаар илчлэлт хүлээн авдаг байжээ. Хуучин Гэрээний бошиглогчид Давид хааны угсаанаас Мессиа болох хаан Бетлехемд төрөх тухай ярьжээ. Иудейчүүдийн-хээр энэ Мессиа Өөрийн хүмүүс болох иудейчүүдийг улс төрийн дарангуйллаас гарган, газар дэлхий дээр зөв шударга байдлаар захирах хаан болох байв. Гэхдээ эртний иудейчүүд Хаан нь хүмүүсээ сүнслэг дарангуйллаас гаргана гэдгийг хүсэн хүлээгээгүй байжээ. Гэтэл Есүс Христ түр зуурын аврал, газар дэлхийн хаанчлалаас илүү зүйл болох мөнхийн аврал, Эцэгийнхээ хаанчлалыг санал болгосон.

Тэнгэр элч Габриел Иохан Баптистын эцэг эх дээр айлчлав

Матай 17:12–13; Лук 1:5–25 (ялангуяа 17-р шүлэг); Сургаал ба Гэрээ 27:7; Судруудын удирдамж, "Елиас"

ИУДЕЙ

Иохан Баптист бол Елиас буюу Есүс Христээс түрүүлж ирсэн хүн юм. Тэнгэр элч Габриел Захариад үзэгдэж, түүний эхнэр Элизабет хүүтэй болох ба түүнийг Иохан гэж нэрлэх ёстой хэмээн мэдэгджээ. Захариа эргэлзсэн учраас хэлгүй дүлий болов.



Тэнгэр элч Габриел Мариад үзэгдэв

Матай 1:18; Лук 1:26-38

НАЗАР БА ГАЛИЛ

Габриел зургаан сарын дараа Елизабетын үеэл Мариа дээр айлчлав. Тэрээр Мариад хэдий онгон байсан ч Ариун Сүнсний хүчээр хүүхэдтэй болж, тэр хүүхэд Есүс Христ гэгдэх болно гэдгийг хэлжээ. Мариа Бурханы Хүүгийн эх болох дуудлагыг даруухан хүлээн авав. Тэнгэр элч үеэл Елизабетыг нь бас бие давхар болсон гэж хэлжээ.

Мариа Элизабетийнд зочлов

Лук 1:39-56

ИУДЕЙ

Мариа дээр тэнгэр элч зочилсноос хойш тэрээр Иудейд байдаг үеэл Елизабетийндээ гурван сар байхаар Назараас явав. Мариаг тэнд байх үед Елизабет Мариагийн хүүхэд бол Бурханы Хүү гэсэн гэрчлэлийг Ариун Сүнсээр дамжуулан хүлээн авчээ. Мариа бас Бурханы тухай гэрчлэлээ хуваалцав.

Иохан Баптист мэндлэв

Лук 1:57-80

ИУДЕЙ

Иохан Баптистыг мэндлэх үед хүмүүс эцгийнх нь нэрээр Захариа гэж нэрлэх байх гэж байтал Елизабет дургүйцэн, найз нөхөд, хөршүүддээ нэрийг нь Иохан гэж хэлжээ. Захариагаас найз нөхөд, хөршүүд нь шалгаахад тэрээр Елизабеттэй санал нэг байв. Тэрээр хүүдээ нэр өгөхдөө Габриелийн зааврыг дагасан учраас хэл ам нь нээгдэн, дахин олж авсан сонсгол, хэлээ Бурханыг алдаршуулахад ашиглажээ.

Тэнгэр элч Габриел Иосефт үзэгдэв

Матай 1:18-23

НАЗАР

Мариатай сүй тавьсан Иосеф Мариаг Назарт ирэхэд дав-хар биетэй байгааг нь хараад, түүнийг "гутамшиг болгох"-ыг үл хүссэн тул нууцаар сүйгээ цуцлах санаатай байв. Гэтэл түүнийг сүйгээ цуцлахаас өмнө тэнгэр элч Габриел түүний зүүдэнд үзэгдэн, Мариагийн хүү Ариун Сүнснийх гэдгийг учирлан, тэрхүү хүүхэд ард түмнээ нүглээс нь аврах нэгэн болно хэмээн гэрчилжээ. Иосеф Мариагаас салахын оронд харин түүнтэй гэрлэхээр шийдэв.

THE PROPHET ISAIAH FORETELLS CHRIST'S BIRTH, ХАРРИ АНДЭРСОН; ТЭНГЭР ЭЛЧ ГАБРИЕЛИЙН ЗУРГИЙГ МАЙКЛ МОЛМ; *BLESSED ART THOU AMONG WOMEN*, ВОЛТЭР РЭЙН; DETAIL FROM *THE VISITATION*, РЕМБРАНД ХАРМЕНЦ (1609–69)/ДЕТРОЙТЫН УРЛАГИЙН ИНСТИТУТ, АНУ/BRIDGEMAN ЗУРГУУД; *ARCHANGEL GABRIEL STRIKES ZACHARIAS DUMB*, АРЫН ДЭВСГЭР, ХҮРЭЭ, ТЭМЭЭ УНАСАН ХҮН ЗЭРГИЙГ GETTY IMAGES-ЭЭС АВАВ; *ZACHARIAS WRITING A NAME FOR THE CHILD*, FCIT-ИЙН ӨМЧ; *ANNUNCIATION TO JOSEPH*, ЖОЗЕФ БРИКИ

Хүн амын тооллого

Лук 2:1–4;
Жэймс Э.Талмэйж,
Jesus the Christ
(1916), 91–92

РОМЫН ЭЗЭНТ ГҮРЭН

Тооллогоор ромчуудын хэрэгжүүлдэг татварыг оногдуулан, хүн амын тооллогын бүртгэл хийдэг байв. Ромчууд хүмүүсийг ихэвчлэн тухайн оршин суугаа газарт нь бүртгэдэг байсан ч иудейчүүдийн заншлаар бол эцэг өвгөдийнх нь нутагт бүртгэдэг байжээ. Ийм учраас Иосефын өвөг дээдсийн төрөлх нутаг Бетлехем хүн ихтэй, дэн буудлууд нь сул өрөөгүй байв.



Есүс Христ мэндэлллээ

Лук 2:6–7

НАЗАР, БЕТЛЕХЕМ, ИУДЕЙ

Бетлехем гэдэг нь "талхны байшин" гэсэн утгатай бөгөөд Мессиагийн төрөх газар хэмээн бошиглогдсон газар байсан.

Иосеф, Мариа хоёр тооллогод бүртгүүлэхээр Бетлехем рүү явжээ. Есүсийг мэндлэхэд Мариа тэжээлийн тэвш буюу мал амьтны тэжээлийн идүүрийг хүүхдийн ор болгож, дотор нь хүүг тавьжээ. Ямар нэгэн мал амьтан дэргэд нь байсан тухай дурдаагүй байдаг.

Бошиглосон тэмдгүүд Америк тивд үзэгдэв

Хиламан 14:1–5;
3 Нифай 1:15–21

АМЕРИК ТИВ

Өмнө бошиглогдсоны дагуу, Христийн мэндэлсэн өдөр Америк тивд нэг өдөр, нэг шөнө нь өдөр, шөнө гэж байхгүй нэгэн өдөртэй адил байв. Тэнгэрт нэгэн шинэ од үзэгдэв.

Хоньчид Христийг төрөх гэж байгаа тухай сонсов

Лук 2:8–17

БЕТЛЕХЕМИЙН ОЙРОЛЦОО

Жилийн тэр үед хоньчид сүргээ хээр өдөр шөнөгүй манадаг байв. Энэ бол Аврагчийн мэндлэх тухай хэлсэн тэнгэр элч үзэгдсэн газар юм. Тэнгэр элчийг ийнхүү зарласны дараа олон тооны тэнгэр элч Бурханыг магтан алдаршуулжээ. Үүнийг сонссон хоньчид Есүсийг харахаар Бетлехем рүү яаран гарав. Тэд Есүсийг харсныхаа дараа Иосеф, Мариа хоёрыг орхиж, бусдад харсан зүйлээ гэрчилж байлаа.

Ариун сүмд Есүсийн хөвчийг хөндөн, нэр хайрлаж, танилцуулав

Лук 2:21–38; Жэймс Э.Талмэйж, *Jesus the Christ,* 95

БЕТЛЕХЕМ

Найман өдрийн дараа иудейчүүдийн заншлаар Есүсийн хөвчийг хөндөн, нэр өгчээ. Түүнд Есүс буюу еврей хэлээр "Аврагч" гэсэн утгатай "Ешуа" хэмээх нэрийг өгөв. Иудейчүүдийн заншлаар эмэгтэй хүн хүүхэд төрүүлснээсээ хойш 40 хоногийн дараа ариун сүмд ордог. 40 хоног өнгөрсний дараа Мариа, Иосеф хоёр Есүсийг танилцуулахаар ариун сүмд авчрав. Тэд тэнд үхэхээсээ өмнө Христийг харах болно хэмээх амлалтыг хүлээн авсан Симеонтэй таарчээ. Тэрээр Христийг таниад, Түүнийг гартаа өргөн барьж, Бурханд магтаал өргөв. Мөн тэрээр дэлхий дээр Христийн гүйцэтгэх зорилгыг бошиглодог байжээ. Мөн эш үзүүлэгч Анна ариун сүмд Христийг гэрчилжээ. Тэрээр бас Түүний зорилгыг гэрчлэв.

Мэргэн хүмүүс Херодоос Христийн тухай асуув

Матай 2:1–10

ИЕРУСАЛИМ

"Дорно зүгээс" тодорхой бус тооны зурхайчид Христийг хайн Иерусалимд хүрч ирэв. Тэд Христ мэндэлснийг илтгэсэн шинэ од тэнгэрт гарсныг харсан байв. Тэд ромчуудын томилсон Иудейн хаан Херодоос хүүхдийг хаанаас олох ёстойг асуужээ. Херод хаанчлалынх нь эрхийг авах шинэ хаан нь Мессиа болж магадгүй гэсэн айдастай байв. Тэрээр энэ айдсаа мэргэн хүмүүст мэдэгдэлгүй, Христийг хаанаас олсноо мэдэгдэхийг тэднээс хүсжээ. Тэр Христийг егүүтгэх санаатай байв.

Мэргэн хүмүүс Христийг олоод, бэлэг сэлт өгөв

Матай 2:9–12; Bible Dictionary, "Magi"

БЕТЛЕХЕМ

Эцэст нь мэргэн хүмүүс Христийг хайж олов. Матай номон дээр тэд Христийг төрснөөс хойш нэг жилийн дараа "бяцхан хүүг" гэртээ байхад нь олдог гэж гардаг. Тэд Есүст алт, гүгэл, мирийг бэлэг болгон барьж, Түүний хаан болохыг нь хүлээн зөвшөөрчээ. Зурхайчид зүүдэндээ Херодод Есүсийг олсон тухайгаа хэлэхгүй байх заавар авчээ.

Иосефт Египет рүү зугт гэж сэрэмжлүүлэв

Матай 2:13–16, 19–23

БЕТЛЕХЕМ, ЕГИПЕТ, НАЗАР

Зурхайчид Херодод амласан ёсоороо мэдэгдсэнгүй. Херод хоёр болоод түүнээс доош насны бүх хүүхдийг хөнөөх зарлиг буулгав. Зүүдэндээ сэрэмжлүүлэг хүлээн авсан Иосеф Мариа, Есүс хоёрыг Египетэд аваачив. Тэд Херодыг нас бартал тэндээ байв. Херодыг нас барсны дараа Иосефын зүүдэнд тэнгэр элч үзэгдэн, Израиль руу буцахад аюулгүй гэжээ. Херодын хүү эцгийнхээ оронд хаанчилж байгааг сонсоод, Иосеф гэр бүлээ Иудей рүү биш, харин Галил нутгийн Назар хотод авчирсан бөгөөд ийнхүү Христийн амьдрал Назарын Есүс болж эхэлжээ. Олон жилийн дараа Тэрээр баптисм хүртэн, гайхамшиг үйлдэж, гайхамшигтай бөгөөд мөнхийн Цагаатгалыг хийжээ.

THE ROAD TO BETHLEHEM, ЖОЗЕФ БРИКИ; *ANNUNCIATION TO THE SHEPHERDS,* ДЭЛ ПАРСОН; *SIMEON AND CHRIST* GOODSALT.COM-AAC © LARS JUSTINEN/ LICENSED; *WISE MEN BEFORE KING HEROD* © THE CLASSIC BIBLE ART COLLECTION/LICENSED FROM GOODSALT.COM; *FLIGHT,* РОЗ ДАТОК ДОЛЛ; *A SAVIOR IS BORN*-ААС ДЭЛГЭРЭНГҮЙ, ЖОЗЕФ БРИКИ; *THE NATIVITY,* ЖОН МАКНОТОН; *THE WISE MEN SEEKING JESUS,* РОБЭРТ ДУДЛИЙ АТБРОЗ (1867–1951)/ХУВИЙН ЦУГЛУУЛГА/©LOOK AND LEARN/BRIDGEMAN IMAGES



Далын
**Ахлагч
Маркус Б.Нэш**

Иосеф Смит:

Сул дорой байдлаас гарсан хүч

[Орчуулагчийн тайлбар: Энэ өгүүлэлд Иосеф Смитийн гараараа бичсэн хэсгээс хэд хэдэн удаа эш татдаг. Уг эшлэлүүдийн англи хувилбар дээр үг үсэг, цэг таслал, том жижиг үсгийн хэрэглээний зарим алдаа бий. (Америк англи хэлний зөв бичгийн дүрэм 1820-иод оны сүүлч хүртэл стандартчилагдаж эхлээгүй байв.) Гэсэн хэдий ч, уншихад хялбар болгохын тулд эшлэлүүдийг алдаагүйгээр нь орчуулах болно.]

Хэдэн мянган жилийн өмнө эртний Иосеф "Их Эзэн надад ийн хэллээ: Би чиний хэвлийн үрсээс сонгогдсон үзмэрчийг тодруулна; . . . миний үгийг авчрах хүчийг би түүнд өгнө . . . тэрээр сул доройгоос чадалтай болгогдох болно" хэмээн бошигложээ (2 Нифай 3:7, 11, 13).

"Тэрээр сул доройгоос чадалтай болгогдох болно" гэсэн бошиглол миний сонирхлыг татан, сүнслэг өдөөлт өгсөн. Их Эзэн агуу ажлаа гүйцэлдүүлэхээр сул доройчуудыг дуудна гэдэг нь уялдаа авцалдаагүй мэт санагдаж магадгүй. Гэхдээ сул талаа танин мэдсэн хүмүүст чухам энэ сул тал нь Их Эзэний хүчийг эрэлхийлэх сэтгэлийн дуудлага болдог байж болох юм. Өөрсдийгөө итгэлээр даруусгадаг хүмүүс тэнгэр газрын бүх хүч чадлыг эзэмшигч Түүгээр хүчирхэгжих болно (Матай 28:18; Мозая 4:9-ийг үзнэ үү).[1]

Иосеф Смит бага залуу байхаасаа ийм шалтгаанаар Их Эзэнд хандсан. Иосеф 15 нас хүрсэн жилээ гэм нүглээс өршөөгдөхийг хүсэмжлэн, аль сүм нь зөв болохыг мэдэхийг маш их хүсжээ. Тэрээр "Хэдийгээр миний бодол санаа гүн гүнзгий хийгээд хурц байсан ч гэсэн, . . . хүмүүс болон юмстай төдийлөн танилцаж амжаагүй миний мэт залуу хүний хувьд, хэнийх нь зөв, бас хэнийх нь буруу байсан тухайд ямар нэг тодорхой дүгнэлт хийх боломжгүй байв" гэж бичсэн байдаг (Иосеф Смит—Түүх 1:8-ыг үзнэ үү).

Сул доройгоо бүрэн ухаарсан тэрээр Бурханы Сүмийг хаанаас олохоо мэдэхээр Ариун ойн цоорхой руу очив. Тэр сүмд нь *нэгдэхийн* тулд юу *хийж* болохоо мэдэхийг хүсжээ (Иосеф Смит - Түүх 1:18-ыг үзнэ үү). Иосефын даруу, чин сэтгэлийн гуйлтын хариуд Бурхан Эцэг болон Түүний Хүү, Есүс Христ хоёр түүнд үзэгдсэн. Тэд ийнхүү

Бид Иосеф Смитийн адил сул талаа танин мэдэж, итгэлээрээ Их Эзэнд хандвал биднийг хүчтэй болгоно.

ДЭЛГЭРЭНГҮЙГ *THE PURPOSE OF LIFE*-ЭЭС, ЖОЗЕФ БРИКИ



үзэгдэхдээ түүнийг чөтгөрийн хүчнээс гарган, Сэргээлтийн замыг бэлтгэж өгчээ (Иосеф Смит—Түүх 1:14–19-ийг үзнэ үү).

Иосеф Смит өөрийгөө “дэлхийн сул дорой зүйлүүд”-ийн нэг гэдэгтэй маргаагүй (С ба Г 1:19; 35:13). Олон жилийн хойно Их Эзэн түүнд хандан, “учир нь дэлхийн сул дорой зүйлүүдээр дамжуулан бибээр мэргэн ухаанаа үзүүлж болохын тулд би энэ төгсгөлд чамайг бэлтгэсэн билээ” хэмээн айлдсан (С ба Г 124:1).

Нэрд гараагүй хөвгүүн

Иосеф “өдөр тутмын хөдөлмөрөөрөө тарчигхан амьдралаа залгуулж яваа, нэрд гараагүй хөвгүүн” хэмээн өөрийгөө дүрслэн хэлжээ (Иосеф Смит—Түүх 1:23). Тэрээр албан боловсрол багатай нийгмийн доод давхаргын гэр бүлд төрсөн. Намтар түүхээ бичих гэсэн түүний анхны оролдлого түүнийг уг ажилд дуудагдахдаа сул дорой байсан гэдгийг онцлон харуулдаг.

“Бидний Их Эзэний нэг мянга найман зуун таван онд, арван хоёрдугаар сарын хорин гурав дахь өдөр Вермонт муж улсын Шарон хотхонд Христийн шашинд намайг оруулахаар ихэд хичээл зүтгэл гаргах сайн эцэг эхийн гэр бүлд би төрсөн. Намайг аравтай юм уу, тэр орчим настай байхад миний эцэг Ахмад Иосеф Смит Нью-Йорк муж улсын Онтарио гүнлэгийн Палмирад шилжсэн бөгөөд ядуу тарчиг нөхцөл байдлын улмаас есөн хүүхэдтэй өнөр бүлээ тэжээж дэмжихийн тулд хүнд хүчир хөдөлмөр хийх үүрэг хүлээсэн юм. Гэр бүлээ тэжээхэд тус нэмэр болж чадах бүх хүний хүчин чармайлт шаардлагатай байснаас бид боловсролын ашиг тусыг хүртэж чадаагүй бөгөөд би ердөө унших, бичих, тооны анхан шатны суурь заалгасан байлаа.”[2]

Иосеф боловсрол муутайгаа маш сайн мэддэг байсан ба “үзэг цаас бэх төгс бус хазгай хэлтгий хэлний бараг түнэр харанхуй мэт жижигхэн нарийхан шорон”-д хүлэгдсэн байгаадаа нэгэнтээ харуусчээ.[3] Хэдий тийм ч Их Эзэн түүнийг Мормоны Номыг орчуулуулахаар дуудсан бөгөөд тэрээр анхны хэвлэгдсэн 588 хуудсыг бүгдийг нь ер хүрэхгүй хоногийн дотор орчуулсан юм.

Ямар ч хүн боловсрол нимгэн Иосеф ганцаараа ийм зүйл хийх боломжгүй гэсэн дүгнэлт хийх нь ойлгомжтой бөгөөд зарим хүний бодож олсон тайлбарууд нь тэр бол Бурханы бэлэг болоод хүчээр орчуулсан бошиглогч байсан хэмээх үнэн тайлбарт итгэхээс хавьгүй илүү хэцүү байдаг.

Эммагийн гэрчүүд

Эмма Смит амьдралынхаа хожуу үед, нөхөр нь алтан ялтсуудыг орчуулж байх үедээ “Мормоны Ном мэтийн ном байтугай ойлгомжтой, сайн найруулгатай захидал бичиж эсвэл хэлж бичүүлж чаддаггүй байсан.

Зүүн гар талд: Иосеф Смитийн түүхийн гар бичмэлийн оршил хэсгээс. Эсрэг талын хуудсанд: Иосеф Смитийн тэмдэглэлээс авсан хуудас. Хасаж дарсан үгсийг анзаараарай.





Энэ нь ямар ч хүний хувьд ер бусын гайхамшиг ба гайхалтай зүйл байдаг шиг уг үйл явдалд оролцсон надад ч бас гайхалтай санагддаг" хэмээн дурсан өгүүлжээ.[4]

Түүхийн энэ хэсгийг 1832 оны 11-р сарын 27-ны Иосефын анхны өдрийн тэмдэглэлийн нэг хуудастай харьцуулж харахад сонирхолтой байдаг (баруун талд харуулав). Тэрээр үүнийг Мормоны Номыг орчуулж дууссанаасаа хойш барагцаалбал гурван жил хагасын дараа бичжээ. Тэрээр доорх үгсийг бичээд, дараа нь дарж хассан байсныг анзаараарай.

"Бага Иосеф Смитийн ажигласан бүхий л жижиг сажиг нөхцөл байдлыг тэмдэглэхийн тулд худалдаж авсан тэмдэглэлийн дэвтэр."

Би түүний тэмдэглэлийг гартаа бариад, хассан үгсийг уншиж байхдаа Иосефыг өмнөд Америкийн хөдөө тосгоны нэгэн газар суугаад, эхний өгүүлбэрийг бичсэнийхээ дараа "Энэ тийм ч зөв биш байна. Дахиад оролдоод үзье" хэмээн бодож байгаагаар төсөөлөн бодсон юм. Тэгээд тэрээр тэр өгүүлбэрийг дарж хасаад, "Бага Иосеф Смит 1832 оны 11-р сарын 27-нд ажигласан бүхий л зүйлээ цэдэглэн бичсэн товч тэмдэглэл ба — —" гэж бичжээ.

Эцэст нь дөнгөж сая бичсэн ядмаг, тааруухан зүйлдээ сэтгэл хангалуун байгаагүй байх магадлалтай тэрээр "Ай, Бурхан минь, бүхий л бодолдоо чиглүүлэгдэх боломж өгөөч. Үйлчлэгчээ адислаач. Амен" хэмээн бичжээ.[5] Би энэ өгүүлбэрээс Иосеф хангалтгүй байгаагаа болон сул доройгоо мэдрэн, хийдэг бүхий л зүйлд нь чиглүүлж өгөх Бурханыг итгэлээр дуудаж байгааг мэдэрдэг.

Одоо харин тэрхүү тэмдэглэлийг 1829 оны 4-өөс 6-р сарын хооронд бичсэн Мормоны Номын гар бичмэлийн эх хувьтай харьцуулан харна уу (дараагийн хуудсан дээр харуулав).

Таслалгүй, баллаж цохлоогүй бичвэр байгааг анхааралтай хар. Энэ нь зохион бичлэг байгаагүй. Иосеф Их Эзэний түүнд зориулан бэлдсэн зэмсгүүд болох Урим ба Туммим болоод үзмэрчийн чулуу руу харж байхдаа хурц тод гэрлээс нүдээ хамгаалж, гарч ирэх үгсийг тод харахын тулд нүдээ малгайгаар халхалж, үүнийг үг нэг бүрчлэн хэлж бичүүлжээ (2 Нифай 27:6, 19–22; Мозая 28:13-ыг үзнэ үү). Та нарын харж байгаачлан бошиглогч, үзмэрч, илчлэгч Иосеф Смитийн бүтээл болох Мормоны Номын орчуулга, Иосеф Смит хэмээх хүний тэмдэглэл хоёрын хооронд асар том ялгаа байна. Хэрэв та нар орчуулгын гар бичмэлийн эхийг сайн харах юм бол.

"Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, эцэгтээ хандаж хэлрүүн: Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлиг эс буулгана гэдгийг би мэдэх учраас би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно" хэмээн Иосефт урам зориг өгсөн үгсийг унших болно (1 Нифай 3:7).

Эдгээр үгийг орчуулахын өмнөхөн тэрээр "Гэвч болгоогтун, итгэлийнх нь учир бүр тэднийг аюулаас ангижрах чадалтай болтол нь хүчтэй болгохоор сонгосон бүгдийн дээр Их Эзэний нигүүлсэл байдгийг би, Нифай та нарт үзүүлэх болно" хэмээн орчуулсан байжээ (1 Нифай 1:20).

АНХНЫ ҮЗЭГДЭЛ, УОЛТЭР РЭЙН



Тиймдээ ч Мормоны Номын болон бошиглогч Иосефын амьдралын гол санаа бол Их Эзэнийг итгэлээр даруухан эрэлхийлдэг хүмүүс Их Эзэний ажилд хүчтэй, бүр агуу хүчтэй болдог гэсэн санаа юм. Энэхүү хүчирхэгжилт жижиг мэт санагдах зүйл дээр ч тохиолдоно.

Жишээлбэл, зөв бичихдээ муу Иосеф хувийн бичээч Оливер Каудерийн бичсэн *Кориантумр* гэсэн үгийг засаж байжээ (Хиламан 1:15-ыг үзнэ үү). Иосефыг эхлээд энэ үгийг Оливерт хэлж бичүүлэхэд тэрээр *Кориантуммер* гэж бичжээ. Англи хэлэнд "мр" гэсэн төгсгөлтэй үг байхгүй учраас энэ бол үндэслэлтэй байв. Гэтэл Их Эзэний өгсөн зөв бичих дүрмийг хүлээн авахдаа сул дорой Иосеф орчуулгын үеэр үүнийг хэлж зөв болгожээ. Бид энэ нь англи хэлэнд хэвийн бус ч, египет хэлэнд яг зөв буудаг, эртний хэл соёлтой тун сайн нийцдэг гэдгийг одоо мэдэж байна. Иосеф үүнийг зөвхөн илчлэлтээр л мэдсэн байв.[6]

Биднийг хүчтэй болгож чадна

Мормоны Номын орчуулгын гайхамшиг бол Иосефыг хэрхэн сул дорой байдлаас нь хүчтэй болгосны нэг жишээ юм. Бас нэг илүү хувийн гэмээр сургамж бол бид Иосеф Смитийн адил сул талаа танин мэдэж, итгэлээрээ Их Эзэнд хандаж, Түүний хүслээр үйлдэх шийдвэр төгс байвал биднийг сул доройгоос хүчтэй болгох явдал юм. Энэ нь мөнх бус амьдралд сул дорой байдал үгүй болно гэсэн үг биш ч ийм хувь хүнийг Бурхан хүчтэй болгоно гэсэн утгатай.

Иосеф төгс бус байдлаа даруухан хүлээн зөвшөөрсөн. Тэрээр залуу насандаа "залуу насны сул тал хийгээд хүмүүний төрөлхийн жижиг сажиг сул тал илрэн гарч байв" хэмээн онцлон хэлжээ (Иосеф Смит—Түүх 1:28). Хожим тэрээр Наувуд байсан гэгээнтнүүдэд хандан, өөрийгөө "хүмүүн байсан хэдий ч тэд [түүнээс] төгс байхыг хүсэн хүлээх ёсгүй; . . . гэхдээ тэд [түүний] болон ах нарын дутагдлуудыг тэвчих аваас [тэр] ч бас адилхан тэдний сул доройг тэвчих болно" хэмээн хэлжээ.[7]

Иосеф хэзээ ч төгс эсвэл алддаггүй мэт дүр эсгээгүй, харин "Би хүмүүний хувиар ярьж байхдаа Иосеф л ярьж байгаа мэт байдаг. Гэтэл Их Эзэнийг надаар дамжуулан ярих үед энэ нь Иосеф Смит биш харин Бурхан ярьж байдаг" хэмээн түүнийг бошиглогчийн хувиар үйлдэхэд нь Бурханы хүч эзэмддэг гэдгийг хүлээн зөвшөөрч байсан.[8]

Иймээс ч Иосеф сул дорой байдлаас мөн бүх цаг үеийн бошиглогчдоос "хүмүүний авралын тулд зөвхөн Есүс Христийг эс тооцвол . . . илүү ихийг" хийх хүчтэй болсон (С ба Г 135:3).

Хэрэв бид Бурханд Иосефын адил зүрх сэтгэлийн бүрэн зорилготойгоор итгэлээр хандвал хэзээ ч хувиршгүй Бурхан маань таныг, намайг сул дорой байдлаас маань хүчтэй нэгэн болгоно.

Залбирал ба даруу байдал

Их Эзэний селестиел хувилахуйн ухаанаар бол Тэрээр бидэнд сул дорой байдлыг өгдөг бөгөөд ийм сул доройг Түүгээр дамжуулан одоо болон үүрд мөнхөд



Мормоны Номын 1 Нифай 3:7-д холбогдох гар бичмэлийн хэсгээс.



хамаатай арга замаар хүчтэй болгоход тусалдаг. Тэрээр "Мөн хэрэв хүмүүс надад ирэх аваас би тэдэнд өөрсдийнх нь сул доройг үзүүлэх болно. Тэд даруу байж болохын тулд би хүмүүст сул доройг өгдөг; мөн миний өмнө өөрсдийгөө даруусгадаг бүх хүмүүст миний ач ивээл хангалттай; учир нь хэрэв тэд миний өмнө өөрсдийгөө даруусгаж, мөн надад итгэлтэй байх аваас, тэгвэл би тэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө" хэмээн хэлсэн (Ифер 12:27).

Судрын энэ хэсэгт өгүүлснээр, биднийг даруу байлгахын тулд сул дорой байдлыг өгдөг. Өөрсдийгөө даруусгаж, Түүнд итгэх итгэлээ хөгжүүлэхийг сонгодог хүмүүс хүчтэй болгогддог. Бурханы өмнө даруу байх нь амьдралд маань Бурханы хүч чадлыг нэмэгдүүлж харахад чухал хүчин зүйл юм.

"Аливааг сураад өөрсдийгөө ухаантай хэмээн санадаг, мөн тэд Бурханы зөвлөмжийг эс анхаардаг, учир нь тэд үл ойшоож, тэд өөрсдөө мэднэ гэж боддог, иймийн тул, тэдний мэргэн ухаан нь тэнэглэл байж мөн энэ нь тэдэнд ашгийг эс өгдөг" хүмүүс байдаг (2 Нифай 9:28). Ийм бардамналын эсрэг ерөндөг бол "Бурханы өмнө өөрсдийн мунхгийг мэдэж, мөн даруу байдлын гүнд доошлон ирэх" явдал юм (2 Нифай 9:42).

Иосеф өсвөр насандаа даруу зан чанарыг төлөвшүүлэх агуу түлхүүр бол чин сэтгэлээсээ, зүрхний угаас Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирах явдал гэдгийг ухаарчээ. Сүмийн эхэн үеийн нэгэн гишүүн Даниел Тайлер Көртландад олон хүн бошиглогчийн эсрэг эргэснийг дурсан бичсэн байдаг. Бошиглогчийн цугларагсадтай хамт Их Эзэний тусламжийг гуйн залбирсан нэгэн цуглаан дээр байлцсан Тайлер ах тэнд болсон үйл явдлыг дараах үгсээр дүрсэлжээ.

"Би эрэгтэй, эмэгтэй хүмүүс залбирч байхыг сонсож байсан . . . , гэхдээ тэр өдрийг хүртэл сайхан сэтгэлтэй эцэг хүн дуулгавартай хүүгийнхээ зовлон шаналлыг сонсон, яг тэнд байгаа мэт Бүтээгчдээ хандан залбирч байгаа хүнийг сонсож үзээгүй байв. Иосеф тэр үед эрдэм боловсролгүй байсан ч гэлээ . . . төөрөөд замаасаа холдсон хэмээн түүнийг буруутгасан олон хүний нэрийн өмнөөс тодорхой хэмжээнд хандсан түүний залбирал тэнгэрээс суралцчихсан, тэнгэрийн уран үг хэллэгтэй байлаа. . . . Хөшиг авагдах үед энэ нь Их Эзэн миний мэдэх хамгийн даруу үйлчлэгчтэйгээ нүүр нүүрээ харан зогсож байгаа мэт надад харагдсан."[9]

ЭРТНИЙ МОРМОНЫ НОМ, ГАР БИЧМЭЛИЙН ЗУРГИЙГ СҮМИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

Сул доройгоос хүчтэй болгогдов

Иосефыг 17-той байхад Моронай "Надад зориулан хийх нэгэн ажил Бурханд бий гэдгийг, мөн миний нэр бүх үндэстэн, ястан болон хэлтнүүдийн дунд сайнаар бас муугаар дурсагдаж, өөрөөр хэлбэл бүх хүмүүний дунд сайн болон муу аль алинаар нь яригдах болно" хэмээн хэлжээ (Иосеф Смит—Түүх 1:33).

Тухайн үед олон хүн энэхүү мэдэгдлийг хэзээ ч биелэхгүй зүйлийн нотолгоо хэмээн үзэж байсан ч өнөөдөр интернэт хөгжсөн дэлхийд, фермийн нэрд гараагүй тэрхүү хүүгийн нэр бөмбөрцгийн эргэн тойронд танигдсан бөгөөд түүнийг сайн болон муу аль алинаар нь ярьж *байна*.

Иосеф, Хайрум Смит хоёрыг Иллинойн Картейжид



алуулахаас өмнө Хайрум Иосефт болон шоронд байсан бусад хүнд дараах үгс бүхий хуудсыг уншиж өгөөд, нугалжээ.

“Мөнхүү улиран тохиох дор тэд энэрлийг агуулж болохын тул, тэрээр харийнханд ач ивээлийг хайрлаасай хэмээн Их Эзэнд хандан би залбирсан буюу.

Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад хэлэв: Хэрэв тэд энэрэл үгүй аваас, энэ нь танд хамаарах нь үгүй; чи итгэлтэй байсан; иймийн тул өмсгөл чинь цэвэр болгогдох болно. Мөн чи өөрийн сул доройг харсан учир чи, миний Эцэгийн эзэмшилд, миний бэлтгэсэн тэр байранд суух хүртэл хүчирхэг болгогдох болно” (Ифер 12:36–37).

Шууд утгаараа Иосеф *сул дорой байдлаасаа* хүчтэй болсон юм. Сул дорой байсан тэрээр урам зориг орж, Бурханы хүслийн дагуу үйлдэх шийдвэр төгс байж, итгэлээр Түүний тусламжийг эрэлхийлжээ. Тэрээр амьдралынхаа туршид Тэнгэр дэх Эцэгтээ иим шалтгаанаар хандаж байсан. Үр дүнд нь тэрээр Анхны үзэгдлийг үзэж, Мормоны Номыг орчуулан, санваарын түлхүүрүүдийг хүлээн авч, Христийн сэргээгдсэн Сүмийг байгуулан, Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг дэлхий дээр авчирсан юм. Бошиглогч Иосеф Смит хүч чадалд өсөн өндийсөн. Гэхдээ тэрээр хормын төдийд хүчтэй болгогдоогүй. Энэ нь “алхам алхмаар, шат шатаар энд бяцхан мөн тэнд бяцхан”-аар түүнд өгөгдсөн ба та бидэнд ч ингэж өгөгдөх болно (С ба Г 128:21; мөн Исаиа 28:10; 2 Нифай 28:30-ийг үзнэ үү).

Тиймээс бүү урам хугараарай. Хүчтэй болгогдох үйл явц алгуур байх бөгөөд юу ч болсон бай Аврагчийг дагах, Түүний хүслийн дагуу байх хөдөлшгүй шийдвэр төгс тэвчээрийг шаардана.

Бэлэг эргэн ирсэн

XVI зуунд Библийг англи хэл дээр орчуулан, хэвлүүлсэн Виллиам Тиндейл Библийг жирийн хүний гарт өгөхийн эсрэг бодолтой байсан нэгэн мэдлэгтэй хүнд ‘Бурхан миний амийг хамгаалах юм бол *би хэдхэн жилийн дотор анжсаа түрэгч тариачин хүүг судрын тухайд танаас дутуугүй мэдлэгтэй болгоно”* хэмээн мэдэгджээ.[10]

Нэгэн сонирхолтой ижил төстэй үйл явдал 300 жилийн дараа болов. Нэнси Таул хэмээх нэгэн нэрт аялагч номлогч “мормончууд”-ыг судалж мэдэхээр



Иосеф, Хайрум Смит хоёрыг Иллинойн Картейжид алуулахаас өмнө Хайрум Иосефт болон шоронд байсан бусад хүнд дараах үгс бүхий хуудсыг уншиж өгөөд, нугалжээ.

Көртландад очжээ. Тэрээр Иосеф Смиттэй болон Сүмийн бусад удирдагчтай уулзсаныхаа дараа Сүмийг хурцаар шүүмжилж байв.

Таулын тэмдэглэн бичсэнээр, тэнгэр элч алтан ялтсуудыг хаанаас олохыг харуулсан хэмээн тангараглаж хэл гэж түүнийг шаардах хүртэл Иосеф юу ч хэлээгүй ажээ. Тэрээр тун эелдгээр хэзээ ч тангараглаж байгаагүй гэсэн хариу өгчээ. Уурыг нь хүргэж чадаагүй тэрээр Иосефыг басамжлах гэж оролдов. “Та иим мэдэгдэл хийхээсээ ичихгүй байна уу? Та бол энэ дэлхийн жирийн л нэг анжис түрсэн хөвгүүнээс өөр хэн ч биш” гэж түүнийг хэлэхэд, Иосеф “Эрт үед бичиг үсэгт тайлагдаагүй загасчдад тохиолдсоны адилаар бэлэг эргэн ирсэн” хэмээн тайван хариулжээ.[11]

Иймд Тиндейлийн хэлсэн үг үнэний ортой байжээ. Учир нь анжис түрсэн хүү Аврагчийг эс тооцвол энэ



дэлхийд амьдарч байсан ямар ч хүнээс илүү судрыг мэддэг болж өссөн.

Сэргээгдсэн Сүм болон Есүс Христийн сайн мэдээ нь Америкийн зах хязгаарын нэгэн “анжис түрсэн хөвгүүн” Иосеф Смит*ийн* ажил байгаагүй нь тодорхой. Харин энэ бол бошиглогч Иосеф Смитээр *дамжуулан* сэргээгдсэн, Их Эзэн Есүс Христийн ажил юм. Иосеф амьдралаа эргэцүүлэн бодож байхдаа Иаковын хэлсэн “Гэсэн хэдий ч, энэ нь түүний ач ивээл мөн хүмүүний үрсэд хандах түүний агуу их хүлцлээр бид эдгээр зүйлийг хийх хүчтэй гэдгийг бид мэдэж болохын тулд Их Эзэн Бурхан өөрсдийн маань сул доройг бидэнд үзүүлдэг болой” (Иаков 4:7) гэсэн сургамжийг ойлгосон байж магадгүй.

Иосеф Смит бол сул дорой байдлаас хүчтэй болгогдсон Бурханы бошиглогч байсан гэдгийг би мэднэ. Ерөнхийлөгч Бригам Янг (1801–1877): “Би чинь бошиглогч Иосеф Смитийг таньдаг байсан шүү дээ гэж бодох бүрдээ Халлелуяа хэмээн хашхирмаар санагддаг” гэжээ.[12] Хэдийгээр надад энэ мөнх бус байдалд ийм аз завшаан тохиогоогүй ч “сая сая хүн ‘Иосеф ах’-ыг мэдэцгээнэ” гэсэн яруу тод амлалтаас би тайвшрал олдог.[13] Сул дорой байдлаас нь хүчтэй болгосон Бурханы өмнө даруу байсанд нь бошиглогчид би гүнээ талархдаг. Мөн хэрэв бид Түүний өмнө өөрсдийгөө даруусган, Их Эзэний хүслийн дагуу үйлдэх хувиршгүй бат шийдвэрээр Түүнд итгэх итгэлээ хөгжүүлбэл Их Эзэн биднийг сул дорой байдлаас маань хүчтэй болгоно гэсэн энэ түүх, сургаал надад урам зориг өгдөг юм. ■

2013 оны 2-р сарын 10-нд АНУ-ын Юта мужийн Логанд болсон Иосеф Смитийн дурсгалд зориулсан 70 дахь удаагийн онцгой цугларалтын үеэр хэлсэн “Out of Weakness He Shall Be Made Strong” гэсэн үгээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. Би хамтран ажилласан хүмүүстээ, ялангуяа Сүмийн түүхийн албаны Бага Ричард И.Төрли, Жед Вүдворф нарт талархлаа илэрхийлж байна.
2. Иосеф Смит, *The Joseph Smith Papers, Histories, 1-р боть, 1832–1844,* хянасан Карэн Линн Дэвидсон ба бусад хүн (2012), 11.
3. Иосеф Смит, “Letter to William W. Phelps, 27 November 1832,” 4, josephsmithpapers.org.
4. Эмма Смит, in "Last Testimony of Sister Emma," *Saints’ Herald,* 1879 оны 10-р сарын 1, 290; spelling standardized; Рассэлл М.Нэлсон, “A Treasured Testament,” *Ensign,* 1993 оны 7-р сар, 62–63-ыг үзнэ үү.
5. Иосеф Смит, *The Joseph Smith Papers, Journals, 1-р боть, 1832–1839,* хянасан Дийн К.Жэссий ба бусад хүн (2008), 9.
6. “Coriantumr” ба бусад хүний нэрийг харахын тулд Роял Скаузэн, *Book of Mormon Authorship Revisited: The Evidence for Ancient Origins,* хянасан Ноэл Б.Рэйнолдс (1997), 61–93-ыг үзнэ үү. Эх гар бичмэлийн баримт нотолгоог Скаузэн ашиглаад, бичвэр дээр хүний нэрсийг анх удаа бичихдээ зөв бичгийн дүрмийн хувьд зөв байсан гэдгийг харуулжээ. Иосеф Смит нэр тус бүрийг анх удаа хэлэхдээ зөв үсэглэж байсан ч дараа дараагийн тохиолдолдоо бичээчийн оюун ухаанд найдсан байснаас нэрс буруу бичигдсэн байж магадгүй.
7. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 522.
8. Эдвард Стивэнсон, Хайрум Л.Андрус, Хэлэн Маэ Андрус, *They Knew the Prophet* (1974), 87.
9. Даниэл Тайлэр, “Recollections of the Prophet Joseph Smith,” *Juvenile Instructor,* 1892 оны 2-р сарын 15, 127; мөн *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит,* 127.
10. Виллиам Тиндейл, С.Майкл Вилкокс, *Fire in the Bones: William Tyndale—Martyr, Father of the English Bible* (2004), 47.
11. *Vicissitudes Illustrated, in the Experience of Nancy Towle, in Europe and America* (1833), 156, 157.
12. *Teachings of Presidents of the Church: Brigham Young* (1997), 343.
13. “Тэр хүнийг магтъя,” *Дуулал,* х. 50.

ИОСЕФ МЭДЛЭГ, ТӨЛӨВШЛИЙГ ТУН ХУРДАН ОЛЖ АВЧЭЭ

“Бошиглогч Иосеф харьцангуй өсвөр насных байсан ба дутуу дулимаг албан боловсролтой байсан мөн мэдлэг, төлөвшлийг ер бусын богино хугацаанд олж авсан зэрэг нь түүний номлолд бүхэлд нь нөлөөлсөн. Тэрээр Анхны үзэгдлийг үзэхдээ 14-тэй, тэнгэр элч Моронайг анх удаа айлчлахад 17-той байв. Тэр алтан ялтсуудыг хүлээн авахдаа 21-тэй, Мормоны Номыг (ажлын 60 хоногийн дотор) орчуулж дуусахдаа дөнгөж 23 хүрсэн байжээ. Бидний Сургаал ба Гэрээн дэх илчлэлтүүдийн талаас илүү нь бошиглогчийг 25-тай эсвэл үүнээс залуу байхад өгөгдсөн. Тэрээр Тэргүүн Зөвлөлийг зохион байгуулахдаа 26-тай, Көртландын ариун сүмийг онцгойлон адислахдаа 30-тай байв.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс, “Joseph, the Man and the Prophet,” *Ensign,* 1996 оны 5-р сар, 71.

Бид илүү сайн байж чадна, 2-р хэсэг:

Есүс Христийн Сүмд байр суурьа олох нь

Христийн Сүмийн гишүүн байснаар ирэх адислалуудыг эдлэхэд саад болох боломжийг бусдад бүү олго.

Бэтси Вандэнбэрг

Редакторын зурвас: Бидний Есүс Христийн сайн мэдээнд итгэх итгэл хэчнээн хүчирхэг ч бай, бид өөрсдийгөө хамааралтай гэдгээ мэдрэхгүй л бол итгэлтэй хэвээр үлдэхэд бэрх байх болно. Сүмийн удирдагчид энэ бэрхшээлийг саяхан Unity in Diversity *гэдэг гарчигтай цуврал видео бичлэгүүдээр авч хэлэлцсэн. 2017 оны 9-р сарын Лиахона дээрх "Бид илүү сайн байж чадна: Бусдыг сүрэгтээ хүлээн авах нь" гэсэн өгүүлэлд бусдыг хүлээн авах бидний үүрэг хариуцлагыг тусгасан болно. Бидний хамааралтай гэдгээ мэдэрч байгаа эсэхээс үл хамааран өөрсдийнхөө итгэлд хэрхэн үүрэг хариуцлагатай хандах талаар энэхүү 2 дахь өгүүлэл харуулдаг.*

8 жилийн турш сүмд яваагүй Пауло руу (бүх нэрийг өөрчилсөн болно) Бразил дахь бишоп нь хэр байгааг нь асуух гэж залгажээ. Пауло эргэж очихыг хүссэн боловч санаа зовоосон олон асуудал бүрэн идэвхтэй байхад нь саад болсон байна. Тэр өдийг хүртэл ганц бие байгаа өөрийгөө гэрлэж, хүүхдүүдтэй болсон хүмүүстэй харьцуулахгүй байж яаж чадах билээ? Тэр ийм урт хугацаа өнгөрсний дараа сүм дээр найзтай болж чадах болов уу? Чадсан ч тэд өөрийнх нь талаар юу гэж бодох бол? Тэр хөрвөгдөж мөн номлолд үйлчилж байсан үеийнх шигээ Сүнсийг мэдрэх болов уу? Дуудлагат ажлуудыг хүлээн авах итгэлтэй байх болов уу?

Утсаар дуудлага хүлээн авснаасаа хойш 1 сарын дараа Пауло Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын Ерөнхий чуулган дээр хэлсэн "Ирж, бидэнтэй нэгд" гэсэн үгийг уншжээ.[1] "Энэ үг надад маш хүчтэй нөлөөлсөн" гэж тэр дурссан юм. Хэдэн долоо хоногийн дараа тэр сүмийн машины зогсоол дээр чичирсхийн суух зуураа машинаасаа гарч сүмийн байр руу орох хүч чадал гуйн залбирч байлаа.

"Бүх зүйл төгс сайн байгаагүй" гэж тэр эргэж очсон анхны жилийнхээ талаар дурсжээ. Байр сууриа олоход амар байгаагүй юм. Гэвч Аврагчтай холбоотой гэдэг мэдрэмж, ариун сүмийн эрхийн бичигтэй болох гүн их хүсэл түүнд эргэлзээ айдсаа даван гарахад тусалжээ. Тэр судруудаа уншиж, залбирч эхэлсэн байна. Тэр хүлээн зөвшөөрөгдөхгүй байгаа юм шиг санагдаж байгаа хүмүүст "Хэрэв та шантрахгүй л бол хүч чадал хүлээн авч, Их Эзэн адисалж байгааг мэдэрч чадна" гэж зөвлөв. "Энэ бол Христийн Сүм гэдэг гэрчлэл надад бий. Гэхдээ та нар жинхэнэ холбоо хамааралтай гэдэг мэдрэмжийг гагцхүү Их Эзэнээс л олох болно."

Паулогийн түүх Сүмийн удирдагчдын *Unity in Diversity* цуврал видео бичлэг дээр тайлбарласан хэд хэдэн санааг илэрхийлж байна. Тэдний захиас өөрсдийгөө хамааралтай гэж мэдрэхгүй байгаа хүмүүст найдвар, зөвлөмж болж байна. Бид заримдаа сүм дээр хүртэл ганцаарддаг ч эдгээр удирдагч, гишүүдийн онцлон тэмдэглэснээр үл зөвшөөрөгдөх буюу үл тоогдох бэрхшээлийг даван гарахын тулд өөрсдийн зүгээс хийж болох зүйлс гэж бий. Бид харьцуулахаас зайлсхийж, эргэлзэж байсан ч урагшилж, эргэж ирэх боломж үргэлж байдаг гэдгийг мэдэн, хамгийн чухал нь Аврагчид итгэж чадна.

Харьцуулахаас зайлсхий: Эцэст нь бид бүгд адислагдах болно

"Та нар өөрийгөө бусадтай харьцуулж эхлэхэд нэг бол сэтгэл гутрал руу, эсвэл бардамнал руу хөтлөгддөг. . . . Адислал хурдан ирэх нь бий. Удаан ч ирэх нь бий. Заримдаа биднийг хөшигний ард талд адислалууд хүлээж байдаг гэдэгт би итгэдэг. . . . Эцэст нь бид бүгд

мөнх амьдралын амлалт нь хүн бүрд зориулагдсан гэдэгт итгэлтэй байж болно.

—Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Гари И.Стивэнсон

Рошэл орон гэргүй хүмүүсийн байранд хэсэг хугацаанд амьдарсныхаа дараа Нэгдсэн Улсын баруун хэсгийн баячуудын хороолол дахь хоёр давхар байшинд нүүж оржээ. Нөхрөөсөө салсан, хэдэн хүүхдээ харж асардаг тэрээр хоёр, заримдаа гурван ажил хийж, хоол унд, түрээсээ төлөх боломжтой болж байв. Тэрээр хөрвөгдсөнөөсөө хойш идэвх султай байсан байна.

"Манай тойргийн бүх хүн надаас хамаагүй дээр амьдралтай ч надад тусалж, миний хувцасласан байдлыг хүлээн зөвшөөрдөг байлаа. Хүн бүр л үнэхээр санаа тавьдаг байсан" гэж тэр тайлбарласан юм.

Рошэл санхүүгийн хувьд маш их дарамттай нөхцөл байдалд байсан ч илүү амар хялбар байдалд байгаа тэднийг үзэн яддаггүй байв. "Мэдээж, би илүү аюулгүй байхыг хүсдэг. Гэхдээ л би хөршийнхөө байшин руу хэзээ ч харж байгаагүй, Бурхан намайг орхисон гэж хэзээ ч бодож байгаагүй. Би Түүнийг миний дэргэд байгааг, тэр бүү хэл намайг муу сонголт хийсэн ч хажууд хамт алхаж байдгийг мэдэрч байдаг" гэж тэрээр дурсан ярив.

Рошэлын ажлын цагийн хуваарь заримдаа хэцүү түвэгтэй байсан ч тойргийн удирдагчид, найз нөхөд нь ариун сүмд очих хүсэл эрмэлзэлдээ хүрэхэд нь түүнд тусалжээ.

"Ариун сүм рүү байнга очдог байх нь энэ хүртэл яваад ирсэндээ талархдаг байхад маань тусалдаг. Би өмнө минь байх юуны ч төлөө санаа зовдоггүй" гэж тэр санаа бодлоо хэлжээ.

Рошэл өөрт нь болон охидод нь амар хялбар байдаггүйг мөн өөрсдийгөө "ХҮГ төгс гишүүн биш" гэдгээ хүлээн зөвшөөрдөг. Тэрээр "Бүх хүнд асуудал байдаг. Төгс гэр бүл гэж байхгүй. Ийм үзэл бодол бусад руу харахын оронд Бурхантай харилцах харилцаандаа илүү төвлөрөхөд нөлөөлдөг" гэдгийг ухаарсан юм.

"Охид маань сайн мэдээ миний амьдралд ямар өөрчлөлт авчирсныг хардаг. Би ч бас ямар өөрчлөлт гарч байгааг мэдэрдэг. Би ажил, гэр бүл, Сүм гээд завгүй байдаг учраас надад харьцуулалт хийх зав байдаггүй. Би зөв зам дээр байгаадаа л аз жаргалтай байна" гэж тэр хэлэв.

Хүчтэй бай: Христ таныг өөрчилж чадна

"Миний хажууд сууж байгаа хүн намайг үл тоомсорлож, тэр бүү хэл холдохыг хүсэж байгаа нь . . . бодит байдал дээр Христ миний талаар юу гэж бодож байгааг мөн Христийн ач ивээлээр хийж чадах бүх зүйлийг маань өөрчилж чадахгүй. . . . Хүн бүр Бурханы хаант улсад, Христийн бие дотор байртай байх болно гэдэгт мөн бодлогогүй, хайхрамжгүй, бүр тэрнээс ч дор хүмүүс үүнд садаа болж чадахгүй гэдэгт бат итгэлтэй байх ёстой.

—Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристофферсон

Мэттью сүмийн жижиг салбаруудад явдаг байв. Тэр эхнэрийн хамт Украйнаас ирсэн хөрвөгч байсан бөгөөд хэд хэдэн дуудлага, олон орны хүмүүсээс бүрдсэн ХҮГ орчинд дасан зохицсон ч хожим Нэгдсэн Улс руу нүүжээ. Том тойргуудын болон соёлын ялгаа өөрсдийгөө "хэрэгцээгүй, зорилгогүй" гэж бодоход тэднийг хүргэсэн байна. "Бидэнд байр сууриа олох боломжгүй юм шиг санагдсан. Бид ням гарагт үл тоомсорлогдож, өргөн дэмжсэн туршлага болон харилцаа холбоогоор дутагдаж байлаа."

Өөр хот руу нүүснийхээ дараа Мэттью эхнэрийн хамт орон нутгийн санваарын удирдагчаа айлчлан ирэхийг хүлээж байсан ч түүнийг ариун ёслолын цуглааны үеэр хөдөлгөөнтэй хүүхдэдээ хараа хяналт тавьж байхыг хүсэх зорилготой ирснийг мэдээд, бухимдал нь дээд цэгтээ хүрчээ. Сэтгэл нь гүн шархалсан Мэттью орон нутгийн цуглааны байр руу хэзээ ч дахиж явахгүй гэж бодсон байна. "Энэ бол Их Эзэний Сүм бөгөөд Аврагч намайг ирээсэй гэж хүсэж байгаа гэсэн гэрчлэл маань намайг зогсоосон доо" гэж тэр тайлбарлав. Сайн мэдээнд оролцох нь амьдралд маань байх ямар ч гомдлын мэдрэмж, хувийн сорилтоос давж гарсан үр дагаврыг авчирдаг."

Сүмийн нөхцөл байдал заримдаа биднийг ганцаардсан, үл тоомсорлогдсон, хэрэгцээгүй мэт санагдуулдаг

нь хожмын үеийн гэгээнтнүүдэд нийтлэг тохиолддог зүйл юм. Католик шашинтай зохиолч Дэвид Миллс сүмд явдаг хүмүүст “өөрсдөөс нь баян эсвэл ядуу, илүү эсвэл бага боловсролтой хүмүүстэй эсвэл өөр үндэстэн ястны, өөр өөр насны хүнтэй харьцах үед” тулгардаг бэрхшээлийг тайлбарлажээ. Бид тэдний хэнийг нь ч олон нийтийн сүлжээндээ нэмэхгүй байж магадгүй гэж тэр тайлбарлалаа. Гэвч шашны үүрэг хариуцлага нь өөрсдийнхөө сонгоогүй хүмүүстэй харилцахыг хэлдэг бөгөөд сүлжээнээс илүүтэй нийгэмлэгийн шинжтэй цөөхөн хэдэн үлдсэн газруудын нэг юм. . . . Та энэ хүмүүсийг хайрлаж сурах хэрэгтэй. Хайрлахыг хүсэхгүй байвал ядаж эелдэг байх хэрэгтэй.”[2] Шашны тойрон хүрээлэлд бусдыг блоколж эсвэл дагахгүй байж болохгүй учраас Бурханд итгэж найдах нь заримдаа асуудлаас гарах цорын ганц арга зам байдаг.

Мэттью ийнхүү Бурханд итгэж найдах нь Сүмд идэвхтэй үлдэхэд амин чухал гэдгийг мэджээ. “Зарим үед намайг Христийн тухай гэрчлэл маань л үргэлжлүүлэн цааш явахад тусалж байв” гэж тэр тайлбарлав. “Сайн мэдээ бид бүгдээс илүү чухал. Христ бидний харахгүй байгаа зүйлсийг хардаг бөгөөд биднийг хэн болж чадахыг мэддэг мөн бидэнд зориулсан орон зай түүнд бий.”

АНУ-ын өмнөд хэсэг дэх гишүүн Жасмин “Амьдралд маань хэт их хөндлөнгөөс оролцдог тойргийнхоо нэгэн эгчтэй сайн харилцаатай байхад надад хэцүү байсан бөгөөд энэ нь надад сүмд эргээд очиход саад болж байсан” гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм. Гэвч түүний бяцхан хүүд санаа зовох сэтгэл нь эргээд очиход ямар байх бол гэсэн эргэлзээг давах тэр үед Жасмин “хэн нэгэн намайг дорд үзэж байгаа эсэхээс үл шалтгаалан бусдын санаа бодолд өөрийгөө Христээс нүүр буруулах боломж олгохоо болих” цаг ирсэн гэдгийг мэдэв.

Төд удалгүй найз нөхөд нь бяцхан гэр бүлийг нь бүрэн дүүрэн хүлээн авч, Есүс Христийн Сүмд өсөж хөгжихөд нь туслах газар руу хүчтэй шуурганаар ч гараад очих хангалттай зоригийг тэр нэгэн ням гарагт олжээ. “Би Сүмийг орхисондоо харамсаж байсан” гэж тэр хэллээ. “Сайн мэдээ бусдын тухай биш, бүр миний тухай ч биш, харин Аврагчийн тухай учраас би бууж өгөөгүйдээ мөн урагш алхсандаа баяртай байдаг.”

Харанхуй руу алх: Гэрэл гарч ирнэ

“Эгэл эмэгтэй, эрэгтэйчүүд ‘Гэрэл замыг минь заан, урдах замаа харах хүртэл харанхуй руу алхаж орно гэдэг бүтэшгүй хэрэг’ гэж хэлдэг. Биднээс хөлөө газарт тавих үед гэрэл асна гэдэгт найдан урагш алхахыг шаарддаг.”

—Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар

Зарим үед ирээдүйд юу хүлээж байгааг бүрэн дүүрэн мэдэхгүй байгаа учраас сайн мэдээн дээр сууриа тавих нь шинэ гишүүдэд хэцүү байдаг. Тайваний гэрийн эзэгтэй Мэй-Синий хувьд итгэлийн энэхүү хэсгээс суралцах нь хүүхдүүдийг дэлхийд авчрах сайн мэдээний зөвлөмжийг багтаадаг. “Манай соёлд

ихэнх гэр бүл нэг хүүхэдтэй эсвэл хүүхдийн оронд тэжээвэр амьтантай байдаг" учраас энэ бол хэцүүхэн алхам гэдгийг тэр ажигласан байна. Бие давхар болох бүрдээ тэр үл мэдэгдэх ирээдүйд хөл тавин, зарим үед хамаатан садан, нийтлэг соёл уламжлалаас ирэх хурц шүүмжлэлийг үл тоомсорлох итгэлтэй байх шаардлагатай байлаа.

Ихэнхдээ урагш алхахын тулд үл мэдэгдэх ирээдүйд хөл тавих шаардлагатай болдог бөгөөд энэ нь шинэ итгэлтнүүдэд айдас төрүүлж байдаг. Энэ нь Их Эзэн аян замд нь тусална гэдэгт итгэх итгэлийг хөгжүүлэхийг шаарддаг юм. Айдас түгшүүр, эргэлзээтэй байх нь суралцах, өсөж хөгжих үйл явцын энгийн нэгэн хэсэг боловч заримдаа үл мэдэгдэх ирээдүй рүү хийх алхмууд нь гэр бүлтэй болох эсвэл Сүмд эргэж ирэх аль нь ч байсан гэсэн айдас төрүүлэм байх нь тодорхой. Учир нь итгэлийн сорилтын дараа гэрчийг хүлээн авдаг юм (Ифер 12:6-г үзнэ үү). Мэй-Син нөхрийн хамт ийм нэгэн гэрчийг гэр бүлээ зохиосны дараа хүлээн авчээ. "Бид хүүхдүүдтэй байгаадаа маш их баярлаж, талархдаг" гэж тэр хэллээ. "Бид арвич хямгач амьдарч, нэг нэгэндээ тусалж, бие биенээ хайрлаж сурсан. Бид тэднийг дэлхийд авчирсандаа талархаж байна."

Ихэнхдээ анхны алхмуудыг хийх хамгийн хэцүү байдаг. Ахлагч Бэднарын хэлснээр "Хамгийн анх [харанхуйд хөл тавих] үед эргэлзээ биш бага зэрэг тодорхой бус байдал, бүр багахан айдас байдаг. Эдгээр нь байдаг л зүйл юм". Урагш алхах үйл явц үргэлж дардан биш байх боловч ("хэзээ ч тасалдахгүй үргэлжлэх мөчлөг биш" гэж тэр тайлбарлав) бид "шат шатаар" өсөж хөгжин, итгэлээ алхам алхмаар өсгөдөг.

Урагш алхахад дадлага шаардлагатай гэж Орос, Европтой хил залгаа Гүрж улсын хөрвөгч Лазар зөвлөлөө. ХҮГ найзуудаа итгэж сурах нь түүний хамгийн анхны алхам байсан бөгөөд тэр санваарын адислал хүлээн авахыг зөвшөөрчээ. "Үүний дараа би номлогчдоос хичээл авах боломжтой болсон" гэж тэр тайлбарлав. Лазарын Есүс Христэд итгэх итгэл өссөн бөгөөд "Би 100% итгэлтэй биш байсан ч гэсэн баптисм хэмээх нэгэн том алхмыг хийсэн. Их Эзэн алхам бүрд минь урам зориг хайрлаж байсан бөгөөд одоо би үүнийг хийсэндээ маш их баяртай байна" гэжээ.

Бүү бууж өг

"Өөрсдийгөө хэт их нүгэл үйлдсэн эсвэл хэт хол явсан эсвэл хэт удаан явсан мөн ямар нэгэн байдлаар хүмүүсийн дунд эргэн ирэх боломжгүй гэж бодож байгаа хүмүүст хандан хэлэхэд: Хэн ч Христийн гэрлийн тусгал хүрэх зайнаас хол унана гэж байдаггүй юм шүү. Ийм байх ч боломжгүй."

—Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд

АНУ-ын Юта мужийн итгэлтэй ХҮГ гэр бүлд өсөж торнисон Брайн Сүм өөрт нь тохирох зүйл биш гэж үзжээ. “Би уран зөгнөлт тоглоом, кино, рок хөгжимд дуртай байсан бөгөөд скаут, судар, семинар, спортод дургүй байсан” гэж тэр хэллээ. Тэр гэрээсээ явмагц орон сууцанд амьдрах болсон бөгөөд “өөрийгөө бэлгийн харьцаа, хар тамхи зэрэг дэлхийн зүйлст зориулжээ." Брайн хэсэг хугацааны турш “дур зоргоороо амьдарч, хэрэн тэнүүчилсний” дараа санхүүгийн асуудалд орж, эцэг эх нь буцаад түүнийг өөрсөд дээрээ авсан ч тэр сүмд эргэж ирээгүй юм.

Охин дүүтэй болсон нь түүнд үзэл бодлоо дахин үнэлж цэгнэхэд хүргэсэн байна. Тэр анх удаа түүнийг тэврэхдээ “тэр зүгээр л нэг амьтан биш гэдгийг би мэдсэн” гэж дурслаа. Тэр бага зэрэг сандарсан байдалтай дүүгийнхээ адисланд оролцсон бөгөөд ариун ёслолын талх, ус ирэх үед “би хүртэлгүйгээр өнгөрүүлсэн ч өөрийгөө сүнслэг байдлаараа цангаж байгааг мэдэрсэн” гэжээ.

Зөрчилдөөнтэй мэдрэмжүүдийнхээ учрыг олох гэж хичээхдээ Брайн тэмдэглэл хөтөлж эхэлсэн байна. “Би нэг өдөр нэлээд орой сүнслэг асуудлуудаа бичиж тэмдэглэн суулаа. Би анхныхаа сүнслэг туршлагыг олж авсан ч энэ нь эерэг зүйл байсангүй.” Тэр бодгалийг нь авахыг оролдож буй хилэнцэт, үзэн ядалт, уур уцаараар дүүрэн хүчийг мэдэрчээ. “Энэ бүхний дараа надад Их Эзэн хэрэгтэй гэдгийг би мэдэрсэн” гэж тэр тайлбарлалаа. Гэвч замаасаа дэндүү холдсон Брайн “Би Түүний тусламж, хамгааллыг хүртэх эрхтэй гэж үү?” хэмээн боджээ. Тэр дахиад ариун ёслолоос хүртэж чадах эсэхтээ эргэлзэв.

Буцаж ирэх зам саад тотгортой байсан. Тамхиа хаяхад хэцүү байсан бөгөөд бишоптоо нүглээ хүлээхэд зориг шаардаж, хуучин найз нөхөд, дадал зуршлаасаа салахад хүндрэлтэй байсан. Түүний гэр бүл, найз охин, бишоп гээд бүгдээрээ түүнийг дэмжсэн ч Брайн хүч чадлын хамгийн гол эх сурвалж нь Есүс Христ болохыг ойлгожээ.

“Их Эзэн надад туслахыг хүсэж байгааг би мэдсэн” гэж тэр дурслаа. “Хуучин хүсэл эрмэлзлүүд шинэ боломжуудаар солигдов. Сайн мэдээний дагуу амьдрахаар хэдий чинээ хичээж зүтгэнэ, төдий чинээ зам маань тодорхой болж байлаа.” Брайныг Их Эзэнд итгэж найдан, Түүний өршөөн, эдгээх хүслийг мэдсэний дараа ариун ёслол түүний хувьд илүү агуу утга учиртай болж, Аврагчид илүү ойртоход нь тусалжээ. “Би хүүхэд байхдаа сүм дээр талх, уснаас олон зуун удаа хүртэж байсан ч эцэст нь ийм мэдрэмжтэйгээр анх удаагаа хүртэж чадсан юм.”

Хэн ч таныг орлож чадахгүй

Машинаасаа гараад, сүм рүү орох, бусад гишүүнд туслах, гомдлын мэдрэмжээ давж гарах, ирээдүйд юу болох талаар бүрэн дүүрэн мэдэхгүй ч сайн мэдээний дагуу амьдрах, нүглээ хүлээх зэргээр бид бүгд амьдралын модонд хүрэх замдаа хүнд хэцүү, тодорхой бус замаар аялдаг (1 Нифай 8-ыг үзнэ үү).

Аврагчийг дагах хувийн үүрэг амлалт маань эсэн мэнд ирэхэд нэн чухал билээ. Сүмийн гишүүд, удирдагчид бидэнд урам зориг өгч, хайраа үзүүлэн, хүлээн авах нь чухал хэдий ч, бидний хүн нэг бүр ганцаараа гэдгээ мэдэж байсан ч Аврагчийг дагахад бэлэн байх ёстой цаг үетэй тулгардаг.

Есүс Христийн Сүмд байр сууриа ол. Битгий харьцуул, харин Христэд өөрийг тань өөрчлөх боломжийг олго. Шагнал авах итгэлийн алхмуудыг хий, эргэж ирэхэд хэзээ ч оройтохгүй гэдгийг сана. “Иймийн тул, хэрэв та нар урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, болгоогтун, Эцэгийн ийн хэлсэнчлэн: Та нарт мөнх амьдрал байх болно” (2 Нифай 31:20). ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Дийтр Ф.Угдорф, “Ирж, бидэнтэй нэгд,” *2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 23–27-г үзнэ үү.
2. Дэвид Миллс, “Go to Church, Meet Annoying People,” 2017 оны 2-р сарын 1, aleteia.org/2017/02/01/go-to-church-meet-annoying-people.

Есүс Христийн сайн мэдээ

ХОРГОДОХ ГАЗАР БА ХАМГААЛАЛТ

Жэтулио Волтэр Жагэр и Силва
Институт ба семинар

Их Эзэн хүмүүсээ хамгаалахыг хүсдэг. Сүм дэх их хавчлагын үед Тэрээр "*батлан хамгаалалтын тулд,* мөн шуурганаас, *хоргодох газар* байж болохын тулд" (С ба Г 115:6; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) Сионд цугларахын ач холбогдлыг онцолсон билээ.

"Эдгээр зарлигуудыг судалснаар" Есүс Христийн сайн мэдээгээр амьдрах үед энэ хоргодох газар, хамгаалалтыг хүлээн авдаг (С ба Г 1:37). Иймээс Сургаал ба Гэрээн дэх хэд хэдэн зарчмыг авч үзэцгээе. *Эдгээрийг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлбэл* бидэнд хамгаалалт болж, өнөөдөр бидэнд тулгарч буй уруу таталт, хилэнц, бусад аюулыг сөрөх хоргодох газар байх болно.

Бид Ариун Сүнсийг эрэлхийлснээр хамгаалагддаг

Ариун Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгах нь дэлхийгээс хоргодох байр, хамгаалалт болдог. Хэрэв Оливер Каудериг илчлэлтийн бэлгийг "ашиглавал" "энэ нь чамайг дайснуудын чинь гараас чөлөөлөх болно, хэрэв энэ нь иим бус байсан аваас, тэд чамайг алж мөн сүнсийг чинь устгалд авчрах байсан биз ээ" (С ба Г 8:4) хэмээн Их Эзэн амласан байдаг. Оливер Каудери Сүнсний дуу хоолойгоор дамжуулан үхэл, нүглээс хамгаалагдах боломжтой байсан гэдгийг санаарай.

Ариун Сүнсний хүчээр дамжуулан үнэнийг хүлээн авах нь биднийг хүмүүний дүрэм журам, Сатаны худал хуурмаг, хууран мэхлэлтээс хамгаална. Их Эзэн "мэргэн хийгээд үнэнийг хүлээн авсан, мөн *Ариун Сүнсийг зам заагчаа болгон авсан,* мөн мэхлэгдээгүй тэд—үнэнээр би та нарт хэлнэ, тэд тас цавчигдан мөн галд хаягдахгүй, харин тэр өдрийг тэсэн гарах болно" (С ба Г 45:57; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) хэмээн амласан билээ. Ариун Сүнсний хүч зүрх сэтгэлд маань үнэнийг бичиж, хууран мэхлэлтээс биднийг хамгаалдаг.

Гэхдээ Сүнсний өдөөлтүүдийг анхааралтай сонсох нь биднийг бүхий л бэрхшээлээс хамгаална гэсэн үг биш. Сургаал ба Гэрээ 122-р хэсэгт хэчнээн зохистой байсан ч бид уй гашуу, сорилт бэрхшээлтэй тулгарна гэдгийг харуулдаг. "Бүх зүйлийг мэддэг" (С ба Г

127:2) Бурханы бодол санаа, мэргэн ухаанд “эдгээр бүх зүйл [бидэнд] туршлага суулгах болно, мөн [бидний] сайн сайхны төлөө байх болно” (С ба Г 122:7).

Бид амьд бошиглогчдыг дагаснаар хамгаалагддаг

Сүм зохион байгуулагдсан өдөр Их Эзэн гэгээнтнүүддээ бошиглогчдыг анхааран сонсохыг зарлигласан байдаг.

“Та нар миний өмнө бүхий л цэвэр ариун байдалд алхан, та нарт түүний өгөх түүний бүх үгсэд хийгээд зарлигуудад анхаарал тавигтун;

Учир нь [Сүмийн ерөнхийлөгчдийн] үгийг та нар миний амнаас гарсан мэтээр бүхий л тэвчээр хийгээд итгэлд хүлээн авах ёстой.

Учир нь эдгээр зүйлүүдийг хийснээр тамын үүд та нарыг дийлэх нь үгүй; тийм ээ, мөн Их Эзэн Бурхан харанхуйн хүчийг та нарын өмнөөс сарниулж, мөн та нарын сайн сайхан хийгээд түүний нэрийн алдар суугийн төлөө тэнгэрийг сэгсрэхэд хүргэх болно” (С ба Г 21:4–6).

Их Эзэн Сургаал ба Гэрээнд “Их Эзэний дуу хоолойг, бас түүний үйлчлэгчдийн дуу хоолойг эс сонсож, *бошиглогчид хийгээд төлөөлөгчдийн үгсэд* анхаарал эс тавих тэд хүмүүсийн дундаас тусгаарлагдах өдөр ирнэ” (С ба Г 1:14; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) гэж хэлсэн билээ.

Амьд бошиглогчдын сургаалууд өнөөдөр бидэнд тулгарч буй бэрхшээлүүдийн талаар байдаг бөгөөд эдгээрийг даван туулахын тулд юу хийх хэрэгтэйг хэлдэг учраас эдгээрийг сонсож, хэрэгжүүлэх нь бидэнд хамгаалалт, аюулгүй байдлыг авчирдаг. Их Эзэний амьд бошиглогчид байгаа нь ямар гайхамшигтай адислал вэ!

Их Эзэн Сургаал ба Гэрээ 101:43–62-т амьд бошиглогчдыг сонсохын ач холбогдлыг харуулахын тулд чидун жимсний цэцэрлэгийн тухай сургаалт зүйрлэлийг ашигладаг. Уг сургаалт зүйрлэл нь бошиглогчийг цамхаг дээрх харуултай зүйрлэсэн байдаг. Эрт үед хүмүүс хотын гаднахыг харж, дайснууд ирэх үед хүмүүст анхааруулах харуулд зориулан цамхаг барьдаг байжээ.

Сургаалт зүйрлэл иймхүү эхэлдэг. “Мөн эргэн тойрны газрыг хэн нэг нь хянаж болохын тулд, миний чидуны моднуудыг гэмтээхээр дайсан ирж мөн жимсний цэцэрлэгийн минь жимсийг өөрсөд дээрээ авахад хугарахгүйн тулд, мөн *цамхаг дээр харуул байхын тулд*, тэдгээрийн эргэн тойронд харуулуудыг тавьж, цамхаг

Сургаал ба Гэрээн дэх сургаалууд биднийг Их Эзэний Хоёр дахь ирэлтэд бэлтгэх үедээ туулах сорилт бэрхшээлээс хамгаалдаг.

OUR SAVIOUR, SUPERSTOCK/GETTY IMAGES-ИЙН ЗУРАГ; АР ТАЛЫН ЗУРГИЙГ DAVID CLAPP/GETTY IMAGES

барь” (45-р шүлэг; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэлл Баллард амьд бошиглогчдын зөвлөгөөг дагаснаар ирдэг хамгаалалт, адислалын талаар заасан байдаг. “Бидний дунд Бурханы бошиглогч байна гэдэг өчүүхэн зүйл биш шүү, ах эгч нар аа. . . . Бид Сүмийн ерөнхийлөгчийн үгээр дамжин ирсэн Их Эзэний зөвлөгөөг эргээр хүлээн авч мөн хурдан шаламгай хариу үйлдэл хийх ёстой. Бошиглолоор ирсэн зөвлөгөөг дагаснаар аюулгүй байдал, амар амгалан, хөгжил дэвшил, аз жаргал ирнэ гэдгийг түүх харуулдаг.”[1]

Бошиглогчдыг сонссоноор ирдэг бие махбодын хамгаалалтаас илүү чухал нь сүнслэг хамгаалалт юм. “Та нарыг унагааж болохын тулд Сатан та нарыг мэхлэхээр эрэлхийлсээр” байгаа учир энэ нь тун хэрэгтэй (С ба Г 50:3). Бошиглогчдыг сонсох нь биднийг дэлхийн гүн ухаанаас мөн “үүгээр тэд мэхлэхийг хүлээн худал хэлдэг хүмүүний овжин заль мэх”-нээс биднийг хамгаалдаг (С ба Г 123:12).

Бид гэрлэлтэндээ үнэнч шударга байснаар хамгаалагддаг

Их Эзэн гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ мөнх байх болно гэж бидэнд амласан билээ (С ба Г 132:19-ийг үзнэ үү). Өргөмжлөлийн энэхүү сургаал нь дэлхийд газар авсан гэр бүлийн харилцааны талаарх худал хуурмагаас хамгаалах хоргодох байр юм.

Хэдийгээр дэлхийн олон дуу хоолой гэрлэлт нь үеэ өнгөрөөсөн, түвэгтэй, шаардлагагүй зүйл гэж тунхаглаж байгаа ч Их Эзэний дуу хоолой “гэрлэхийг хориглодог хэн боловч Бурханаас томилогдоогүй болой, учир нь гэрлэлт нь Бурханаас хүмүүнд томилогдсон билээ” гэж тунхагладаг (С ба Г 49:15).

Их Эзэн гэрлэлтээ хэрхэн хамгаалах талаар “Чи эхнэрээ бүх зүрх сэтгэлээрээ хайрлаж мөн өөр хэнтэй ч биш харин түүнтэй нэгдэн нийлэх ёстой” (С ба Г 42:22) хэмээн заадаг.

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) энэ зарлигийн бүхнийг хамарсан шинж чанарын талаар тайлбарлажээ.

“Их Эзэн *бүх* зүрх сэтгэлээрээ гэж хэлэхдээ зүрх сэтгэлээ хуваалцахгүй, хуваахгүй, салгаж авахгүй байхыг хэлсэн. Харин эмэгтэйчүүдийн хувьд энэ нь ‘Чи нөхрөө *бүх* зүрх сэтгэлээрээ хайрлаж мөн өөр хэнтэй ч биш харин түүнтэй нэгдэн нийлэх ёстой’ гэсэн үг юм.

Өөр хэнтэй ч биш гэдэг үгс бүх хүнийг, бүх зүйлийг хэлж байна. Энэ нь хань ижлийнхээ амьдралд хамгийн чухал хүн болно гэсэн үг. Нийгмийн амьдрал, ажил мэргэжил, улс төрийн амьдрал эсвэл өөр аль ч хүсэл сонирхол ба хувь хүн хамтрагч болох хань ижлээс маань илүү байр суурь эзлэхгүй.”[2]

Бидний харж байгаа зүйлс бидэнд сайнаар эсвэл муугаар асар их нөлөөлдөг. Иймээс л Их Эзэн дараах шүлгэн дээрх сэрэмжлүүлгийг өгсөн гэж би боддог.

БРАЙН КЭРШИСНИК, *CHOOSING EVERYTHING*-ЭЭС ДЭЛГЭРЭНГҮЙГ АВАВ. ХУУЛБАРЛАЖ БОЛОХГҮЙ. АР ТАЛЫН ЗУРГИЙГ CLAUDIO CONTRERAS/NATUREPL.COM/GETTY IMAGES

“Мөн эмэгтэй хүнийг тачаангуйгаар *хардаг* тэрээр итгэлийг үгүйсгэнэ, мөн Сүнстэй байх нь үгүй болно; мөн хэрэв тэрээр үл наманчилбаас тэрээр зайлуулагдах ёстой” (С ба Г 42:23; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Дайсны дайралтаас хамгаалагдахын тулд бидний нүд, зүрх сэтгэл зөвхөн бидний хань ижил, Их Эзэн рүү харсан байх ёстой. Бид хань ижлээсээ өөр хүн рүү харц чулуудах эсвэл өөр хүнийг хүсэх ёсгүй. Бид уг уруу таталтаас хамгаалагдахын тулд зүрх сэтгэл, оюун санаагаа түгжих хэрэгтэй. Энэ бол амжилттай гэрлэлттэй байх Их Эзэний жор юм.

Бид номлолд үйлчилснээр хамгаалагддаг

Бидэнд Сүмд үйлчлэх олон боломж байдаг бөгөөд Их Эзэн “[өөрт нь] үйлчилдэг тэднийг хүндэтгэхдээ баяртай байдаг” (С ба Г 76:5). Номлолд үйлчлэх талаар агуу зарчмуудыг Сургаал ба Гэрээнд заасан байдаг.

Их Эзэн “Мөн явж хаант улсын энэхүү сайн мэдээг тунхаглах, мөн бүх зүйлд итгэлтэйгээр үргэлжлүүлэхэд бүтэлгүйтэхгүй аль ч хүмүүн оюундаа харанхуйлагдах нь үгүй, мөн биендээ ч, үендээ ч, мөчиндөө ч тэр ядарсан байх нь үгүй; мөн толгойнх нь нэг ширхэг үс ч газарт ажиглагдахааргүй унах нь үгүй билээ. Мөн тэр өлсгөлөн явах нь ч, мөн цангах нь ч үгүй байх болно” хэмээн амласан (С ба Г 84:80). Их Эзэн биднийг бэрхшээлээс чөлөөлдөггүй ч биднийг Түүний тэнгэрлэг халамжинд байх болно гэж амладаг гэдгийг санаарай.

Тэрээр “Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно” (С ба Г 84:88) гэж нэмсэн билээ. Хэрэв бид Түүнд үйлчилбэл “мөнхүү улиран тохиох дор чам дээр хүч байх болно; чамд агуу итгэл байх болно, мөн бибээр чамтай хамт байж мөн нүүрний чинь өмнө явах болно” (С ба Г 39:12). Номлолд бүх зүрх сэтгэлээрээ үйлчилдэг хүмүүс “сүнсний мөн биеийн талаар аль алинаар нь адислагдах болно” гэсэн амлалт хүлээн авдаг (С ба Г 14:11).

Их Эзэн мөн энэ хамгаалалтыг үйлчилж буй хүмүүсийн гэр бүлүүдэд өгдөг. “Тэдний гэр бүлүүдийг би хангах болно хэмээх амлалтыг Их Эзэн бибээр тэдэнд өгч байна; мөн үүнээс хойш үр дүнтэй хаалга тэдний төлөө нээгдэх болно” (С ба Г 118:3).

Мөн итгэлтэй номлогчдод “нүглүүд чинь чамд өршөөгдсөн авай, мөн чи нуруун дээрээ боодлуудыг үүрэх болно” гэж амладаг (С ба Г 31:5). Энэ адислал бол бидний бодгалийн хоргодох газар юм.

Бид аравны нэгийн хуулийг дагаснаар хамгаалагддаг

Бид Сургаал ба Гэрээнээс аравны нэгийн талаар дурдсан дараах сургаалыг олж мэддэг. “Болгоогтун, Хүний Хүүгийн ирэлтийг хүртэл эдүгээ энэ нь өнөөдөр хэмээн нэрлэгдэх бөлгөө, мөн үнэнээр энэ нь золиослолын өдөр, мөн миний хүмүүсийн аравны нэгийг төлүүлэх өдөр бөлгөө” (С ба Г 64:23).

90 нь 100-аас илүү агуу учраас аравны нэгийн хууль нь математиктай зөрчилддөг гэж би хэлэх дуртай. Бид орлогынхоо 10 хувийг Их Эзэнд өгөх үед Тэрээр “тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах” болно хэмээн амладаг (Малахи 3:10; мөн 3 Нифай 24:10-ыг үзнэ үү).

Бид итгэлээ хэр хүчтэй байгааг үнэлж цэгнэхийн тулд аравны нэгийн хуульд хэрхэн хандаж байгаагаа анзаарах хэрэгтэй. Аравны нэгээ төлөх нь мөнгөний

Цамхаг дээрх харуулуудын адил бошиглогчид алсыг харан, ирж буй дайсны талаар сэрэмжлүүлдэг.

асуудал биш бөгөөд итгэлийн асуудал юм.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг “Бид аравны нэгийн бүрэн төлөгч байх болон үүнийг дагах хичээл зүтгэлдээ гуйвшгүй байх шийдвэрийг одоо гаргаснаар итгэлдээ хүчирхэгжиж, цагийн явцад бидний зүрх сэтгэл зөөлөрнө. Энэ нь Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бидний зүрх сэтгэлд ирж байгаа өөрчлөлт бөгөөд энэ нь бидний өгөх мөнгө эсвэл эд хөрөнгөнөөс илүү хожмын өдрүүдэд Их Эзэний аравны нэгийг бүрэн төлөгчдийг хамгаалах амлалтыг боломжтой болгож өгдөг [С ба Г 64:23-ыг үзнэ үү]. Хэрэв бид одоо аравны нэгийг бүрэн төлж, үүнийг хийхдээ гуйвшгүй байх үүрэг хүлээвэл өөрсдийгөө энэ хамгаалалтын адисалд тэнцэнэ гэдэгтээ итгэлтэй байж болно.”[3]

Бид мэргэн ухааны үгийг дуулгавартай дагаснаар хамгаалагддаг

Бид олон хор хөнөөлтэй бодис эрүүл мэндийг маань заналхийлж буй цаг үед амьдарч байна. Их Эзэн бидэнд юу тулгарч байгааг мэдэж байсан учраас 1833 онд бошиглогч Иосеф Смитэд “хуйвалдагч хүмүүсийн зүрх сэтгэлд байгаа мөн эцсийн өдрүүдэд байх хилэнц хийгээд бодлуудын улмаас энэхүү мэргэн ухааны үгийг илчлэлтээр та нарт өгснөөр би та нарыг сэрэмжлүүлсэн билээ, мөн урьдаас сэрэмжлүүлж байна” (С ба Г 89:4) хэмээн заажээ.

Их Эзэний эрүүл мэндийн хуулийг дагадаг хүмүүс “хүйсэндээ эрүүл энхийг хийгээд яснуудаа чөмөг хүлээн авах болно [бие махбодын эрүүл мэнд]; мөн мэргэн ухаан хийгээд мэдлэгийн агуу сан хөмрөгүүдийг, бүр нуугдмал сан хөмрөгүүдийг олж авах болно [оюун санааны мөн сүнслэг адислалууд]; мөн гүйхэд мөн ядрах нь үгүй, мөн алхахад мөн цуцах нь үгүй байх болно [бие махбодын эрүүл мэнд]” хэмээх амлалтыг хүлээн авдаг.

Мөн Их Эзэн энэ хуулийг дагадаг хүмүүст аюулгүй байдлыг амласан. “Мөн устгагч тэнгэр элч, Израилын хүүхдүүдийн дэргэдүүр өнгөрсний адил тэдний дэргэдүүр өнгөрч, мөн тэднийг хөнөөхгүй байх болно хэмээх амлалтыг Их Эзэн бибээр тэдэнд өгч байна” (С ба Г 89:18–21).

Үхэл бол мөнхийн төлөвлөгөөний нэг хэсэг учраас энэ амлалт нь бид үхэхгүй байх болно гэсэн үг биш юм. Гэхдээ “нүглүүдийнх нь төлөө зөв шударга бус хүмүүсийг шийтгэхээр ирдэг

GETTY IMAGES-ИЙН АВСАН ЦАМХГИЙН ЗУРАГ; *КАЛИФОРНИЙН САКРОМЕНТО АРИУН СУМ*, САНДРА РАСТ

мөн эрт цагт ёс бус египетчүүдийг ёс бус явдлынх нь төлөө цохиж байсан устгагч тэнгэр элч [Египетээс гарсан нь 12:23, 29] гэгээнтнүүдийн дээгүүр өнгөрөх болно.”[4]

Бид ариун газруудад зогссоноор хамгаалагддаг

Их Эзэн бидэнд ахин дахин “ариун газруудад зогсогтун” (С ба Г 45:32; 87:8; 101:22-ыг үзнэ үү) хэмээн зарлигласан байдаг. Мэдээж хэрэг, бидний ариун сүмүүд бол ариун газар юм. Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит (1876–1972):

“Хэрэв бид тэр үедээ юу хийж байгаагаа ойлгох юм бол хишиг хүртэх ёслол нь бидний насан туршийн, ариун сүмд очдоггүй хүнд олдохгүй хамгаалалт болох юм.

Би аавынхаа [ерөнхийлөгч Жозеф Ф.Смит] хүнд хэцүү цагт, уруу татагдах үедээ Их Эзэний Өргөөнд хийсэн гэрээ, өгсөн амлалтаа боддог байсан мөн тэдгээр нь түүний хамгаалалт байсан гэж ярьж байхыг сонссон”[5] хэмээн заасан юм.

Ариун сүмүүдээс гадна Сүмийн байр, анги болон бидний гэр орон ариун газрууд хэмээн онцгойлон адислагдсан байдаг. Хэрэв амьдардаг хүмүүс нь зүрх сэтгэлдээ цэвэр ариун, Бурханы зарлигуудыг дагадаг бол эдгээр газар нь ариун байх болно. Бид зарлигуудыг сахих үедээ Ариун Сүнсний нөхөрлөл, удирдамж, тайтгарлыг хүлээн авдаг. Хэрэв Тэр бидний байнгын хамтрагч болж чадах юм бол бид ариун газруудад зогсох нь тодорхой.

Дүгнэлт

Бид эдгээр зарчмаас суралцаж, дагах үедээ Есүс Христийн сайн мэдээний өгдөг олон төрлийн хамгаалалтыг Сургаал ба Гэрээнээс олж мэддэг. Бид энэ хамгаалалтыг хаанаас олж болохоо лавлаж болно.

Гэгээнтнүүдэд хайр, нигүүлслээ үзүүлдэг Их Эзэн бидэнтэй хамт байх болно хэмээн амласан. “Зоригтой байгтун, бяцхан хүүхдүүд минь; учир нь бибээр та нарын дунд байна, мөн бибээр та нарыг орхих нь үгүй” (С ба Г 61:36). “Анхааргтун, . . . та нарын Бурхан Их Эзэн, бүр Есүс Христ, хүмүүний сул талыг хийгээд уруу татагдсан тэдэнд хэрхэн туслахыг мэддэг, та нарын өмгөөлөгч тэрээр хэлж байна” (С ба Г 62:1).

Бид Аврагч Есүс Христийн Цагаатгал, сургаалыг амьдралдаа хэрэгжүүлснээр ачаагаа хөнгөлөх мөн нүгэл, бэрхшээлүүдээ даван гарах хүч чадлыг өгч, биднийг гэгээнтнүүд болгодог хамгаалалт, хоргодох газрыг хүлээн авч чадна. ■

Зохиогч нь Бразилийн Куритибад амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. М.Рассэлл Баллард, “His Word Ye Shall Receive,” *Лиахона,* 2001 оны 7-р сар, 80.
2. *Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* (2006), 199.
3. Хэнри Б.Айринг, “Spiritual Preparedness: Start Early and Be Steady,” *Liahona,* 2005 оны 11-р сар, 40.
4. Бага Ж.Рубэн Кларк, in Conference Report, 1940 оны 10-р сар, 17; мөн *Сургаал ба Гэрээний суралцагчийн гарын авлага* (Сүмийн Боловсролын Системийн гарын авлага, 2001), 211.
5. Жозеф Фийлдинг Смит, “The Pearl of Great Price,” *Utah Genealogical and Historical Magazine,* 1930 оны 7-р сар, 103; мөн *Сургаал ба Гэрээний суралцагчийн гарын авлага,* 259.

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРААР ХРИСТИЙН ХАЙРЫГ ТҮГЭЭХ НЬ

Би 2016 оны Христийн мэндэлсний баярын “Дэлхийг гэрэлтүүл” хэмээх аянд оролцохдоо сэтгэл их догдолж билээ. Би энэ аяны өдөр бүр сайн үйлс хийх уриалгыг, нэн ялангуяа тав дахь өдрийн “Есүс өвчтэй нэгнийг эдгээсэн шиг та ч мөн хэн нэгнийг эдгээж чадна” гэсэн уриалгыг тэсэн ядан хүлээж байв.

Би тэр өдөр ажлаа тараад, өвөө эмээ дээрээ очих санаатай хотын саарал гудамжаар алхаж явлаа. Надад маш сайхан санагдаж байв. Христийн мэндэлсний баярын үе байсан бөгөөд дэлхий нэг л гэгээлэг байв. Хандив өргөхийг хүссэн хонхны дуу жингэнэнэ. Намайг трамвайн зогсоол руу дөхөж байтал орон гэргүй нэгэн эмэгтэйн хашхирах дуунаар хонхны жингэнээ бүдгэрч сонсогдлоо.

Тэр эмэгтэй “Та нар худлаа шүү дээ. Би өлсөж, даарч байна. Та нар өөрсдөдөө л авдаг. Та нар худлаа” гэж орилж байв.

Ихэнх хүн тоохгүй өнгөрч байсан ба хонх барьсан хүн хонхоо үргэлжлүүлэн дуугаргасаар байв. Би чихэвчээ зүүсэн боловч нөгөө эмэгтэйн “Та нар худлаа. Би өлсөж, даарч байна” гэж хашхирах сонсогдсоор байлаа.

Би халаасандаа хорин долларын дэвсгэрт байгааг санав. Үүнийг тэр эмэгтэйд өгдөг юм билүү гэж бодтол “Үгүй ээ. Үүнийг хэн нэгэнд өгөх бол сайхан хүнд л өгөх хэрэгтэй” гэсэн бодол орж ирэв. Гэтэл Ариун Сүнс надад нөгөө уриалгыг болон миний хэнтэй адил болох гэж хичээж байгааг сануулсан юм. Есүс хаадын Хаан байсан атлаа хамгийн дорд хүмүүст үйлчилсэн. Тэгээд би юу хийх хэрэгтэйгээ ойлгоод, уг эмэгтэйг чиглэн алхав. Тэр эмэгтэй орилж хашхирахаа больсон ч нүдээ анихад нь нулимс хацрыг нь даган урсаж байлаа. Би халааснаасаа хорин долларын дэвсгэрт гарган түүнд өгөв.

“Хэцүү өдөр байв уу?” гэж намайг асуухад

Тэр над руу харж, “Тийм ээ” гэв.

“Надад харамсалтай байна” гэж би хэлээд, түүнийг тэврэхэд тэрээр трамвай иртэл мөрийг минь налан уйлав.

Биднийг бие биендээ баяртай гэж хэлтэл эмэгтэй “Баярлалаа. Зөвхөн мөнгөнд биш ээ. Намайг тэврэсэнд баярлалаа. Надад тэврэлт хэрэгтэй байлаа” гэж хэлсэн юм.

Гудамжинд ямар ч хамаагүй хүнийг тэврэх нь миний хийхээр төлөвлөснөөс өөр зүйл байсан ч Есүсийн хийх байсан зүйл гэдгийг би мэддэг. Өөртэй нь адил үйлчлэх боломж өгсөнд би Их Эзэнд талархдаг. Есүс өвчтэй, ядуу, гачигдалтай хүмүүст тусалж байсан. Би ч гэсэн тэгж чадна. ■

Жордан Врайт, АНУ, Юта

Эмэгтэйг чиглэн алхав. Тэр эмэгтэй орилж хашхирахаа больсон ч нүдээ анихад нь нулимс хацрыг нь даган урсаж байлаа.

Хоёр том хайрцган дээр миний нэрийг бичсэн хэрнээ буцах хаяггүй байв.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭРОЛИН ВИББЭРТ

НАДАД ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН БЭЛЭГ ӨГЛӨӨ ГЭЖ ҮҮ?

Би 2003 оны Христийн мэндэлсний баярын үеэр Калифорнийн Сакраменто номлолд үйлчилж байсан юм. Миний хамтрагч болон байранд хамт амьдардаг байсан өөр хоёр эмэгтэй номлогч хамаатан садан, найзуудаасаа бэлэг, захидал авч эхлэв. Гэхдээ миний хувьд ийм зүйл байхгүй гэдгийг би мэдэж байсан.

Аргентинд байдаг гэр бүл маань бага орлоготой, бичсэн захидал нь хоёр, гурван сарын дараа ирдэг байв. Би хэдий гэр бүлээсээ хол байсан ч Христийн мэндэлсний баярыг Есүс Христэд үйлчлэн өнгөрүүлэхдээ тун баяртай байлаа.

Баярын өмнөх орой биднийг орондоо орох гэж байтал номлогчдын нэг нь хэн нэгэн хүн миний нэрийг бичсэн боодолтой зүйлс үлдээснийг хэлэв.

“Надад уу? Тийм байх учиргүй дээ” гэж би гайхан хэллээ.

Хоёр том хайрцган дээр миний нэрийг бичсэн хэрнээ буцах хаяггүй байв. Би маш их баярлаж, бас нөгөө номлогчид ч миний өмнөөс баяртай байсан юм. Боодолтой зүйлсийг задалтал дотор нь бэлэг сэлт, амттан, хүүхдийн зурсан зураг, бас бус зүйл байв. Би нулимсаа барьж дийлсэнгүй.

“Хэн над руу энэ боодолтой бэлгийг явуулсан байж болох вэ?” гэж би гайхав. Бидний хэн нь ч мэдэхгүй байсан ч ийм өгөөмөр зангийн төлөө бид дөрвүүлээ баясаж билээ.

Христийн мэндэлсний баяраас хойш хэд хоног өнгөрсөн ч хэн надад бэлэг илгээснийг би мэдэхгүй л байв. Тэгээд би номлолын алба руу утасдаад, номлолын ерөнхийлөгчийн нарийн бичгээс хэн надад ийм гайхамшигтай бэлэг явуулсныг асуув. Тэрээр нэг тойргийн нэрээ нууцлахыг хүссэн гишүүн Христийн мэндэлсний баяраар надад бэлэг илгээхээр шийдсэн гэдгийг хэлсэн юм. Христийн мэндэлсний баярын өмнөх орой тийм их хайр авчирсан тойргийн өгөөмөр сэтгэлд болон номлолын минь үеэр үзүүлсэн дэмжлэгт би үргэлж талархах болно.

Сүмийн гишүүн бүр урмын үг, үйлчлэлээрээ дамжуулан гэрээсээ хол байгаа номлогчдод гэртээ байгаа мэт мэдрэмж төрүүлэх боломжтойг би ухаарсан. Энэ бол миний амьдралын хамгийн сайхан баяруудын нэг байсан юм. Би Аврагчид үйлчилсэн бөгөөд Түүний Сүмийн гишүүдээр дамжуулан Түүний хайрыг мэдэрсэн билээ. ■

Элизабэт Андэрсэн Богадо, Аргентин, Ньюкен

ЖОЛИ РОЖЕРСИЙН ЗУРАГ ЧИМЭГЛЭЛ

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯР ОХИНЫ МИНЬ НҮДЭЭР

Би гэр бүлийнхэнтэйгээ хамт Христийн төрөлтийг бодитоор харуулсан малын хашаа руу ороход ямар нэгэн тайван амгалан байдал биднийг нөмрөв. Мал амьтад хашаандаа байсан ба Иосеф, Мариа хоёр шиг хувцасласан эрэгтэй, эмэгтэй хоёр хүн зогсож байсны эмэгтэй нь нялх хүүхэд тэвэрчээ. Тэд бяцхан хүүхэд рүү харж, амгалан дөлгөөн байдалтай байв. Тэнд уур амьсгал бүхэлдээ нам тайван байсан юм.

Би эхнэр, том хүүхдүүдтэйгээ хамт зогсоод, хамгийн бага охин маань бидний урд бухал дээр сууж байв. Охин маань хөдөлгөөнгүй тайван, харц нь хүүхэд дээр тогтсон байлаа. Гэр бүлийнхэн маань явахаар зэхэх үед би охиныхоо мөрөн дээр гараа тавиад, явах цаг боллоо гэж шивнэв. Харин охин маань бяцхан Есүстэй хамт баймаар байна гэж хэлсэн юм. Охиныгоо тэгж хэлэхэд миний сэтгэл хөдөлж, түүнтэй хамт үлдэхээр шийдэв.

Хэдэн минутын дараа би охиныхоо гараас зөөлөн бариад, явах хэрэгтэйг хэлэхэд охин маань дахиад жаахан баймаар байна гэлээ. Би охиноо тэврээд, хажууд нь өвдөглөн суув.

Тун удалгүй надад цаг хугацаагаар аялж, Мариа, Иосеф хоёртой хамт байсан юм шиг санагдлаа. Тэгэхэд би хамт баймаар байна гэж хэлсний нь учрыг ойлгож билээ. Сүнс намайг нөмрөн авсан мэт санагдав. Тэр газарт байхад Аврагчийн дэргэд байгаа мэт мэдрэмж төрж байсан. Нүд минь нулимсаар дүүрч, би Түүний хайрыг мэдэрч байлаа. Бидний явах цаг болж, би балчир охиноо дээш өргөн, гарах хаалга руу зүглэх зуур охиныгоо бяцхан Есүстэй салах ёс гүйцэтгэн, хэчнээн их хайртайгаа хэлж байхыг сонссон.

Би үлдсэн амьдралынхаа турш нандигнан дурсах үйл явдлыг тэр орой охинтойгоо хамт өнгөрүүлсэн бөгөөд тэрхүү сайхан боломжийг бараг алдахаа шахсан билээ. Тэр шөнө би бэлэг авсан. Би Бурхантай илүү ойр байж, Түүний хайрыг

Охин маань хөдөлгөөнгүй тайван, харц нь хүүхэд дээр тогтсон байлаа.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АЛЛЕН ГАРНС

мэдэрсэн. Би Аврагчид болон Түүний мэндэлснийг дурсан санах болсон тэр боломжинд талархдаг. Аврагчийн амьдрал, үлгэр жишээ, Цагаатгал нь Бурханы бүх хүүхдээ гэсэн дуусашгүй хайрын гайхамшигтай бэлэг гэдгийг би мэднэ. Би тэрхүү бэлгийг зүрх сэтгэлийнхээ угт үргэлж нандигнах болно. ■

Аарон Адамс, АНУ, Өмнөд Каролина

АВРАГЧИД ӨГӨХ ГЭР БҮЛИЙН БЭЛЭГ

Арван хоёрдугаар сар айлчлан ирэхэд би Христийн мэндэлсний баярын улиралд бэлдээд завгүй байв. Бид 4 жилийн турш Христийн мэндэлсний баярыг гэртээ тэмдэглэсэн ч энэ жил би халгаж байлаа. Би нөхөртэйгөө бэлэг худалдаж авах, хоол бэлтгэх зэрэг хийх ёстой бүх зүйлийнхээ талаар ярилцаж байхдаа энэ жилийн Христийн мэндэлсний баярын үдэшлэгийг цуцлаад, арай өөр зүйл хийхээр шийдсэн юм. Бид Аврагчид бэлэг болгон өгөх ямар нэгэн зүйл хийхийг хүссэн.

Арван хоёрдугаар сарын турш бид гэр бүлийн үдшүүдээ Есүс Христийн амьдралын тухай болгож, ариун сүм рүү явж, гэр бүлээрээ хийх үйлчлэлийг төлөвлөв. Нөхөр маань бишоп байсан бөгөөд Христийн мэндэлсний баярын өдөр бид тойргийнхоо бэлэвсэн эмэгтэйчүүдэд дуу дуулж өгөхөөр шийдэж, гэр бүлээрээ хэд хэдэн дуу бэлдэж эхлэв. Хүүхдүүд маань "Тэжээлийн тэвшинд" (*Hymns*, д. 206) дууг дуулах дуртай.

Христийн мэндэлсний баярын өмнөх өдөр бид айлуудаар зочлохдоо авч явах Христийн мэндэлсний баярын зурвастай ил захидал, зууш бэлдсэн юм. Гэр бүл маань эв нэгдэлтэй байж, бусдад хайраар туслахдаа баяртай байгааг харахад сайхан байсан. Би Христийн мэндэлсний баярын сүнсийг мэдэрч чадсан.

Христийн мэндэлсний баярын өдөр хүүхдүүд маань айлуудаар зочлохыг тэсэн ядан хүлээж байв. Бид айлчлан очсон айл бүрдээ аз жаргалтай байсан бөгөөд дуулах бүрд дууллууд илүү сайхан болж байгаа мэт санагдсан. Биднийг хамгийн сүүлийн айлдаа ирэхэд хэн ч байхгүй юм шиг байлаа. Хэдэн минут хүлээсний дараа хүүхдүүдийн тэвчээр алдагдаж эхлэв. Тэгтэл ням гаргийн хувцсаа өмсөж, үсээ сайхан янзалсан нэгэн бэлэвсэн настай эмэгтэй бидэнтэй уулзахаар гарч ирлээ. Тэр биднийг хараад, нүдэнд нь нулимс цийлэгнэв. Миний ч бас сэтгэл хөдөлж, арай ядан дуулж дууслаа.

Биднийг гэр рүүгээ явах үед таван настай охин маань гэр рүүгээ явахгүй, дуулаад л баймаар байгаагаа хэлсэн юм. Намайг хариу хэлэхээс өмнө есөн настай хүүхэд маань "Бид дараа жил үүнийг дахин хийнэ шүү дээ!" гэж хэлэв.

Бид бусдыг өргөн дэмжиж, Есүс Христэд хайраа харуулсан учраас энэ Христийн мэндэлсний баяр гэр бүлийн маань хувьд үнэхээр мартахааргүй сайхан байсан. Би тэр өдрийн үйл явдлын талаар бодохдоо Их Эзэний хайрыг мэдрэн, Түүний "Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг" (Матай 25:40) гэх үгсийг санасан билээ. ■

Мариа Апарэсида да Киямa Силва, Бразил, Сан Пауло



2016 онд болсон Пеннсильванийн Филадельфи ариун сүмийн онцгойлон адислах ёслол Жозефинд долоо хоног бүр ариун сүмд орох боломж олгожээ. Тэр ариун сүмд амьдралын сорилт бэрхшээлийг давахад туслах хүч чадал, эдгэрлийг олж авдаг байна.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЛЭСЛИЙ НИЛССОН

Жозефин Сийр

АНУ, Пеннсильвани

Би хүнд хэцүү нөхцөлд төрсөн. Ээж маань Либерийн цагаач учраас бид ядуу тарчиг амьдралтай байсан бөгөөд ээжийн минь итгэж найдан намайг үлдээгээд явсан асран хамгаалагчид намайг хүүхэд байхад зодож дарамталдаг байв. Энэ нь амьдралыг минь зарим талаар маш хүнд хэцүү болгосон.

Зовлон бэрхшээл маань намайг сайн мэдээний дагуу амьдрахаар шийдэмгий байхад хүргэсэн юм.

Таны хожмын үеийн гэгээнтэн эсэхээс үл хамааран амьдрал хүнд хэцүү байдаг. Аврагчтай мөн хүү Енохтойгоо харилцах харилцаа маань хүч чадал авчирдаг. Ариун сүмд хийсэн гэрээнүүдээ сахих нь мөн хүч чадал өгдөг.

Үнэн ямагт үнэнээрээ л байдаг. Үүнтэй маргах хэрэггүй. Үүнийг батлах ч албагүй. Үнэн л бол үнэн. Энэ бол бодит. Хүн бүрийн хувьд бодит. Энэ бол Ютагийн Солт Лэйк Сити хотод амьдарч байгаа хүмүүст ч, Филадельфигийн ядуусын хороололд амьдардаг хүмүүст ч мөн адил бодит юм. Бид үүнээс л урам зориг авах ёстой.

Авьяаслаг монголчууд

По Ниэн (Фэлипэ) Чоу, Петра Чоу, Очиржавын Одгэрэл нар

Өнгөрсөн оны 12-р сард Монгол Улаанбаатар Баруун, Зүүн гадасны найрал дуучид үндэсний хэмжээний телевизийн *Авьяаслаг монголчууд* шоуны хагас шигшээд шалгаран үлджээ. Найрал дуучид нь институт, семинарын суралцагчид, зарим нь буцаж ирсэн номлогчид байв. Тэд итгэл үнэмшлээ хуваалцах ийм боломж гарч ирнэ гэдгийг төсөөлөө ч үгүй байсан.

2015 онд Бусийн далын ахлагч Монголд айлчлан очихдоо Сүмийн олон нийттэй харилцах хүчин чармайлтын тал дээр сургалт явуулжээ. Улаанбаатар Баруун гадасны ерөнхийлөгч Очиржавын Одгэрэл тэр асуудлыг хэрхэн шийдвэрлэхээ сайн мэдэхгүй байв. 2016 оны 1-р сард хүргэн ах нь түүн рүү утасдаад, “би *Авьяаслаг монголчууд* шоуг үзэж байна. . . . Танай Сүмийн найрал дуу шоунд оролцох хэрэгтэй гэсэн хүчтэй мэдрэмж төрлөө” гэж хэлжээ.

Ерөнхийлөгч Одгэрэл найрал дууны удирдаач Пүрэвийн Өнөржаргал эгчтэй энэ санааныхаа талаар ярилцсан байна. Өнөржаргал эгч ч, найрал дуучид ч гэсэн энэ боломжийн талаар сэтгэл өөдрөг байв. Найрал дуучид Сион буюу монгол хэл дээр *сэтгэл, итгэл, оюун, нэгдмэл* гэсэн үгсийн товчлолоос бүрдсэн нэрээрээ олонд танигдсан.

Эхний шат

2016 оны 3-р сард болсон шоуны эхний шатанд “Сион” хамтлаг хоёр дуу дуулсан юм. Шоуны нэг шүүгч нь “Та нарын царайнаас гэрэл цацарч байгааг би харлаа. . . . Бид та нарын видео бичлэгийг дэлхий даяар үзүүлэхийн тулд YouTube дээр тавих хэрэгтэй юм байна” гэж хэлэв.

Өөр нэг шүүгч тэднээс шоуны ялагч болоод, 50 000 ам.доллар хожвол юу хийх вэ гэж асуув. Бүгдийг нь Христийн мэндэлсний баярын онцгой бэлэг болгон өнчин хүүхдийн асрах газар хандивлана гэж хариулсан нь шүүгчдэд онцгой сэтгэгдэл төрүүлжээ.

Хоёрдугаар шат

Шоунд 400 оролцогч оролцооноос Сион хоёрдугаар шатанд үлдсэн 200 оролцогчийн нэг болсон ч тоглолт найрал дууны 35 гишүүний тэн хагас нь оролцох байсан гадаснуудын хамтарсан өсвөр үеийнхний чуулгантай давхацжээ. Найрал дуучид хоёрдугаар шатанд оролцохоор шийдсэн учраас тоглолтынхоо дараа өсвөр үеийнхний чуулган руу автобус хөлслөн найман цаг явав.

Монголд харьцангуй цөөн хүн Сүмийг мэддэг боловч найрал дуучид энэ байдлыг өөрчлөхөд хувь нэмрээ оруулжээ.

Хоёрдугаар шатны 200 үзүүлбэрээс Сион хагас шигшээд шалгарсан 32 оролцогчийн нэг болов. Найрал дууныхан *Авьяаслаг монголчууд* шоутой холбоотойгоор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч эхэлсэн юм.

Хагас шигшээ

Найрал дуучид хагас шигшээд оролцохоор 6 сараас 9 сар хүртэл бэлтгэл хийв. Тоглолт болох өдөр тэд хасах 34 хэмийн хүйтэн цаг агаартай үед өглөөний дөрвөн цагт босжээ. Найрал дууны гишүүн Энхтүвшингийн Номуунгэрэл эгч “Хамтлагийн олон гишүүн ханиад хүрсэн байсан. Гэвч бид тэдний төлөө залбирсан учраас тэд эдгэрч байлаа” гэж хэлэв.

Монгол орон даяар хүмүүс шоуг үзэн, мессэжээр саналаа өгч байв.

Пүрэвдоржийн Шижир ах “Телевизийн энэ шоуны дараа олон хүн Сүмийн талаар эерэг хандлагатай болж байна” гэж хэлсэн.

Адислалууд

Найрал дууны гишүүд өөрсдөө бас адислал хүлээн авсан юм. Төмөрсүхийн Одгэрэл ах “Бид жилийн туршид ажил, амьдралдаа тулгарч байсан саад бэрхшээлээ зохицуулж, цаг заваа зориулан, анхаарал тавьж ирсэн. Хэчнээн хэцүү байсан ч бид олон адислал хүлээн авсан. Би Их Эзэнд зориулан цаг гаргах, золиослол хийх талаар их зүйл ойлгож сурсан юм” гэж хэлэв.

Найрал дууны гишүүдийн итгэл өсөж хөгжсөнөөс гадна тэд өөртөө итгэх итгэл, найз нөхөрлөл, нэгдмэл байдлыг олж авчээ. “Найрал дуунд дуулсан нь хэрхэн бусдыг уучлах, нэг нэгнээ дэмжих талаар суралцахад маань тусалсан. Бид илүү нэгдмэл болсон” хэмээн Өлзийдүүрэнгийн Ганбаатар ах хэлэв. Тунгалагтуулын Билгүүнзаяа эгч “өөртөө эргэлзэж, хийж чадахгүй нь гэж бодох хэрэггүй юм байна” гэдгийг ойлгож ухаарчээ.

Лхагважавын Баярцогт ах “Найрал дуунд дуулсан минь манай гэр бүлд олон адислал авчирсан. Бас тодорхой хугацаанд хайж байсан асуултуудынхаа хариултыг олж авахад надад тусалсан. Удирдагчид маань гарц шийдэл санал болгож байв. . . . Мөн удирдагчид маань Бурханаар дуудагддаг гэсэн гэрчлэлийг минь баттай болгосон” гэж хэлэв.

“Би *Авьяаслаг монголчууд* шоунд оролцоод, нэг нэгэндээ урам зориг өгч, дэмжиж байх нь [бидний] амжилтын түлхүүр юм байна гэдгийг ойлгосон” хэмээн Далайхүүгийн Онон эгч ярилаа. Онон эгч олон үүрэг хүлээж байсны нэг нь найрал дууны гишүүдийг зохион байгуулах үүрэг байсан бөгөөд энэ нь түүний удирдагч байх чадвараа хөгжүүлэхэд тус болжээ. Тэрээр “Бид Их Эзэн биднийг удирдан, сүнслэгээр нөлөөлж байсан гэдгийг мэдэрч байсан. Бидэнд заримдаа өвдөх, завгүй байх, ядрах, сэтгэл санаагаар унах зэрэг явдал тохиолддог байсан. Гэсэн ч бид хамтдаа залбирсан үедээ илүү хүч чадалтай, тэсэж тэвчих хүсэлтэй болдог байсан” хэмээн өгүүлэв.

Хэдий найрал дуучид эцсийн шатанд үлдэх хангалттай санал аваагүй ч тэдний үзүүлбэр Монгол улс даяар Сүмийг таниулахад чухал ач холбогдолтой болсон. Ерөнхийлөгч Одгэрэл “Бид санваарын удирдагчдынхаа даалгаварт дуулгавартай байсан ба Их Эзэн замыг бэлтгэсэн. . . . Одоо бүхэл хотоороо [Улаанбаатар] *Авьяаслаг монголчууд*” шоунд оролцсон Мормон найрал дуучдын тухай ярьж байна” хэмээн ярьсан юм. ■

Нийтлэлийг бичигчид нь АНУ-ын Юта болон Монголын Улаанбаатарт амьдардаг.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ ОЧИРЖАВЫН ОДГЭРЭЛИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР, ОЛОН ХҮНИЙ ЗУРГИЙГ GETTY IMAGES-ЭЭС АВАВ

Аврагчид өргөх миний **бэлэг**

Чэрстан Пикстон

Орос орон бол өвөлдөө маш хүйтэн, бүрхэг, жилийн олон хоног бүүдгэр, муухай байдаг орон юм. 11-р сарын сүүлээр нэг муухай цаг агаартай өдөр надад ганцаардсан, хангалттай сайн байж чадахгүй байгаа, сайн номлогч байх чадваргүй мэт санагдав. Би нэгэн шинэ номлогчийг сургах үүрэг даалгавар аваад удаагүй байсан юм. Харт эгч гайхамшигтай номлогч байлаа. Надад шинэ хэлээ илүү сайн сурах, үлгэр жишээ байх, сургаал сонсох хэн нэгнийг олох гэсэн үүрэг өгсөн юм.

Бид шинэ номлолын ерөнхийлөгч маань манай Перм бүсээс таван цагийн зайтай байдаг Екатеринбургт бүсийн чуулган хийх гэж байгааг сонссон байсан. 12-р сарын нэг жихүүн өглөө эрт Харт эгч бид хоёр галт тэрэгний буудал руу явав.

Галт тэрэг хүлээж байхдаа би өөрт төрж байсан мэдрэмжийнхээ тухай эргэцүүлэн бодлоо. Би удахгүй болох баярын тухай, гэр бүлийнхэнтэйгээ хамт байхыг маш их хүсэж байгаагаа бодов. Номлогч байх гэсэн сэтгэлийн их хөөр замхран арилж байсан бөгөөд есөн сар номлогчоор үйлчлэхдээ их зүйл хийж гавиагүй юм шиг санагдсан. Бидний суух галт тэрэг дохиогоо хангинуулсаар ирэхэд бид галт тэргэндээ орж, суудлаа эзлэв. Суугаад л би Аврагчийн тухай бодож байлаа. Би нүдээ аниад, хэрхэн өөрийнхөө тухай бодохоо больж, Аврагч дээр илүү сайн анхаарлаа төвлөрүүлэхээ мэдэх чадвартай байхыг гуйж залбирав.

Маргаашийн бүсийн чуулган дээр ерөнхийлөгч Раст сайхан бөгөөд зүрх сэтгэлд хүрсэн үг хэлсэн юм. Раст эгч үг хэлэх гэж босоод, Аврагч бол төөрсөн нэг хонийг олоод, сүрэгт нь авчрахын тулд явдаг хоньчин байсан тухай жирийн нэг түүх хуваалцав. Тэрээр Аврагчийн бидний төлөө хийсэн золиослолын талаар яриад, эцэст нь номлогч бидэнд Түүний алдагдсан хонийг сүрэгт нь авчрахаар үйлчлэх боломж байгаа тухай хүчтэй гэрчлэл

Надад номлогч байхад тохирохгүй юм шиг санагдав. Би зөвхөн өөрийгөө л боддогоо больж, Аврагчид анхаарлаа төвлөрүүлэхийн тулд юу хийж болох вэ?

хуваалцсан юм. Раст эгч Христийн мэндэлсний баяраар Аврагчид ямар бэлэг өгч болох тухайгаа бодоорой хэмээн уриалсан.

Түүнийг ингэж уриалахад Аврагчид өгөх ёстой миний бэлэг бол илүү олон хүнтэй ярилцах явдал юм байна гэсэн өмнө мэдэрч байгаагүй хүчтэй мэдрэмж төрсөн юм. Тэр өдрийг хүртэл би огт танихгүй хүнтэй, ялангуяа орос хэл дээр яриа эхлүүлэхээс айдаг байв! Намайг



тэднийг ойлгодоггүй тэнэг гэж хүмүүс бүү бодоосой гэсэндээ юу ч хэлэхгүй байх нь илүү амар байсан юм. Гэхдээ тэр үед би яг юу хийх хэрэгтэйгээ мэдсэн. Би өөрийнхөө тухай бодохоо больж; ах, эгч, дүү нарынхаа тухай бодох хэрэгтэй болсон. Би үлдсэн нэг сарын хугацаанд нийтийн тээврийн хэрэгсэлд суух болгондоо сайн мэдээний тухай хэн нэгэнтэй ярина, үүнийгээ Аврагчид Христийн мэндэлсний баяраар өргөх бэлэг болгон зориулна гэсэн зорилго тавив.

Харт эгч бид хоёр маргааш өглөө нь Перм орох галт тэргэнд суух үед би дэргэд суусан хүмүүстэйгээ ярьж зорилгоо биелүүлж эхэлсэн юм. Тэд миний хуваалцсан зүйлийг нэг их сонирхохгүй байсан ч би юутай ч гэсэн оролдлого хийсэн шүү дээ!

Аврагчид бэлэг өргөх гэхээр өдөр бүр л хэцүү асуудалтай тулгардаг байсан ч би улам аз жаргалтай байж, номлогч байх дуудлагаа илүү сайн биелүүлж байгаа гэсэн итгэл ихээр төрж байв. Христийн мэндэлсний баяр болж өнгөрсөн ч гэлээ, би хүмүүстэй үргэлжлүүлэн ярилцсаар байв. Би зөвхөн нийтийн тээврээр явахдаа төдийгүй гудамж, дэлгүүр, номын сан гээд хаа явсан газраа тэдэнтэй ярилцаж эхэлсэн.

Бид илүү олон хүнтэй ярилцсан ч заах хүн олоогүй. Гэхдээ би сайн мэдээний үрийг суулгасан гэдгийг мэдэрдэг. Бид автобусны жолооч, амьдарч байсан газрынхаа хүнсний дэлгүүрийн хүмүүс, бас бусад хүнтэй найз нөхөд болсон. Хамгийн сайхан зүйл нь гэвэл бид тэдэнтэй дахиад тааралдах үед тэд бидэн рүү инээмсэглээд, түрүүлж мэндэлдэг байв. Тэр хүмүүст сайн мэдээний талаар суралцах шинэ боломжууд гарах үед бидний суулгасан тэр үр нэгэн өдөр цэцэглэнэ гэдэгт би итгэлтэй байдаг. Тэнгэрлэг Эцэг жижиг бөгөөд энгийн арга замаар ажилладаг. Энэ нь заримдаа жирийн нэг “сайн уу” гэж хэлэхээс эхэлж болдог.

Би Екатеринбург руу явах галт тэргэнд сууж байсан үеэ эргээд санахад Тэнгэрлэг Эцэг миний залбиралд хариулсан гэдгийг ухаарсан. Тэрээр номлолын ажил бол өөрийгөө бодохын нэр биш, харин бусдын төлөөх ажил бөгөөд бид бусдыг өөрсдөөсөө болон өөрсдийн шаналал, уй гашуугаас дээгүүрт тавих үед хайж байгаа аз жаргалаа олдог гэдгийг ухаарахад надад тусалсан юм. Миний хувьд Аврагч хэчнээн өгөөмөр гэдэг нь, ялангуяа бид чадах бүхий л зүйлээ Түүнд өгөхөөр хичээх үед Тэрээр биднийг адисалж, бидэнд хэдэн зуу дахин нугалж өгдөг гэдэг нь үнэхээр гайхалтай санагддаг. ■

Зохиогч нь АНУ-ын Айдаход амьдардаг.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДИНАРА МИРТАЛИПОВА

Итгэлээ сэргээсэн нь

Зам үргэлж дардан байдаггүй ч буцах зам байдаг.

Дэвид Диксон
Сүмийн сэтгүүлүүд

Мормоны Номонд бидний уншдагчлан "хориглогдсон замаар будилан орж мөн [төөрөх]" (1 Нифай 8:28) гэх үгс бидний ихэнхэд тийм ч найдвар төрүүлэм сонсогдохгүй байж болно. Үнэн хэрэгтээ энэ нь бүр эсрэгээр сонсогддог. Жимснээс нь хүртсэн ч орхин явсан Лихайн амьдралын модны үзэгдэлд гардаг хэсэг бүлэг хүний гунигтай төгсгөлийн тухай төсөөлөхөд маш хялбар.

Гэвч Шинэ Зеландын 17 настай Тэ Ораноа М арай өөр бодолтой явдаг аж. "Тэд үүрд мөнхөд төөрөлдсөн гэж энэ судрат хэлээгүй нь надад сүнслэг урам өгсөн" гэж тэр хэллээ.

Ямар гайхалтай ойлголт вэ! Энэ ойлголтыг тэр хувийн туршлагаараа олж авчээ. "Би Сүмээс хөндийрсөн байсан ч эргэж ирэх боломжтой байсан" гэж тэр хэллээ.

Бөхсөн нь

Ораноа Сүмд өсөж хүмүүжсэн бөгөөд гэрчлэлтэй болж, сүнслэг зорилгууд тавьж байсан тухайгаа ярив. "Гэхдээ гэрчлэл маань бөхөж эхэлсэн" гэж тэр хэллээ.

Тэр өөрийгөө зарим талаараа Амюлектэй, ялангуяа Аммонайхагийн хүмүүст өөрийгөө дүрслэн хэлсэнтэй нь адил болохыг олж мэджээ. "Би зүрх сэтгэлээ хатууруулсан, учир нь би олон удаа дуудагдсан боловч би сонсохоос татгалзсан; тиймийн тул би эдгээр зүйлүүдийн талаар мэдэж байсан боловч мэдэхийг хүсээгүй" (Алма 10:6).

Ораноагийн хувьд энэ судар маш их утга учиртай. "Амюлектэй л адил би эдгээр бүх сүнслэг зүйлийг мэдэж байсан бөгөөд Сүнс надад тодорхой зүйлсийг хийхийг зөвлөж байсан ч зөрүүд, бардам зангаасаа болоод би тэдгээрийг үйлдээгүй. Үүний дараа гэрчлэл маань бөхөж эхэлсэн."

Эцэст нь Тэ Ораноагийн хувьд Амюлекийн түүх зүгээр л нэг танил зүйлээс илүү утга учиртай болсон байна. Энэ нь буцах замдаа гарах шийдвэрлэх мөч болжээ.

Сайн сайхан дурсамжаа санах нь

Итгэл нь бөхөж байсан үед ч тэр урьдын сайн сайхан дурсамжуудаа санасаар байжээ. Ораноа өсвөр үеийнхэнтэй хамт ариун сүмд орж мөн өсвөр үеийн чуулганд явж байхдаа мэдэрсэн зүйлээ хэзээ ч мартаагүй.

"Бараг л хэвшил болчихсон байсан" гэж тэр хэллээ. "Би сүмд ирсэн үедээ сайн сайхныг мэдэрдэг байсан ч сүмд яваагүй үедээ хэцүүхэн л байдаг байв."

Эцэст нь нэгэн өдөр Тэ Ораноа тэдгээр сайхан мэдрэмжээ дахин мэдэрч чадах эсэхээ харахаар шийджээ. Тэр юуны түрүүнд хамгийн сүүлийн Ерөнхий чуулганы үгсийг уншсан байна.

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн "Алма, Амюлек хоёроос суралц" хэмээх үг Тэ Ораноагийн бодгальд ямар нэг зүйлийг өдөөжээ. Түүний амьдралын олон хэсэг ба мэдэрсэн мэдрэмжүүд ерөнхийлөгч Угдорфын Амюлекийн итгэл хэрхэн бөхсөнийг дүрсэлсэнтэй адил болохыг мэджээ. Тэр итгэлээ хүчирхэг байх үед мэдэрсэн баяр баясгалангаа урьд урьдынхаас илүү тод томруун

ДЭВСГЭР ЗУРГИЙГ GETTY IMAGES

"Та нар хүссэн цагтаа Их Эзэн рүү эргэх боломжтой."

санажээ. Тэр даруйхан өөрчлөлт хийхээр шийдсэн байна.

"Би гэрчлэлийнхээ галыг өрдөх ямар нэгэн зүйл олно гэж найдаж байсан учраас ерөнхийлөгч Угдорфын үгийг уншсан. Тийм ээ, би галаа өрдсөн."

Мөнх амьдралд найдах нь

Тэ Ораноагийн итгэл рүүгээ буцах зам үргэлж дардан байгаагүй ч хонгилын үзүүр дэх нэгэн гэрэл болох мөнхийн гэр бүлийн найдвар түүнийг авч явжээ.

"Гэр бүлүүд үүрд хамт байх болно" гэж тэр хэллээ. "Энэ бол амьдралын маань хамгийн том хүсэл мөрөөдөл, итгэл найдвар юм. Би ямар нэгэн зүйлийн талаар суралцах эсвэл ямар нэгэн ойлгоход хэцүү сургаалыг олох үедээ эдгээрийг мөнхийн гэр бүлтэй холбохыг хичээдэг. Жишээлбэл, Есүс Христийн Цагаатгал яагаад надад чухал вэ? Нэг үгээр хэлбэл, ариун сүмд орж, гэр бүлтэйгээ мөнхөд лацдан холбуулахуйц зохистой байхад Түүний Цагаатгал амьдралд маань хэрэгтэй.

Бурхан руу эргэх нь

Жимснээс нь хүртсэн ч төөрөлдөн одсон Лихайн зүүдэн дэх хүмүүс ядаж л *хүртсэн* гэдгийг санахад илүүдэхгүй байх. Тэд үүний сайн сайхныг, бүр багахан ч болов мэдсэн байх ёстой. Тиймээс тэд дахиад мэдэрч чадна. Энэ нь Тэ Ораноагийн өөрийнхөө болон бусдын талаар тээж явдаг итгэл найдвар юм.

"Та нар насан туршдаа тэр хориглогдсон замаар төөрч явах шаардлагагүй" гэж тэр хэллээ. "Та нар хүссэн цагтаа Их Эзэн рүү эргэх боломжтой." ■

Христийн мэндэлсний баярын магтуу дууны ГАЙХАМШИГ

ХУАКИНД ЗОРИУЛСАН МАГТУУ ДУУ

Аргентинд Христийн мэндэлсний баярын магтуу дууг дуулдаг уламжлал тийм ч их байдаггүй. Үнэнийг хэлэхэд, эндхийн Христийн мэндэлсний баяр та нарын төсөөлдөг цастай баярын уур амьсгалаас өөр юм. Бид дэлхийн бөмбөрцгийн өмнөд хагаст амьдардаг учраас Христийн мэндэлсний баяр *надад* үргэлж том савтай жимсний салатыг санагдуулдаг.

Аав, ээж маань магтуу дууг гэр бүлээрээ дуулаад үзэхийг зөвлөхөд хүүхдүүд бидний тэвдэх, догдлох зэрэгцэж билээ. Бид дуу хөгжмийн хэр их авьяастайгаа мэдэхгүй байсан учраас ядаж л хүмүүст инээмсэглэл бэлэглэх зорилгоор айлчилж буй хүмүүстээ жигнэмэг хийж очихоор шийдсэн юм.

Хуакин хэмээх нэгэн эрэгтэй ухаан орсон цагаас минь л тойрогт маань явдаг байв. Тэр арван хоёрдугаар сард хүндээр өвдөж, ариун ёслолд оролцох боломжгүй болсон юм. Аав, ах нар маань ням гарагт түүнд ариун ёслол хүргэхээр Сүмийн дараа эмнэлэг рүү явдаг байв.

Христийн мэндэлсний баярын өмнөх ням гарагт бид гэр бүлээрээ Христийн мэндэлсний баярын халуун дулаан уур амьсгалыг авчирна гэж найдан Хуакин руу очихоор машиндаа суусан юм. Биднийг очиход сувилагч түүний ор руу дагуулан явав. Тэр биднийг хүлээж байсан гэлтэй судруудаа дуулалын номтой хамт орон дээрээ тавьсан байв.

Тэр биднийг ирсэнд баяртай байгаа нь илт байсан бөгөөд тэр даруй бид ч бас түүнийг гэсэн хайрыг мэдэрсэн. Ах нар маань ариун ёслолыг бэлтгэж, адислан, түгээв. Бид явахаасаа өмнө "Алс тэртээ хол Иудейн нутаг хээр талд" дууллыг дуулсан. "Дээдийн дээд Хаан Бурханыг магтъя, ертөнц хүмүүс амар байг" (*Сүмийн дуулал болон хүүхдийн дуу,* х. 52).

Тэр биднийг "тэнгэр элчүүд" гэж дуудан, айлчилж ирсэнд маань талархахад бидний зүрх сэтгэлд амар амгалан, хайрын мэдрэмж төрсөн. Бид бүгд эдгээр мэдрэмжийг л түүнд авчрахыг хүссэн билээ.

Жулиа Г, Аргентин, Буэнос-Айрес

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ МАЙКЛ МУЛЛАН

БАЯСГАЛАН АВЧРАХАА ТӨСӨӨЛӨӨГҮЙ БАЙЖЭЭ.

ТЭР ОРОЙН ХАМГИЙН СҮҮЛИЙН АЙЛ

Христийн мэндэлсний баярын өмнөх өдөр байсан бөгөөд би магтуу дуу дуулахаар гарахыг *хүсэхгүй* байв.

Гэсэн ч ээж маань гэр бүлээрээ хуучин машиндаа суугаад, эргэн тойрондоо мөсөөр хучигдсан замаар яван, тойргийнхоо гурван бэлэвсэн эмэгтэйд магтуу дуу дуулж өгвөл сайхан байх болно гэж бодож, аав маань ч түүний санааг баяртайгаар дэмжсэн юм.

Надад эвгүй санагдаж байв. Хэн биднийг сонсохыг хүсэх юм бэ? Хэрэв таньдаг хүн маань тааралдвал би ичиж үхнэ ээ. Уурлаж унтууцсан би ах, эгчтэйгээ хамт хойд талын суудал руу хөлөө зөөж ядан оров.

Очих хамгийн эхний байшин хэдхэн гудамжны цаана байв. Хэн ч гарч ирсэнгүй. Бид хоёр дахь айл руугаа явлаа. Дахиад хэн ч хариулсангүй. Би баярлаж эхлэв.

Бид хамгийн сүүлийн айлынхаа нарийн гудамжаар орох үед би “Гэртээ байхгүй байгаасай” гэж бодсон юм.

Гадаа харанхуй болсон байв. Ээж маань хаалга тогшин, хүлээх үед үүдний өрөө харанхуй хэвээрээ л байв. Сайн байна. Удахгүй бид гэртээ харьж, би ч унтлагын өрөө рүүгээ ухас хийнэ дээ.

Тэгтэл удалгүй үүдний өрөөний гэрэл асаж, хаалга онгойх нь тэр. Би маш их ичиж байв. Түүнд садаа болсон гэдэгтээ би итгэлтэй байв.

“Ороод ир. Алив ээ” гэж намхан, туранхай эмэгтэй хэлэв. Тэр хуучны босоо төгөлдөр хуур руугаа заагаад,

“Та тоголдог уу?” гэж ээжээс маань асуув. “Төгөлдөр хуууртай хамт дуулцгаая.”

Түүний эелдэг байдал, урам зориг зүрх сэтгэлийг минь зөөллөв. Тэр биднийг тэнд байгаад тийм ч их дургүйцээгүй бололтой. Биднийг хэдэн дуу дуулах үед тэр халуун шоколадаар дайлав.

“Чи тусалж чадах уу?” гэж тэр надаас асуулаа. Биднийг түүний гал тогоо руу ороход, Христийн мэндэлсний баярт зориулан гайхалтай сайхан зассан гоёмсог ширээг хараад би гайхаж орхив. Үнэхээр баяр ёслолын байдалтай байлаа! Суудал бүрийн тоогоор анхааралтай боож багласан жижигхэн боодолтой зүйлс байв.

“Хэнд өгөх гэж байгаа юм бэ?” гэж би асуулаа. Тэр ганцаараа амьдардаг гэдгийг би мэдэж байв.

“Хөршүүддээ” гэж тэр хэллээ. “Христийн мэндэлсний баяр бүрээр би өөртэйгөө адил гэр бүлгүй хөрш айлын хүмүүсээ Христийн мэндэлсний баярын өглөөний унд, бяцхан зоогоор дайлдаг.”

Энэ санаа 13 настай миний сэтгэлийг догдлуулсан юм. Зөрүүд зүрх сэтгэл маань баяр бахдалаар дүүрэв. Тэр өрөө хэчнээн гоё байсан гээч! Тэр намхан настай эгч ямар үзэсгэлэнтэй байсан гэж санана! Биднийг тийшээ авч явсан ээж маань ямар хөөрхөн байсан гээч! Би ингэж нэг баярлав.

Дараагийн сар нь сүм дээр энэ эгч биднийг айлчлан ирсэнд дахин талархсан юм. Тэр жил *түүнийг* санасан цорын ганц хүмүүс бид байсныг тэр эгч бидэнд хэлж билээ. Хэдэн сарын дараа тэр гэнэт нас барав.

Би тэр нэгэн Христийн мэндэлсний баярыг эргэн санахдаа Христийн мэндэлсний баярын уур амьсгалыг бусдад авчрахыг хүссэн гайхамшигт эцэг эхдээ мөн тэр настай эгчид талархдаг юм. ■

Бруук К., АНУ, Юта

Христийн мэндэлсний баяр

НОМЛОГЧ болох ХАМГИЙН ТОХИРОМЖТОЙ ҮЕ БАЙДГИЙН НАЙМАН ШАЛТГААН

Баяр ёслолууд сайн мэдээг хуваалцах явдлыг илүү сайхан болгодог онцгой үе юм!

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ МАНУ КАЛЛЭЖОН

Шарлотт Ларкэбэл
Сүмийн сэтгүүлүүд

Та найздаа хайртай. Та сайн мэдээнд хайртай. Гэтэл та энэ хоёрыг хооронд нь хэрхэн холбохоо мэдэхгүй байна.

Хэрэв та ийм байдалд байгаа бол ганцаараа тийм биш. Олон хүн найз нөхөдтэйгөө сайн мэдээ хуваалцахыг хүсдэг ч өөрсдийгөө улайран зүтгэдэг эсвэл хачин жигтэй гэж харагдахаас эмээж байдаг. Сайн мэдээг хуваалцах гэдэг нь сэтгэл шаналгасан асуудал байж болно.

Гэхдээ хэзээ ч бүү ай! Хэдий та хэзээ ч, ямар ч хүнд Сүмийн тухай дурдаж байгаагүй бол таны энэ баярын өдрүүд жирийн, амар хялбар, бүхэлдээ хийж болох номлолын цаг мөчөөр дүүрэн байх боломжтой. Хэрхэн ийм байх вэ?

Эхний хийх зүйл бол залбирах юм. Сайн мэдээнээс хуваалцах боломжийг Тэнгэрлэг Эцэгээс гуйхыг бод. Хэнтэй ярих, хэнийг урихаа мэдэхийн тулд мөн сайн мэдээг үнэхээр хуваалцах зориг гуйн залбир.

Дараах зүйл нь хийж эхлэх явдал юм. Тэгээд *одооноос* эхэл. Нэг нууц гэвэл, Христийн мэндэлсний баяраар номлолын ажил хийхэд *маш хялбар* байдаг. Яагаад? Найман шалтгаан байна.

1. Хүн болгон сайхан үдэшлэгт дуртай.

Танай тойрог эсвэл танай гэр бүл Христийн мэндэлсний баярын үдэшлэг хийхээр төлөвлөж магадгүй. Найзуудаа хөгжилдөж баярлахаар нэгдэхэд урь. Аврагчийн тухай дуу, захиас байх боломжтой бөгөөд энэ нь найзын чинь сонсох хэрэгтэй ч зүйл байж болно.

2. Христийн мэндэлсний баяраар хүмүүсийг Сүмд урих явдал бол энгийн л зүйл.

Хүмүүсийг Сүмд явахад хүргэдэг ямар нэгэн зүйл Христийн мэндэлсний баярт байдаг. Энэ бол Сүмийн гишүүд хэрхэн Аврагчийг бишрэн шүтдэгийг найз нөхөддөө харуулах таатай цаг юм.

ЗАМЫН АЛХАМ БҮР

Би сайн мэдээг ихэд сонирхдог хөрштэйгээ ярилцаж байсан юм. Түүнийг Мючелийн арга хэмжээнд урьсан боловч ямар нэг зүйл тохиолдоод ирж чаддаггүй байв. Нэг шөнө би энэ талаар залбирдаггүй гэдгээ ухаарлаа. Тэр даруй би өвдөг сөгдөн, Ариун Сүнс надтай хамт байж, удирдаасай хэмээн хүсэж залбирсан юм. Залбирсныхаа дараа би хариу хүлээсэн ч юу ч хүлээн авсангүй. Гайхаж байсан ч, дахиад л залбирав. Ингэж залбирахдаа надад байгаа бүхий л адислалуудынх нь төлөө Бурханд талархах өдөөлтийг мэдрэв. Бас бусад хүнийг ч гэсэн өөрсдөдөө байгаа болон байж болох байсан бүх адислал нь Аврагчийн хүч чадлын ачаар байсан гэдгийг ухаарахад тусалж болохын төлөө залбирав. Хэчнээн их цаг хугацаа орох байсан ч Тэнгэр дэх Эцэг минь замын маань алхам бүрд надтай хамт байж, надад тэвчээр суулгаж, намайг илүү адислах болно гэдгийг би хүчтэй мэдэрсэн. Хэд хэдэн удаа залбирсны дараа нэг найз минь Мючелийн арга хэмжээнд надтай хамт очсон юм.

Элора К., нас 14, АНУ, Аризона

3. Христийн мэндэлсний баярын хоол, амттан бол урилга эсвэл сайн мэдээний захиасыг илүү амттай болгох төгс арга юм.

Дуртай судартайгаа хамт таваг жигнэмэг өгвөл ямар вэ? Хэдэн чихэртэй хамт Христийн мэндэлсний баярын тухай эшлэл өгвөл? Тийм шүү, сайхан санаа байна!

4. Гэр бүлүүд цуглаад хамт байх хандлагатай байдаг.

Гэр бүлийнхэнтэйгээ цагийг өнгөрүүлэх нь Христийн мэндэлсний баярын уламжлалын томоохон хэсэг учраас гэр бүл, баярын уламжлал, гэр бүлийн тухай итгэл үнэмшлийнхээ талаар ярихад хавьгүй хялбар байна.

5. Гэрлэн чимэглэл, халуун шоколадыг дэлхийн зарим газар нийтлэг ашигладаг.

Халуун шоколад уух эсвэл гэр бүлийн үдэш юмуу Мючелийн үйл ажиллагаанд зориулан Христийн мэндэлсний баярын үеэрх хотын гэрлэн чимэглэлийг явж хар. Баярын үйл ажиллагаа хүн болгонд хөгжилтэй байдаг бөгөөд шашныхаа дагуу хэрхэн амьдардгаа найздаа харуулах гайхалтай арга зам юм.

ТИЙМ Ч СҮРХИЙ САНАГДАХГҮЙ БАЙЖ БОЛОХ ЮМ

Хэсэг хугацааны өмнө Сүмийн нэг найз минь нүүгээд, би сургуулийнхаа цорын ганц Сүмийн гишүүн болсон юм. Ням гаргийн багш найзуудтайгаа хэрхэн сайн мэдээг хуваалцаж болох талаар яриад удаагүй байлаа. Би яаж үүнийг хийхээ мэдэхийн тулд залбирч, хариултаа хүлээн авсан юм. Би нэг найзтайгаа ярилцаж байхдаа болзооны талаар түүнийг ямар байр суурьтай байдаг тухай ярьж эхэлсэн. Би 16 нас хүртлээ болзоонд явахыг дэмждэггүй гэж тайлбарлатал түүний баримталдаг зарим нэг жишиг минийхтэй адил байсан тул үнэхээр гайхаж билээ. Тийм ч сүрхий санагдахгүй байж болох ч энэ нь яг миний хэд хэдэн удаагийн залбирлын хариу байсан бөгөөд залбирлын тухай миний гэрчлэл илүү хүчтэй болсон.

Дэвид С., нас 13, АНУ, Техас

6. Христийн мэндэлсний баярын Мормон захиасыг хуваалцахад гайхалтай бөгөөд хялбар байдаг.

”Аврагч мэндэллээ— Христийн мэндэлсний баярын видео бичлэг”-ийг хуваалцан, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд уг баярын уур амьсгалыг авчир! Та нарын фэйсбүүк найзуудаас хэчнээн нь аавтай үйлчлэгчид тусалсан бяцхан тэнгэр элчийг “The Reason Behind Christmas (Христийн мэндэлсний баярын далд учир шалтгаан)” видео бичлэгээс эсвэл амиа бодоогүй сайхан сэтгэлийн тухай түүхийг “The Coat: A Story of Charity (Хүрэм: Энэрэл харуулсан түүх)” видео бичлэгээс харахыг хүсэх бол? Эдгээр видео бичлэг болон Христийн мэндэлсний баярын захиасыг хуваалцахын тулд LDS.org эсвэл the Mormon Channel-аас хайна уу.

7. Христийн мэндэлсний баяр бол Аврагчийн баяр юм.

Христийн шашинтай олон хүн Христийн мэндэлсний баяраар Аврагчид илүү анхаарлаа төвлөрүүлдэг. Өдөр болгон үйлчлэл хийх санааг хуваалцахаас гадна Mormon.org сайт нь Аврагчийн сургаал болон “Дэлхийг гэрэлтүүл” арга хэмжээг илүү онцлох болно. Энэ нь найз нөхдийн тань хайж байгаа Христийн мэндэлсний баярыг тэмдэглэх арга байж болох юм.

8. Христийн мэндэлсний баяраар өгөх, үйлчлэх олон арга байдаг.

Үйлчлэх нь номлогч байх гайхамшигтай арга зам бөгөөд баярын үеэр бусдад үйлчлэх олон боломж байдаг. Та нар асрамжийн газар очих, хөршдөө Христийн мэндэлсний баярын дуу дуулж өгөх, орон нутгийн орогнох газруудад эд зүйл хандивлах зэргээр үйлчилж болно. 12-р сарын эхний 25 өдөр хэрхэн үйлчлэх талаарх санааг Mormon.org-оос авч болно.

Та юу хүлээж байна вэ?

Сайн мэдээний ачаар та Есүс Христийн тухай болон Түүний авчрах бүхий л итгэл найдварын талаар мэддэг. Энэ бол гайхамшигтай бэлэг бөгөөд энэ нь таны бусдад өгч болох бэлэг юм. Хэрэв та чин сэтгэлээсээ Тэнгэрлэг Эцэгээс сайн мэдээг хуваалцах боломж гуйвал Тэрээр хэнтэй ярилцаж болохыг мэдэх сүнслэг мэдрэмжийг өгөх болно. Христийн мэндэлсний баяр бол хуваалцах, өгөх, Есүс Христийг санах үе юм. ■

БАЯРЫН ҮЕ

“Энэ бол баярлаж баясах үе. Энэ бол Христийн мэндэлснийг тэмдэглэх ойн өдөр. Бүхнийг Чадагч Бурхан дэлхийг мөн биднийг гэтэлгэхийн тулд Төрсөн Ганц Хүү, Есүс Христийг илгээсэн гэдгийг дурсан санадаг гайхамшигтай үе юм.”

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, “Бид Христийн мэндэлсний баяраар Христийг харж чадах уу?” (Тэргүүн Зөвлөлийн Христийн мэндэлсний баярт зориулсан онцгой цугларалт, 2009 оны 12-р сарын 6), broadcasts.lds.org.

БИД БҮХЭН **ЕСҮСТ** ЗАЙ ГАРГАЖ ӨГӨХӨӨР ШИЙДДЭГ **ДЭН БУУДЛЫН ЭЗЭН** ЮМ.

Ахлагч Нийл А.Максвэлл (1926–2004), "Settle This in Your Hearts," 1992 оны 10-р сарын Ерөнхий чуулган

GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Ерөнхийлөгч
Томас С.Монсон

ХРИСТИЙН МЭНДЭЛСНИЙ БАЯРЫН ЖИНХЭНЭ УУР АМЬСГАЛЫГ ХЭРХЭН МЭДРЭХ ВЭ?

Христийн мэндэлсний баяр бол жилийн хамгийн сайхан цаг үе билээ. Энэ баяраар бидний ихэнх нь завгүй байдаг. Энэ баярын нөлөөнд хэт их автсанаар буруу зүйлсэд илүү ач холбогдол өгч, Бетлехемийн Ариун Нэгний төрөлтийг дурсан санах энгийн баяр баясгаланг мэдэлгүй бүү өнгөрөөсэй хэмээн би итгэн залбирч байна.

Христийн мэндэлсний баярын жинхэнэ баяр баясгалан нь бид илүү ихийг хийж, амжуулах гэж яаран сандарснаар ирдэггүй. **Христийн мэндэлсний баярыг Аврагчид төвлөрүүлснээр бид энэхүү баярын жинхэнэ баяр баясгаланг олох болно.**

Бид Христийн мэндэлсний баярыг тэмдэглэхдээ Аврагчийн заасан хайрыг мөн аминч бус занг харуулах хэрэгтэй. Авахаасаа илүү **өгөх нь** Христийн мэндэлсний баярын уур амьсгалыг илүү бүрэн дүүрэн авчирдаг. Бид нэг нэгэндээ **илүү сайхан сэтгэлээр** ханддаг. Мөн бид аз жаргалгүй байгаа хүмүүст хайраар хүрч, тусалдаг. Бидний **зүрх сэтгэл зөөлөрч,** дайснуудаа уучлан, найз нөхдөө дурсан санаж, Бурханд дуулгавартай байдаг. Христийн мэндэлсний баярын уур амьсгал дэлхийг өөр нүдээр харах боломж олгодог бөгөөд бид дэлхийн завгүй амьдралаа анзаарч, эд зүйл гэхээсээ хүмүүст илүү анхаарал тавьдаг. Христийн мэндэлсний баярын жинхэнэ утга учрыг ойлгохын тулд **Христийн Сүнсийг эрэлхийлэхэд** л хангалттай.

Аврагчийн өгсний адилаар бид ч бас өгөх болтугай. Өөрийгөө зориулах нь ариун нандин бэлэг юм. Аврагчийн өгсөн бүхнийг дурсан санаснаар бид ч мөн өгдөг. Бид хожим нь эвдэрдэг эсвэл мартагддаг бэлгүүдийг хүмүүст өгөхийн сацуу мөнхийн үнэ цэнтэй бэлгүүдийг ч бас өгөх болтугай. Хэрэв бид бүгд ойлголцол, энэрэл, үйлчлэл, нөхөрлөлийн мөн сайхан сэтгэл, эелдэг байдлын бэлгүүдийг бэлэглэдэг байсансан бол энэ дэлхий хэчнээн сайн сайхан байх байсан бол.

Христийн мэндэлсний баяр бүхий л сүр жавхлан, алдар суугаараа биднийг хүрээлж буй энэ цаг үед Аврагчийн төрснийг мэргэн хүмүүсийн адил тэмдэглэхэд биднийг удирдах тэрхүү гэрэлтсэн, онцгой одыг бид эрэлхийлэх болтугай. Бид энэрэл хайраар дүүрэн байж, зүрх сэтгэлээ Аврагчид бэлэг болгон өгснөөр сүнсээрээ Бетлехемийг зорин аялах болтугай. ■

2013 оны Тэргүүн Зөвлөлийн Христийн мэндэлсний баярын онцгой цугларалтаас эш татав.

Би ямар нэгэн чухал зүйлийн төлөө залбирч байгаа боловч хариултаа хүлээн авсан эсэхээ сайн мэдэхгүй байна. Би хэрхэн мэдэх вэ?

Залбирлын хариулт хүлээн авахыг үйл явц хэмээн тайлбарладаг. Эхлээд та асуултаа оюун санаандаа тунгаан бодоод, дараа нь хариулт тань зөв эсэхийг Бурханаас асуух хэрэгтэй. Хэрэв таны хариулт зөв бол Их Эзэн “чиний оюунд амар амгаланг ярих” (С ба Г 6:23) болно.

Гэвч гайхамшигт амар амгаланг мэдрэхгүй бол яах вэ? Аль эсвэл хариулт хүлээн авснаа мэдэж байгаа ч энэ нь өөрөөс тань байна уу эсвэл Ариун Сүнснээс байна уу гэдэгт эргэлзэж байвал яах вэ?

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднарын хэлснээр “Илчлэлт бага багаар нэмэгдэн ирдэг бөгөөд бидний хүсэл, зохистой байдал, бэлтгэлийн дагуу ирдэг”.[1] Энэ нь үргэлж тэр даруй ирдэггүй, ихэнхдээ “шат шатаар, дүрэм дүрмээр” (2 Нифай 28:30) өгөгддөг бөгөөд ихэнхдээ бүр бүрэн хариултаа хүлээн авлаа гэдэг мэдрэмж төрөхөөс *өмнө* аль нэг чиглэлд алхам хийх хэрэгтэй болдог. Заримдаа ямар ч хариулт хүлээн авахгүй байж болно. Ийм үед Бурхан цаг нь болохоор хариулна гэдэгт итгэн үйлдэх хэрэгтэй.

Хэрэв та хариулт тань танаас уу эсвэл Ариун Сүнснээс үү гэдэгт эргэлзэж байвал хамгийн зөв хариулт “[таныг] сайныг үйлдэхэд мөн Бурханыг хайрлахад, мөн түүнд үйлчлэхэд урьж мөн татдаг” (Моронай 7:13) гэдгийг санаарай.

ЭШЛЭЛ

1. Дэвид А.Бэднар, “Илчлэлтийн Сүнс,” 2011 оны 4-р сарын Ерөнхий чуулган.

Шийдвэрээ гаргаж, Сүнсийг хүлээ

Нэгэн зун надад чухал шийдвэрийн талаар Их Эзэн хариулт өгөхгүй байгаа юм шиг санагдсан. Би өдөр бүр Түүний хүслийг мэдэхээр чин сэтгэлээсээ залбирч байсан бөгөөд түүнд юу хүсэж байгаагаа хэлсэн. Би тодорхой хариулт хүлээн авалгүйгээр шийдвэрээ гаргаж билээ. Би тэр даруй миний гаргасан шийдвэр надад өсөж хөгжин, Тэнгэр дэх Эцэгтэйгээ илүү адилхан болоход туслах юм байна гэж Сүнс гэрчилж байгааг мэдэрсэн. Тэнгэрлэг Эцэг бидний сонгох эрх, зөв шударга хүсэл эрмэлзлийг хүндэтгэдэг учраас заримдаа бид хариулт хүлээн авахын тулд үйлдэл хийх хэрэгтэй байдаг. Хэрэв бид зохистой амьдарч байвал бидний хүсэл Түүнийхтэй нийцэж байгаа учраас Түүний Сүнс биднийг хүсэл эрмэлзэлдээ хүрэхэд хөтлөх болно.

Аманда Х., 16 настай, АНУ, Юта

Тэвчээртэй мөн гярхай бай

Хэсэг хугацааны өмнө би үйлчлэх боломжуудын төлөө залбирахад өөрийгөө уриалсан. Би бусдад туслах арга замуудын тухай бодож байсан ч өдөөлт гэж мэдэрсэн хариултыг хүлээн аваагүй юм. Намайг сэтгэлээр унасан байхад ээж маань “Сайн бүхэн Бурханаас ирдэг” хэмээх Алма 5:40-ийг хуваалцсан. Надад төрсөн үйлчлэлийн тухай намуухан бодлууд үнэндээ Ариун Сүнсний өдөөлт байсныг би

Эдгээр хариулт тусламж, ойлголт өгөх зорилготой бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.

мэдсэн. Бидний залбирал үргэлж хариулагддаг гэдгийг би мэднэ. Бид зүгээр л тэвчээртэй, дуулгавартай байж, Их Эзэнд итгэх ёстой.

Либий Б, 16 настай, АНУ, Орегон

Сүнсэнд итгэ

Та нар Ариун Сүнсэнд итгэж суран, Тэнгэрлэг Эцэгийн хариулдаг арга замыг таних чадвараа хөгжүүлснээр Сүнс та нарт ямар их туслах боломжтойг ойлгох болно. Түүний дуу хоолой биднийг их намуун зөөлнөөр урамшуулан зоригжуулдаг. Бид дэлхийн зүйлстэй хэт зууралдан завгүй байгаад байвал дээрээс ирэх шивнээ, мэдрэмжийг анзаарахгүй өнгөрөөх болно. Хэрэв бид явах ёстой замаараа явбал зүрх сэтгэлдээ Сүнсний бидэнд юу гэж хэлж байгааг мэдэх амлалтыг үргэлж хүлээн авч байх болно.

Рибэйро эгч, 24 настай, Бразилийн Порто Алегрэ Өмнөд Номлол

Тусламж гуйн залбир

Би олон удаа залбирч, хариултаа хүлээн авч байсан ч хичээл сургуультай холбоотой туршлагууд маань надад хамгийн гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн. Шалгалтаас өмнө би тайван байж, судалсан мэдээллээ санахын төлөө залбирсан. Олон удаа би Бурханы тусламжгүйгээр хэзээ ч санахгүй гэдгээ мэдэж байсан мэдээллээ догол мөр бүрээр нь санаж байлаа. Тэр миний амьдралыг маш их адисалсан бөгөөд би залбирлын хүчийг мөн үүгээр дамжин ирдэг Түүний нөлөөг үнэлдэг.

Эмили Б., 18 настай, Австрали, Квийнслэнд

Оролдоод үз, тэгээд хар!

Заримдаа бүрэн хариултаа хүлээн авахаасаа өмнө итгэлээрээ үйлдэхийг Их Эзэн биднээс шаарддаг. Та нар мэргэн ухааны үг нь үнэхээр Бурханаас ирсэн зарлиг мөн эсэх талаар мэдэхийг хүсэж байна уу? Тэгвэл үүнийг дага! Та нар Мормоны Ном үнэн эсэхийг мэдэхийг хүсэж байна уу? Тэгвэл унш! Иохан 7:17 дээрх "Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсэж байвал тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү, эсвэл Би Өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ" хэмээх амлалтад итгэ.

Прэстон О, 19 настай, АНУ, Юта

Христийн хүчээр

Намайг ахлагч Расбанд, Оскарсон эгч хоёрын нүүр тулсан уулзалт нэвтрүүлгийг үзэж байх үед нэгэн өсвөр үеийн хүүхэд хариулт хүлээн авах талаарх яг энэ асуултыг тавьсан юм. Оскарсон эгч "Христийн хүч болон бэлгээр . . . та нар энэ нь Бурханаас гэдгийг төгс мэдлэгээр мэдэж болно" хэмээх Моронай 7:16-г эш татсан. Бид Бурханы биднээс юу хүсэж байгааг төгс мэдлэгээр мэдэх боломжтой гэдгийг энэ судар харуулж байна. Сүнсийг мэдэр, тэгээд хариултаа мэдэх болно.

Сара С, 17 настай, Бразил, Санта Катарина



СҮНСЛЭГ ӨДӨӨЛТ БАГА БАГААР ИРДЭГ

"Бид шийдвэр гаргахад туслах сүнслэг өдөөлтийг эрэлхийлэх үед Их Эзэн намуун зөөлөн өдөөлтүүдийг өгдөг. Эдгээр нь биднээс бодож тунгаан, итгэлээ хөгжүүлж, хөдөлмөрлөж, тэмцэхийг мөн үйлдэл хийхийг шаарддаг. Цөөхөн тохиолдолд л нэн чухал шийдвэр, ярвигтай асуудлын бүх хариулт нэг дор ирдэг. Ихэнх тохиолдолд энэ нь бага багаар, төгсгөл нь харагдахгүйгээр ирдэг."

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт (1928–2015), "Learning to Recognize Answers to Prayer," 1989 оны 10-р сарын Ерөнхий чуулган.

ДАРААГИЙН АСУУЛТ

"Заримдаа надад Аврагчийн хайрыг хүртэх эрхгүй юм шиг санагддаг. Би хэрхэн энэ мэдрэмжээ орхиж, өөрийнхөө үнэ цэнийг мэдрэх вэ?"

Хэрэв хүсвэл хариултаа өндөр нягтралтай зургийн хамт liahona.lds.org хаягаар ("Өгүүлэл оруулах" дээр дар) 2018 оны 1-р сарын 15-ны дотор илгээнэ үү.

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлаж магадгүй.

БИДНИЙ ОРОН ЗАЙ

ШИНЭ НАЙЗУУДТАЙ БОЛОХ НЬ

Гэр бүлээрээ нүүх гэж байгаа гэж эцэг эхийгээ дуулгахад шинэ найз нөхөдтэй болох нь гээд сэтгэл минь маш их догдолж билээ. Бид шинэ хотод нүүж ирээд, Сүмдээ явав. Би тэнд Сүнсийг маш хүчтэй мэдэрсэн бөгөөд бүх зүйл сайхан болно гэдгийг мэдсэн.

Удалгүй шинэ сургуульд явж эхлэв. Би сургууль дээрээ ганцаараа мормон байсан юм. Сургуульд явж ороход л тэнд байх ёсгүй юм шиг санагдаж билээ. Би бусад хүүхдээс өөр байсан.

Эхний долоо хоног, дараа нь ч гэсэн би найз нөхөдтэй болох гэж хичээв. Гэтэл надад тун эвгүй санагдав. Хичээл бүр дээр өөр хүмүүсийн хажууд сууж, өдөр болгон өөр өөр ширээн дээр үдийн хоолоо идэж байх гэж хичээсэн ч нэг их өөрчлөлт гарахгүй байгаа мэт байлаа.

Тэгээд үеийнхэндээ сайн үлгэр жишээ байхаар хичээж чармайя гэж шийдсэн юм. Би Хувийн хөгжил дэвшил болоод судраа шаргуу судлахад анхаарлаа төвлөрүүлэв. Би хичээх тусам өөрийгөө Бурханы охин гэдгийг мөн Түүнийг надад хайртай гэдгийг илүү сайн ойлгож ухаарч байлаа.

Цаг хугацаа өнгөрч, хийе гэж бодсон зүйлээ үргэлжлүүлэн хийж байтал сургууль дээрээ найз нөхөдтэй болж байгаагаа анзаарч эхэлсэн юм. Хүмүүс надад татагдаж байгаа юм шиг санагдав. Намайг бусдаас огт өөр гэдгийг тэд хэлж байв. Энэ нь гэрлээ гэрэлтүүлснээс болсон гэдгийг би ойлгосон. Би ангийнхнаасаа өөр байдлаар биеэ авч явж, даруухан хувцаслан, зөв үгээр ярьж, бусдад сайхан сэтгэлээр хандаж байсан.

Бид бүгд Бурханы хүүхэд. Надад хэдий тэнд байхад тохирохгүй мэт санагддаг байсан ч гэрлээ гэрэлтүүлсэндээ маш их талархаж явдаг. Бид Их Эзэний талд байвал хэзээ ч ганцаардахгүй гэдгийг би мэднэ. ■

Рэбэка К., Принц Эдвард арал, Канад

БИ МОРМОНЫ НОМЫГ ХУВААЛЦАЖ ЧАДАХ БОЛОВ УУ?

Мючелийн арга хэмжээний үеэр бидэнд нэг хамтрагч олоод, Сүмийн гишүүн бус хүнд гэрчлэлээ хуваалцах, гишүүн бус найздаа Мормоны Номын нэг хувийг өгөх зэргээр номлогч болох даалгавар өгсөн.

Тэр арга хэмжээний дараа би ээжээсээ зөвлөгөө авав. Хэрэв би итгэлээр Тэнгэрлэг Эцэгт хандан залбирвал Тэр миний залбиралд заавал хариулна гэж ээж маань амласан юм.

Мормоны Ном хүлээн авах хүн олоход хоёр долоо хоног болов. Эхлээд хүмүүс олон удаа татгалздаг байв. Би гомдохоос залхаж байсан бөгөөд бараг л бууж өгөх гэж байлаа.

Нэг шөнө би манай гэр бүлийн дотны найз нэг эмэгтэйг зүүдэлж, зүүдэндээ түүнийг хамтрагч бид хоёрын очих ёстой хүн гэж ойлгов. Би сэрэнгүүт надад тусалсных нь төлөө Их Эзэнд талархаж билээ.

Дараагийн Мючелийн арга хэмжээний үеэр хамтрагч бид хоёр Мормоны Номын эхний хуудсан дээр гэрчлэлээ бичээд, тэр эмэгтэйд зориулан жимсний сагс хийв. Бид эмэгтэйн гэр рүү очоод, хаалгыг нь тогшин, хүлээж байлаа. Татгалзах байх даа гэж дотроо айж байсан ч бага ч гэсэн итгэлтэй байх хэрэгтэй гэж өөртөө хэлсэн юм. Эцэст нь эмэгтэй инээмсэглэсээр гарч ирээд, Мормоны Номыг хүлээн авав.

Бага ч гэсэн итгэлтэй байж, Тэнгэрлэг Эцэг бидний төлөө байдаг гэдгийг мэдэх үед боломжгүй зүйл ч боломжтой болдог гэсэн мэдрэмжийг хялбархан мэдэрч чадна гэдгийг би энэ туршлагаас ойлгож авсан. ■

Америкийн Самоа, Рапунзэл Л.,

ТӨГӨЛДӨР ХУУРЫН СУРГАЛТААСАА АМРАЛТ АВСАН МИНЬ

Би нэг долоо хоног төгөлдөр хуур давтахгүй амралтаа авна гэдгээ зарлая гэж шийдэв. Намайг ингэж амарна гэдгийг төгөлдөр хуурын багш ч, ээж ч зөвшөөрсөнгүй. Бүтэн долоо хоногийн турш давтлага хийсэнгүй өнгөрөв. Надад амрах, өөр бас бус зүйл хийх цаг гарсан учраас сайхан байна гэж би бодож байлаа.

Маргааш өглөө нь төгөлдөр хуурын давтлагатай гэж ээжийг сануулахад миний тэр сайхан баяр пүрэв гаргийн орой дуусгавар болов. Цагийн өмнө эрт босоод, давтах арга байна гэж би боддоо. Гэтэл миний гаргасан хичээл зүтгэл тун өчүүхэн бас оройтсон гэдгийг би ухаарав. Би сонгох эрх чөлөөгөө эдэлж байсан ч гарах үр дагаврын талаар эргэцүүлж бодоогүй байжээ.

Маргааш өглөө нь төгөлдөр хуурынхаа багштай уулзахад үр дагавар нь гарч эхэллээ. Би давтаагүй гэдгээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болсон бөгөөд багш тогтмол хийдэг давтлагаас гадна хийгээгүй давтлагаа нөхөж хийх хэрэгтэй хэмээн хэлэв.

Сонгох эрх, үүрэг хариуцлага, үүрэг хүлээх зэргийн талаар ойлгож авах болсон тэрхүү сургамжинд би талархдаг. Сонголт болгонд үр дагавар байдаг бөгөөд хэрэв би цаг гарган үр дагаврынх нь талаар эхлээд эргэцүүлэн бодвол илүү сайн шийдвэр гаргах болно гэдгийг ойлгож авсан. ■

Блэйк Х., АНУ, Юта

ОДОО ТАНЫ ЭЭЛЖ

Лиахона таныг туршлага, шинэ сэргэг ойлголтуудаа илгээнэ үү хэмээн урьж байна. Танд дуртай судар байгаа юу? Залбирлынхаа хариуг хүлээн авсан уу? Сайн мэдээний дагуу амьдрах зориг байгаа гэдгээ харуулсан уу? Та бидэн рүү liahona.lds.org вэбсайтаар түүхээ илгээнэ үү ("Submit an Article or Feedback" дээр дар).

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ НАСАН ХАРДКАСТЛ

Христийн мэндэлсний баярын өмнөх орой ирсэн гийчин

Энэ орой жилийн хамгийн сайхан үдэш болдог. Гэтэл одоо балрах гээд байна!

Холли К.Вортингтон
Бодит түүхээс сэдэвлэв

"Sing the carols of the Christ child: Let your neighbors know you care" (Children's Songbook, *51*).

Кларад Христийн мэндэлсний баярын өмнөх оройн тогтсон уламжлал сайхан санагддаг байв. Тэд эхлээд оройн хоолондоо шарсан загас, баярын жигнэмэг иддэг байж. Дараа нь тэд баярт зориулан нээгдсэн зах руу явдаг байв. Гэртээ ирээд тэд Библиэс Христийн мэндэлсний баярын холбогдолтой түүх уншдаг. Унтахаасаа өмнө гацуур модныхоо гэрлийг асаан, бие биендээ өгсөн бэлгээ задалдаг. Энэ орой Кларагийн хувьд жилийн хамгийн сайхан үдэш болдог. Тэрээр

"Энэ жил бид баярын өмнөх өдөр нэгэн онцгой гийчинтэй байна.

Хатагтай Рэйнэрийг санаж байна уу?" хэмээн ээжийгээ хэлэх хүртэл сэтгэл догдлон хүлээж байв.

Клара дотроо дургүй байв. "Өнгөрсөн долоо хоногт аавын Сүмд урьсан хөрш үү?"

"Тийм ээ, тэр хүн. Аав нь түүнийг одоо гэрээс нь авч байгаа."

Клара сандал дээрээ падхийтэл суув. Гэрт гадны хүн байхад яаж амарч, цагийг сайхан өнгөрүүлж чадах вэ дээ? Христийн мэндэлсний баярын өмнөх орой нурлаа! Аав хатагтай Рэйнэрийг Сүмд урихад тэр ирээгүй. Энэ удаа ч тэр ирэхгүй байж магад.

Гэхдээ аав хаалгаар орж ирэхэд тэр нэгэн "онцгой гийчин" аавтай цуг ирсэн юм. Хатагтай Рэйнэр ядарсан шинжтэй, гунигтай харагдав. Клара мэндлэхээс өөр юу ч хэлэхийг хүссэнгүй. Оройн хоолны үеэр Клара ээж, аавыгаа хатагтай Рэйнэртэй ярилцаж байх хооронд хоолоо л анхаарч байв.

"Бүжгийн сургалтад явж байсан уу? гэж хатагтай Рэйнэр зөөлөн дуугаар асуугаад, Клараг хариулахыг хүлээж байгааг нь тэр харав. Тэр толгой дохиод, таваг руугаа харцаа буулгав.

“Би ч гэсэн” гэж хатагтай Рэйнэр хэлэхдээ дуу нь бас л зөөлөн байв. “Чи ямар бүжигт дуртай вэ?”

Клара мөрөө хавчаад, тавагтай хоолныхоо ногоог түлхэв.

“Би балетад дуртай. Би их сургуулийнхаа балетын хамтлагт байсан. Нэг жил бид Европоор аялсан нь үнэхээр гайхалтай байж билээ” гэж хатагтай Рэйнэр хэлэв.

Клара дээш харав. Энэ нь гайхалтай сонсогдож байлаа.

“Та өөр юунд дуртай вэ?” гэж Клараг асуухад хатагтай Рэйнэр нүүр дүүрэн инээмсэглэв. “Төгөлдөр хуур тоглох дуртай. Бас математикт дуртай” гэж түүнийг хариулахад

Кларагийн нүд томров. “Тийм үү? Математик миний дуртай хичээл.”

Клара оройн хоолны үлдсэн цагийг хатагтай Рэйнэртэй ярилцаж өнгөрүүлэв. Тэрээр хатагтай Рэйнэрийг их сургуульд математикаар суралцсан ба математикийн профессор болохоор суралцаж байхдаа нөхөртэйгөө танилцсан гэдгийг мэдэж авав. Нөхөр нь зарим нэг муу сонголт хийсэн учраас шоронд орсон байжээ.

Оройн хоолны дараа Клара хатагтай Рэйнэрийн дэргэд үлдэн, түүнтэй хамт захаар явав. Тэднийг Христийн мэндэлсний баяртай холбогдолтой түүх уншиж байхад Клара хатагтай Рэйнэртэй хамт судраасаа уншиж байв.

Удалгүй бэлгээ задлах цаг боллоо. Клара нил ягаан өнгөтэй, биед эвтэйхэн унтлагын хувцас бэлгэнд авав. Тэр шинэ унтлагын хувцсаа өмсөх гэж яарч байлаа. Гэтэл хатагтай Рэйнэрт бэлэг байхгүй гэж санахад түүнд эвгүй байв.

Тэгтэл ээж нь хатагтай Рэйнэрт бэлэг өглөө. Хатагтай Рэйнэр ичингүйрэн инээмсэглээд, боодолтой бэлгээ задлан, хар хөх энгийн оймс гаргаж ирэв. Тэрээр нулимстай нүдээр ээж рүү нь харснаа “Баярлалаа. Та надад юм өгөх хэрэггүй дээ” гэв.

Клара унтлагын өрөө рүүгээ ороод, унтлагын хувцсаа өмслөө. Хатагтай Рэйнэрийн тухай бодол түүнээс салахгүй байв. Тэр Христийн мэндэлсний баяраар оймс бэлгэнд авсандаа их талархаж байх шиг санагдсан.

Клара үслэг оймсоо өмсөж байхдаа сайхан аялгуутай хөгжим эгшиглэж эхлэхийг сонсов. Тэрээр хатагтай Рэйнэрийн төгөлдөр хуурын аялгуунд дуулж байсан аав, ээж рүүгээ шатаар уруудан гүйж очоод, тэр хоёртой цуг дуулав. Дуулж байхдаа зүрх сэтгэлдээ дулаан мэдрэмж мэдрэв. “Христийн мэндэлсний баярын өмнөх орой зочин гийчинтэй байх ч муугүй юм байна” гэж түүнд бодогдов.

Ням гарагт хатагтай Рэйнэр сүмд ирээд, ариун ёслолын үеэр Кларагийн гэр бүлийнхний хажууд суусан юм. Тэр маш их баяртай байгаа харагдав. Клара хатагтай Рэйнэртэй хамт Сүмийн дууллын номноос харж дуулахдаа инээмсэглэв. Христийн мэндэлсний баярын тогтсон уламжлал дээрээ шинэ зүйл нэмэх цаг болсон байж магадгүй юм шүү. ■

Зохиогч нь АНУ-ын Айдахоод амьдардаг.

Би ганцаараа амьдардаг хөршийндөө зочилж очих, зургийг нь зурж өгөх зэргээр хайраа үзүүлдэг.

Жилл К., 10 настай, АНУ, Калифорни

Далын
**Ахлагч
Пол Б.Пийпэр**

Зориг гарган, ХУВААЛЦ!

Гэр бүл маань дэлхийн олон газарт амьдарч байсан. Бидэнд олон янзын хүмүүстэй уулзаж, сайн мэдээг хуваалцах хэд хэдэн боломж байсан. Мөн хүүхдүүд маань гэрчлэлээ хуваалцсанаар бусдыг адисалж байсан.

Хүүхдүүдээ бага байхад бид Казакстанд амьдардаг байлаа. Тэр үед тэнд ямар ч номлогч байгаагүй. Найз нөхөд, хөршүүд маань сайн мэдээг сонсохыг хүсвэл *бид* номлогч болох ёстой болдог байв.

Охин Марнэ маань найз Алёнатайгаа сайн мэдээг хуваалцсан юм. Алёна ээжийнхээ зөвшөөрлөөр баптисм хүртэхээр шийдсэн бөгөөд хожим ээж нь ч бас дүүтэй нь хамт баптисм хүртсэн. Саяхан Алёна Нью-Йоркийн Манхэттэн ариун сүмд зөв шударга эрэгтэйтэй гэрлэсэн бөгөөд Марнэ тэнд байх боломжтой байсан. Тэр найздаа Есүс Христийн тухай мэдэхэд нь тусалсандаа маш их баяртай байв.

Биднийг АНУ-ын Виржиниад амьдарч байхад хүү Крис маань Хүүхдийн хэсэгт явдаг байв. Крисийн нэг найз, гэр бүлийнхээ хамтаар номлогчидтой уулзаж эхэлсэн бөгөөд Крис гэр бүлд нь заахад тусалсан. Тэр хичээл бүрийн өмнө бэлтгэлээ базаан, тэдний асуултад хариулахад тусалдаг байв. Тэр гэр бүл баптисм хүртэхээр шийдсэн. Үүний дараа Крис номлолд үйлчилж чадах эсэхтээ дахин эргэлзэхээ больсон юм. Тэр хийж чадна гэдгээ мэдэж байсан.

Өөр нэгэн удаа нэгэн эрэгтэй байшинг маань засах гэж ирсэн бөгөөд ажлаа дуусгасных нь дараа эхнэр маань түүнд талархан, "Бид танд бэлэг өгмөөр байна" гэж хэлж билээ. Тэр түүнд Мормоны Номыг өгөхөд тэр эрэгтэй сэтгэл дундуур байв. Тэр бидний юунд итгэдгийг ойлгоогүй бөгөөд биднийг Есүс Христэд итгэдэггүй гэж бодож байж.

Крис зориг гарган, гэрчлэлээ түүнтэй хуваалцсан юм. Крис өөрийгөө Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн ба Есүс Христэд итгэдэг гэж хэлсэн.

Тэнгэрлэг Эцэгийн олон хүүхэд сайн мэдээний тухай мэддэггүй. Бусад нь биднийг Есүст итгэдэг гэдгийг ойлгодоггүй. Энэ хүмүүст өөрсдөд нь сайхан хандаж, ярилцах хүн хэрэгтэй байдаг. Бид зориг гарган, гэрчлэлээ хуваалцаж чадна. Бид бусдад Есүс Христийн тухай мэдэхэд тусалж чадна. ■

Сүм өнөөдөр

Сүмийн түүхийн талаар хуваалцахдаа эдгээр түүхийг ашигла.





Ерөнхийлөгч Монсон

Гэгээнтнүүд Солт Лэйкийн хөндийд нэгэн үзэсгэлэнт хотыг байгуулсан бөгөөд Солт Лэйк ариун сүмийг 40 жилийн турш барьжээ. Тэр эртний цаг үеэс хойш Сүм маш ихээр өсөж хөгжсөн. Өнөөдөр дэлхий даяар баригдаж дууссан 156 ариун сүм байгаа бөгөөд Мормоны Ном 110 хэл рүү орчуулагдсан байна. Ерөнхийлөгч Томас С.Монсон өнөө үе дэх бидний бошиглогч юм. Сүм үргэлжлэн өсөж хөгжихөд та хэрхэн тусалж чадах вэ?

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БЭТ М.ВИТТАКЕР

Танд энэ жилийн Сүмийн түүхэн дэх онцгой хүмүүс цуврал таалагдсан гэдэгт бид найдаж байна. Та өнгөрсөн удаагийн мэдээллийг liahona.lds.org-оос авна уу.

УЛААН тасалбар

Яана аа! Даниэл дахиад л нэг тасалбар алдчихлаа.



Дарси Жэнсэн Моррис
Бодит түүхээс сэдэвлэв

*"Би сайн, эелдэг байх үедээ мөн тааралдсан хүндээ туслах үедээ маш их аз жаргалтай байдаг" (*Children's Songbook, *197).*

Матэо самбар дээрх тооны бодлого руу хараад, дэвтэртээ хурдхан гэгч тэмдэглэн авч байв. Тооны хичээл түүний дуртай хичээл учраас тэр анхааралтай байхыг хүсэж байлаа. Гэвч найз Даниэл нь яриад байсан учраас хатагтай Сантосыг сайн сонсож чадахгүй байв.

"Чшшш! Даниэл би сонсож чадахгүй байна!" гэж Матэо шивнэлээ. Даниэл ярьсаар л байв. Эцэст нь хатагтай Сантос түүнийг сонсоод,

"Даниэл, чи дахиад л саад боллоо" гэж хэллээ. "Чи аль хэдийн анхааруулга авсан байгаа. Одоо тасалбараа надад өгөх болж дээ."

Даниэл аажуухан түүний ширээ рүү очоод, тасалбараа өгөв. Тэр мөрөө унжуулан, шал ширтэв. Хатагтай Сантос дуулгавартай байж, дүрэм журам дагасан сурагчдад тасалбар өгдөг байв. Сурагчид өдөр бүр тасалбар дээр нэрээ бичээд, шилэнд хийдэг байлаа. Гэхдээ хэрэв чи дуулгаваргүй байвал тасалбараа буцаагаад өгнө. Баасан гараг бүр хатагтай Сантос

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЖОН МАНДЭРС

шилнээс тасалбарыг гаргаж ирдэг бөгөөд ялагч ангийн шагналын хайрцагнаас шагналаа сонгож авдаг байсан. Даниэл ярьсныхаа төлөө олон удаа тасалбараа буцааж өгч байсан учраас нэр нь бараг л сонгогддоггүй байв. Даниэл дахиад нэг тасалбараа алдаж байгаад Матэо сэтгэл дундуур байв.

Матэо завсарлагааны цагаар хөл бөмбөг тоглохоор талбай руу гүйлээ. Даниэл савлуурын хажууд ганцаараа зогсож байгааг тэр харав. Даниэл уйлж байгаа нь илт байлаа. Матэо түүнд тайтгарахад нь туслахыг хүсэв.

"Чи хөл бөмбөг тоглохыг хүсэж байна уу?" гэж Матэо асуухад,

Даниэл юу ч хэлсэнгүй. Матэо дахиад яриа өдөхийг оролдсон ч Даниэл буруу харав.

"За за, боддоо өөрчилбөл хүрээд ирээрэй. Би хөл бөмбөг тоглож байя."

Матэо өөр найзуудтайгаа тоглохоор явсан ч Даниэлийн тухай бодсоор байв. Матэо удахгүй найман нас хүрч, баптисм хүртэх гэж байлаа. Тэр Есүстэй адил байж, сайн найз байхыг хүсэж байв. Тэр Даниэлд асуудалд орохгүй байхад нь туслах ямар нэгэн зүйлийг хийж чадах болов уу?

Дараагийн өдөр нь анги жижиг бүлгүүдэд хуваагдан, түүх уншиж байв. Даниэл уншихын оронд номоо дээшээ шидлэв.

Матэо түүнийг болиулахыг оролдлоо. "Даниэл, бид номоо унших хэрэгтэй. Тоглож болохгүй."

Даниэл дахиад л номоо шидэв. Хатагтай Сантос түүний ном бараг л таазанд хүрэх гэж байгааг хараад, Даниэл руу очин, тасалбарыг нь авах гэж гараа сунгав. Даниэл ширээн дээрээ очив. Тэр тасалбараа хайх зуур маш их айж сандарсан байлаа.

"Үгүй байлгүй дээ! Түүний тасалбарууд дуусах нь!" гэж Матэо бодлоо. Тасалбаргүй болно гэдэг нь Даниэл завсарлагаанаар гарахгүй гэсэн үг. Матэогийн толгой маш хурдан ажиллаж эхлэв. Тэр юу хийж чадах вэ? Түүнд нэгэн сайхан санаа төрөв.

Хатагтай Сантос "Даниэл, надад тасалбараа өгөхгүй бол" гэж хэлэхэд

Матэо гүнзгий амьсгаа аван, "Би түүний өмнөөс өгч болох уу, хатагтай Сантос" гэж асуулаа.

Анги чимээгүй болов. Хэн ч урьд нь түүнээс ингэж асууж байсангүй. Матэо түүнийг юу гэж хариулахыг мэдэхгүй байлаа.

Хатагтай Сантос гайхсан байдалтай харагдсан ч инээмсэглээд, "Чи маш сайн найз байна. Тийм ээ, чи Даниэлийн өмнөөс тасалбараа өгч болно" гэж хэлэв. Матэо хатагтай Сантост нэг тасалбараа өглөө.

Даниэл "Баярлалаа, Матэо" гэхэд,

"Зүгээрээ" гэж Матэо хэллээ. "Чи одоо хамт уншмаар байна уу?"

Даниэл толгой дохин, номоо авав.

Даниэлийг уншиж эхлэхэд Матэод халуун дулаан, сайхан мэдрэмж төрөв. Энэ сайхан санаа Ариун Сүнснээс ирсэн юм. Есүс Даниэлд хайртай учраас өөрөөс нь Даниэлд туслахыг хүссэн гэдгийг Матэо мэдэж байв. Матэо ч мөн адил Есүсийн хайрыг мэдэрлээ. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЕСҮС БИДНИЙ ТӨЛӨӨСИЙГ ТӨЛСӨН

Матэо Даниэлд санаа тавьдаг учраас тасалбараа өмнөөс нь өгсөн. Бид хэн нэгний гэм нүглийн төлөөсийг төлж чадахгүй ч Есүс Христ чадна! Есүс бидэнд хайртай учраас бидний бүх нүглийн төлөөсийг төлсөн. Бид ямар нэгэн буруу зүйл хийсэн бол наманчилж, өршөөгдөж чадна. Есүс бидэнд илүү сайн байхад тусалж чадна.

Би наманчилснаар хэрхэн аз жаргалыг мэдрэх боломжтой вэ?

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Дэйл Г.Рэнланд

Жинхэнэ наманчлал бол зүрх сэтгэл болон хүслээ Бурхан руу хандуулж, нүглээ орхих явдал юм.

Есүс Христ бидний үйлдсэн нүглийн төлөөсийг төлсөн учраас уучилж өршөөдөг. Тэр бидэнд хайртай учраас уучилж өршөөхийг хүсдэг.

Бид наманчлахыг сонгох үед Тэр баяр баясгалантай байдаг.

Тэр биднийг өршөөхөд бид бас баяр хөөртэй байж чадна.

“Наманчлал: Баяр хөөр авчрах сонголт,” 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган, *121–124.*

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДИЛЛИЙН МАРШ

Галт оч цацруулагч



Ахлагч Дэйл Г.Рэнландыг 12 настай байхад гэр бүл нь Шведэд амьдардаг байжээ. Нэгэн ням гарагт Дэйлийн найз Стефан том галт оч цацруулагчийг шүдэнзний хамт Сүмийн байранд авчирчээ. Дэйлийн сэтгэл хөдөлсөн байлаа. Дэйл шүдэнз зурж оч цацруулагчийг асаав. Тэр асаагуур утсыг дарж унтраах гэсэн боловч хуруугаа түлээд, оч цацруулагчийг газар унагачихжээ. Дэйл, Стефан хоёр асаагуур утас шатахыг харан айж балмагдан зогслоо.

Галт оч цацруулагч дэлбэрч, хурц үнэр Сүмийн байраар тархав. Дэйл, Стефан хоёр оч цацруулагчийн үлдэгдлийг түүгээд, үнэрийг нь гаргах гэж цонх онгойлгожээ. Тэд хэн ч анзаарахгүй байх гэж найдлаа.

Хүмүүс ариун ёслолын цуглаанд ирээд, *анзаарсан* юм. Үнэр маш хурц байсан учраас хүмүүс цуглаанд анхаарлаа хандуулж чадахгүй байв. Дэйл маш их ичиж, санаа нь зовжээ. Түүний хийсэн зүйлд Тэнгэрлэг Эцэг сэтгэл дундуур байсан гэдгийг тэр мэдэж байв.

Сүмийн дараа салбарын ерөнхийлөгч Линдберг ямар нэгэн зүйл болохгүй байгааг хэлэхээр Дэйлийг өрөөндөө дууджээ. Дэйл оч цацруулагчийн талаар маш их харамсаж байгаагаа ерөнхийлөгч Линдбергт хэлэв.

Ерөнхийлөгч Линдберг эелдэг хүн байсан. Тэр судраа нээгээд, Дэйлээс доогуур нь зурсан хэдэн шүлгийг уншиж өгөхийг хүсэв. Дэйл “Болгоогтун, нүглүүдээ наманчилсан тэрээр, мөнхүү тэр нь өршөөгддөг ажгуу, мөн Их Эзэн, бибээр тэдгээрийг нь цаашид санах нь үгүй. Хүн нүглүүдээ наманчилдаг эсэхийг та нар үүгээр нь мэдэж болно—болгоогтун, тэрээр тэдгээрийг хүлээж мөн орхих болно” (С ба Г 58:42–43) гэж уншлаа.

Тэр уншиж дуусаад, ерөнхийлөгч Линдбергийн инээмсэглэхийг харав. Ерөнхийлөгч түүний уучлагдсан болохыг мэдэрчээ. Дэйл өрөөнөөс гарахдаа баяртай байлаа.

Ахлагч Рэнланд ямар нэгэн буруу зүйл хийсэн бол өршөөгдөж болно гэдгийг сурсан юм. Тэр наманчилж, Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг дагасан үедээ аз жаргалтай байдаг байв. ■



12-р сарын 11
“Намайг харь хүн байтал урьж оруулсан” (Матай 25:35).

12-р сарын 12
“Гашуудаж буй хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд тайвшрал авах болно” (Матай 5:4).

12-р сарын 13
“Тиймээс та нар хүмүүсийг өөрсдөдөө хэрхэн хандаасай гэж хүссэнээрээ л өөрсдөө ч тийнхүү тэдэнд ханд.” (Матай 7:12).

12-р сарын 14
“Шүүгдэхгүйн тулд чи бүү шүү” (Матай 7:1).

12-р сарын 15
“Энэрэнгүй хүмүүс ерөөлтэй еэ!” (Матай 5:7).

12-р сарын 16
“Нүцгэн байхад минь Намайг хувцасласан” (Матай 25:36).

12-р сарын 17
“Та нар ойр ойрхон цуглан уулзацгаах болно” (3 Нифай 18:22).

12-р сарын 18
“Та нар үргэлж сэрэмжилж мөн залбирах ёстой” (3 Нифай 18:15).

12-р сарын 19
“Баярлацгаа, мөн баяр хөөртэй байцгаа” (Матай 5:12).

12-р сарын 20
“Харин Бурханы хаанчлалыг хайгтун” (Лук 12:31).

12-р сарын 21
“Хүмүүсийн алдааг уучил” (Матай 6:14).

12-р сарын 25
“Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг” (Матай 5:16).

12-р сарын 22
“Учир нь миний хийснийг та нар харсан, бүр түүнийг та нар хийх болно” (3 Нифай 27:21).

12-р сарын 23
“Өвчтэй байхад минь Намайг та нар эргэж байсан” (Матай 25:36).

12-р сарын 24
“Миний гэр бол залбирлын гэр гэж нэрлэгдэх болно гэж бичигдсэн байдаг” (Матай 21:13).

Өдөр бүр Есүсийн заасан зүйлээс уншаад, Түүний сургаалыг хэрхэн дагахаа тунгаан бод. Дараа нь оддыг буд.

Ирэх жил бид дэлхий даяарх хүүхдүүдийн одыг цуглуулан авах болно. Бидэнд одоо илгээгээд, хэрхэн гэрэлтэх жишээ болсон тухайгаа бичээрэй. Хэрэв гэрэл зураг байгаа бол илгээхээ бүү мартаарай. Тэдгээрийг liahona.lds.org руу илгээгээрэй.

GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Есүсийн сургаал

12-р сард Есүс Христийн сургаалын тухай илүү дэлгэрэнгүйг Mormon.org-оос олж аваарай!

Энэхүү үйл ажиллагааны эхний арван өдрийг liahona.lds.org вэбсайт дээрх нийтлэлийн цахим хувилбараас мөн Gospel Library программаас олж авч болно.

Түүнд зай гарга

Үгийг Ларри Хиллер
Аяыг Майкл Ф.Муди

Намуухнаар ♩ = 76–84



Зохиогчийн эрхийг © 2017 Ларри Хиллер, Майкл Ф.Муди нар эзэмшинэ.
Энэхүү дууг арилжааны бус зорилгоор Сүмийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан олшруулж болно.
Олшруулсан хуудас бүрд энэ мэдэгдлийг оруулна уу.

БИДНИЙ ХУУДАС

Бид ариун сүмийн бидний амьдрал, гэр бүл дэх ач холбогдлын талаар ярилцсан. Бид гэр бүлээрээ ариун сүмүүдийг дуурайлгаж хийсэн.

Бразилийн Сан Пауло дахь тойргийн Хүүхдийн хэсгийн хүүхдүүд

Бид амралтаараа далайн эрэг рүү явж, элсэн дээр ЗС бамбайг зурсан.

София, Матиас, Томас О, Аргентин



Би гэрийн даалгавраа хийхэд нь дүү нартаа тусалснаар тэднийг хайрладгаа байнга харуулдаг. Инээмсэглэж бай!

Бэнжамин С, 11 настай, Кени

БҮХНИЙГ ЧАДАГЧ

Хүн бүр өөрсдөөсөө
“Бүхнийг Чадагч гэж хэн юм бэ?”
гэж асуудаг.
Олон хүн үүнийг мэдэхгүй.
Тэд Түүнийг бяцхан хүүхдүүдийн
нүднээс хардаг гэдгээ мэддэггүй.
Та нар хүнгэнэх шивнээг
сонсохдоо,
Хатан зоригтны зүрх сэтгэлээс,
Хайртай хүмүүсийнхээ инээмсэглэлээс Түүнийг олж хардаг.
Та нар Түүнийг зөвхөн “Бурхан,”
“Бүхнийг Чадагч” гэж нэрлэдэггүй.
Харин Түүнийг . . . “Тэнгэрлэг
Эцэг минь” гэж дууддаг.

Адриана Г, 9 настай, Чили

Есүс Бетлехемд төрөв

Ким Вэбб Рэйд

Нэгэн өдөр тэнгэр элч Мариа дээр ирж, Бурхан түүний өмнөөс баяртай байна гэж хэлэв. Тэрээр Есүсийн эх болох гэж байв.



Мариа, Иосеф хоёр Бетлехем рүү аялжээ. Энэ үед Есүс төрөх дөхсөн байлаа. Маш олон хүн Бетлехем руу очиж байсан учраас Мариа, Иосеф хоёр хоноглох газар олж чадахгүй байв. Дэн буудлын эзэн тэднийг малын хашаанд байрлахыг зөвшөөрчээ.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

Удалгүй Есүс төрөв. Дэлхийн гэрэл газар дэлхий дээр ирлээ гэдгийг хүн болгонд хэлэх шинэ од тэнгэрт үзэгдлээ.

Тэнгэр элч Есүсийг төрсөн хэмээн зарим хоньчинд ярьжээ. Тэд малын тэвшинд хэвтэж байгаа Есүс хүүг харахаар яаран очив.

Есүс надад хайртай учраас энэ дэлхийд ирсэн. Би энэ Христийн мэндэлсний баяраар мөн бүтэн жилийн турш Түүний гэрлийг дагах болно! ■

Лук 1:26–38; 2:1–20-оос тус тус авав



“[Хоньчид] яаран ирж, Мариа, Иосеф болон тэжээлийн тэвшин дотор хэвтэж буй Хүүг олж очив” (Лук 2:16).

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

Сүмийн анхны ерөнхийлөгч
Иосеф Смит (1805–1844)

ХРИСТИЙН ҮЙЛ ХЭРЭГТ БААТАРЛАГ БАЙХ НЬ

Та нар арван хуруу тэгш байж чадахгүй

Би бол ариун журам, ариун явдал, биеэ зохистой авч явах болон цэвэр ариун амьдралын хэв маягийн талаарх Христийн зорилгыг хайрлан хүндэтгэдэг хүн.

Би Бурханы өмнө ариун журамтай, зөв шударга, цэвэр ариун амьдрахад итгэдэг бөгөөд ийнхүү үйлдэхийг бүх хүнд эрх мэдлийнхээ хүрээнд сэнхрүүлэн итгүүлэхийг өөрийн үүрэг гэж үзнэ. Ингэснээр тэд нүгэл хилэнцийг орхиж, сайныг үйлдэж суран, зөв шударгыг үйлдсэнээр нүглээсээ салж чадна.

Бид адислагдсан Есүсийн хүүхдүүдийг гоён чимдэг аливаа сайн чанар бүрийг авч, итгэлээ бэхжүүлэн мөн үүний шагнал тэнгэрийн хаант улсад илүү агуу байна гэдгийг мэдсэнээр залбирах цаг болоход залбирч, хөршөө өөрийнхөө адил хайрлан, гай зовлон тохиолдоход итгэлтэй байж чадна. Ямар агуу тайтгарал, ямар гайхалтай баяр баясал вэ дээ! Зөв шударгыг үйлдэгчдийн амьдрал надад байх болтугай,

бас миний шагнал түүнийх шиг байх болтугай! . . .

Хүмүүний авралыг асар их хүсдэг хүний хувьд би, ариун журам, цэвэр ариун байдал, Их Эзэний зарлигуудыг дагахын төлөө бурханлаг хичээл зүтгэлээр чармайн ажиллахыг та бүгдэд сануулж байна. Сайн санаатай, ухаан сийрэг, үнэнч шударга, чөлөөтэй бай. Бүхнээс илүүгээр энэрэнгүй байж, сайн үйлсээр үргэлж бялхаж яв.

Номхон дөлгөөн, шулуун шударга, цэвэр ариун байгтун. Хилэнцийг сайн үйлсээр хариул. . . . Амьдралын бүх нөхцөл байдалд тэвчээртэй, даруухан бай. Тэгвэл бид бүр ч цог жавхлантайгаар ялалтад хүрэх болно.

Бид ах нарыгаа [мөн эгч нарыг] даруухан бөгөөд залбирдаг байж, энэ үеийнхээ гэрлийн хүүхдүүд шиг явахыг зоригтойгоор уриалан дуудаж байна. Ингэснээр бидний Их Эзэн Есүс Христийн зохих нэрээр аливаа уруу таталтыг тэсвэрлэн, нүгэл хилэнц бүрийг даван туулах ач ивээл тэдэнд байх болно.

Хүн бүр жимсний цэцэрлэгт хичээл зүтгэл гарган, шаргуу хөдөлмөрлөснийхөө дагуу хүлээн авах ёстойг тунгаан бодох нь баярт мэдээний үйлчлэгч хэмээн нэрлэгддэг хүн бүрд авьяасаа хөгжүүлж, улмаар авьяас чадвартай болоход нь бусдад сүнслэгээр нөлөөлөх ёстой.

Бидний итгэл Бурханд оршдог бөгөөд бид селестиел алдар суугийн титмээр титэмлэгдэж, Бурханы хүүхдүүдэд бэлтгэсэн амралтад орохын тулд, итгэлтнүүд төгсгөлийг хүртэл тэвчиж, зорилгоо хадгалан үлдэхэд Түүний нигүүлсэл бидэнд тусална гэдэгт бид бат итгэдэг.

Та нар арван хуруу тэгш байж чадахгүй. Тэвчээр бол тэнгэрлэг, дуулгавартай байдал бол эрхэмлүүштэй, уучлал нь нигүүлсэнгүй мөн өргөмжлөл бол бурханлаг юм. Иймээс эцсийг хүртэл итгэлтэйгээр тэвчсэн хүн шагналаа алдахгүй. Сайн хүн бодгалиа аврахын тулд . . . Христийн төлөө бүх зүйлийг тэвчих болно. ■

Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит *(2011), 352–356.*

***ЕСҮСИЙГ АРИУН СҮМД ТАНИЛЦУУЛСАН НЬ,* ХРИСТИН ДАЛСГААРД**

"Эзэн, Та Өөрийн үгийн дагуу боол намайгаа амар тайван явуултугай.

Учир нь Миний нүд Таны авралыг харлаа.

Та үүнийг бүх ард түмний өмнө бэлдсэн билээ.

Энэ нь харь үндэстэнд илчлэлийн гэрэл, Таны ард түмэн болох Израилийн алдар нь болой."

Лук 2:29–32; мөн 25–35-р шүлгийг үзнэ үү.

Мөн энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Аврагчид өргөх миний **бэлэг**

Надад номлогч байхад тохирохгүй мэт санагдаж байлаа. Тэгээд би зөвхөн өөрийгөө л гэж боддогоо больж, Аврагчид анхаарлаа төвлөрүүлж эхлэх хэрэгтэйгээ ойлгосон юм.

48-р хуудас

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

54-р хуудас

Христийн мэндэлсний баяр **номлогч** болох **хамгийн тохиромжтой үе** байдгийн найман шалтгаан

Сайн мэдээг найз нөхөдтэйгөө хуваалцахыг хүсдэг байсан уу? Гэхдээ та яаж хуваалцахаа мэдэхгүй байна уу? Энэ дугаарт яагаад Христийн мэндэлсний баяр нь номлогч байхад хамгийн хялбар үе байдаг тухай өгүүлэл байгаа.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Есүсийн сургаал

Энэ сард Христийн мэндэлсний баярыг тэмдэглэхэд бэлдэхийн тулд Есүсийн сургаалыг дагах эдгээр гурван одыг ашигла.

72-р хуудас

MONGOLIAN
4 02144 52363 4

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ